Хүн амын орчин үеийн тооллогын түүх харьцангуй богино боловч аливаа улс үндэстнүүд хүн амаа бүртгэн тоолж байсан нэлээд эртний уламжлалтай. Цэрэг дайчилгаа болон албан татвар хураах зорилгоор хүн амаа тоолдог байсан тухай олон орны түүхийн эх сурвалжид тэмдэглэн үлдээсэн байдаг.

Монгол Улс хүн амын бүртгэлийг нэн эртнээс явуулж, XIII зуунаас эхлэн хүн амаа тоолж байсан тухай сурвалж бичигт тэмдэглэсэн боловч хэдий хэмжээний газар нутгийг хамарч, хэдэн онд бүртгэл, тооллого явуулж, хэчнээн хүн тоологдож байсан талаар тэр үеийн түүхэн тодорхой баримт хараахан олдоогүй байна. Харин түүхийн төв архивын эх сурвалжаас үзэхэд 1789 онд Түшээт хан аймгийн Ахай гүний хошуу (Одоогийн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум) хүн ам, малын тоо бүртгэлийг явуулжээ. Түүний дараа 1854 онд Түшээт хан аймгийн арван хошуу нэг жилийн дотор хүн ам, малаа тоолсон баримт байна. Энэ мэтчилэн 1789-1919 он хүртэлх 130 жилд Монгол Улсын 4 аймгийн хошууд давхардсан тоогоор 80 удаа хүн ам, малын бүртгэл, тооллого явуулжээ. Манай улсын хүн амын бүртгэлийн нэг онцлог бол хүн амаа тоолохын зэрэгцээ малынхаа тоог хамт бүртгэж, тоолж байжээ. Ийм төрлийн бүртгэлийг 1940 оныг хүртэл явуулж байлаа.

Дэлхийн улс орон орчин үед явагдаж байгаа хүн амын тооллогыг 200-гаад жилийн тэртээгээс тодорхой давтамжтайгаар, нэгдсэн хөтөлбөрөөр явуулж, үр дүнг нь албан ёсоор нэгтгэн гаргаж иржээ. Монгол Улсад хүн амын тооллого ХХ зууныг хүртэл тогтмол явагдаж байгаагүй бөгөөд ХХ зууны анхны тооллого 1918 онд явагдсан байна. Дараа нь 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010 онуудад ээлжит тооллогыг явуулав. Үүний зэрэгцээгээр 1947, 1950 онуудад хүн амын тооллого шиг нэг удаагийн бүртгэл хийсэн байдаг.

Хүн амын 1956 оны тооллогыг Улсын төлөвлөгөөний комиссын Тоо бүртгэлийн хэлтсээс эрхлэн явуулсан нь аргачлал, хөтөлбөрийн хувьд нэлээд боловсронгуй болсон байжээ. Монгол Улсад статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны бие даасан байгууллага 1960 онд байгуулагдаж, 1963 оны тооллогоос эхлэн тус байгууллага хүн ам, орон сууцны тооллогыг эрхлэн явуулж ирэв. Статистикийн байгууллага тооллогыг эрхлэн явуулж эхэлснээр тооллогын асуулга, хөтөлбөр, заавар, аргачлалыг олон улсын нийтлэг жишиг аргачлалтай нийцүүлэн боловсруулж, баталж, мөрдүүлэх, тооллогын дүнг нэгтгэн боловсруулахад орчин үеийн техник, технологи ашиглах болсон байна. Эдийн Засгийн Харилцан Тусалцах Зөвлөлийн аргачлалын дагуу 1969, 1979, 1989 оны тооллогыг явуулсан, ба энэхүү аргачлал нь НҮБ-ын зөвлөмжтэй нийцэж байв. Монгол Улс 1969 оноос хүн ам, орон сууцны тооллогыг 10 жилийн давтамжтайгаар, улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1960 онд тусад нь 1969, 1979, 1989 онуудад хүн амын тооллоготой ижил хугацаанд явуулж байлаа.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого нь өмнөх тооллогоос ихээхэн онцлогтой байв. Энэхүү тооллого нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байх үед явуулсан анхны тооллого болсон ба тооллогод ашиглагдах ойлголт, тодорхойлолт, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг шинэчлэн өөрчлөх шаардлага гарсан. НҮБ-аас удаа дараа гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, завлэмж”-ийг 2000 оны тооллогод анх удаа, уг зөвлөмжийн 2008 онд өргөжүүлэн шинэчилсэн хоёр дахь хувилбарыг 2010 оны тооллогод удирдлага болгосон нь олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн аргачлалтай тооллого болгосон юм.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОНЦЛОГ

Тооллого явуулах хууль, эрх зүйн бусад үндсийг бүрдүүлсэн нь

Хүн амын тооллого явуулах хууль, эрх зүйн бусад үндсийг бүрдүүлэх нь тооллого явуулах үндсэн баталгаа юм. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оноос өмнөх бүх тооллогыг “Хүн амын тооллого явуулах тухай” Засгийн газрын шийдвэрээр зохицуулж ирсэн юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын бэлтгэл ажлыг Үндэсний статистикийн хороо 2006 оноос эрчимжүүлсэн. Хүн ам, орон сууцны тооллогын тухай тусгай хуультай болох талаар өмнөх тооллогын явцад яригдаж байв. Хуулийн анхны төсөл боловсруулах ажлыг 2006 оноос эхлэн, хэд хэдэн ажлын хэсэг байгуулан ажиллуулж, эцэст нь УИХ-ын гишүүн Ц.Баярсайханаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан.

Улсын Их Хурал 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” Монгол Улсын хуулийг баталсан. Энэ бол түүхэн чухал шийдвэр байлаа. Энэхүү хуулиар тооллого явуулах эрх зүйн болоод эдийн засгийн баталгааг хангаж, тооллого явуулах хугацаа, арга, зохион байгуулах байгууллага, институт, төрийн байгууллага, засаг захиргааны нэгжийн удирдлага болон хувь хүний тооллогод оролцох үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллоготой холбогдсон эрх зүйн акт:

Монгол Улсын хууль:

- “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль;
- “Статистикийн тухай” хууль, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;

Монгол Улсын Их Хурлын тогтоолууд:

- “Улсын комисс байгуулах тухай”
2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 19 дүгээр тогтоол;
- “Тооллогын тов тогтоох тухай”
2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 18 дугаар тогтоол;
- “Тооллогын тов өөрчлөн тогтоох тухай”
2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 88 дугаар тогтоол;

Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын тогтоолууд:

- “Тооллогын комисс байгуулах тухай”
2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогын байр зүйн зураглалын тухай”
2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоол;
- “Үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай”
2009 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр тогтоол;
- “Тооллогын тов өөрчлөх, Улсын комиссын бүрэлдэхүүний тухай”
2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоол;
- “Тооллогын мэдээлэл боловсруулалтын тооцооллын тухай”
2011 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үндсэн үр дүнгийн тухай”
2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол;

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалууд:

- “Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын мастер төлөвлөгөө батлах тухай”
2008 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/139 дүгээр тушаал;
- “Бэлэгдэл /эмблем/-ийн эх загвар батлах тухай”
2008 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/177 дугаар тушаал;
- “Техникийн ажлын хэсэг байгуулах тухай”
2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 01/28 дугаар тушаал;
- “Тооллогын асуулга, нэгтгэлийн маягт, түүнийг нөхөх заавар батлах тухай”
2009 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/135 дугаар тушаал;

Энэ тушаалаар баталсан маягт, зааврууд:

- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга
(Маягт ХАОСТ-1)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын явцын мэдээ-1
(Маягт ХАОСТ-4)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын явцын мэдээ-2
(Маягт ХАОСТ-5)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нөхөгдсөн асуулгыг хүлээлцэх баримт
(Маягт ХАОСТ-6)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын урьдчилсан дүн-1
(Маягт ХАОСТ-7)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын урьдчилсан дүн-2
(Маягт ХАОСТ-8)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын урьдчилсан дүн-3
(Маягт ХАОСТ-9)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод зарцуулсан зардлын тайлан-1
(Маягт ХАОСТ-10)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод зарцуулсан зардлын тайлан-2
(Маягт ХАОСТ-11)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга нөхөх заавар
- “Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн тооллогын комиссын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах тухай”
2010 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/33 дугаар тушаал;
- “Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллогод ашиглах газрын зургийн агуулга, загварыг батлах тухай”
2010 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/56 дугаар тушаал;
- “Монгол Улсын баг, хороодын код батлах тухай”
Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын хамтарсан 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/62, 226, 58 дугаар тушаал

- “Маягт нөхөх заавар батлах тухай”

2010 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/101 дүгээр тушаал;

Энэ тушаалаар баталсан маягтууд:

- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэл
(Маягт ХАОСТ-3)
- Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын хяналтын тооллогын асуулга
(Маягт ХАОСТ-2)

- “Хяналтын тооллого явуулах үзэл баримтлал батлах тухай”

2010 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 01/118 дугаар тушаал

- “Маягт, заавар батлах тухай”

2010 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01/127 дугаар тушаал;

Энэ тушаалаар баталсан заавар, маягт:

- Тооллогод иргэдийг урьдчилан хамруулах заавар
- Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийг тоолох интернэт тооллогын асуулга
(Маягт ХАОСТ-1.2)

ТООЛЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Хүн ам, орон сууцны улсын тооллого нь Үндэсний статистикийн хорооны зохион байгуулж явуулдаг улсын хэмжээний хамгийн том үйл ажиллагаа юм. Тооллогын үйл ажиллагааны онцлог нь засаг захиргааны хамгийн бага нэгжээс төр засгийн дээд төвшний бүх байгууллага, ард иргэдийг нийтэд нь хамруулан өргөн цар хүрээтэй, нарийн нягт зохион байгуулалттай явуулдагт оршино. Тооллогын бэлтгэл ажлыг сайн зохион байгуулах удирдлагын багийг бүрдүүлж, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг 2010 оны улсын тооллого бүрэн хангасан.

Тооллогыг амжилттай явуулах чухал урьдчилсан нөхцөл нь үйл ажиллагаа бүрийг бүрэн хамарч, оновчтой төлөвлөх асуудал байдаг. Тооллогын үйл ажиллагааг үе шатаар нь урьдчилан сайтар бодож гүйцэтгэх, хугацаа, зардал, гарах үр дүнг үндэслэлтэй тооцсон төлөвлөгөө шаардлагатай болдог. Ялангуяа, тооллогын бэлтгэл ажлын зохион байгуулалт, сургалт, тоолох ажиллагаа, мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ, тооллогын үнэлгээ болон тооллогын үр дүнг хэрэглэгчдэд хүргэх зэрэг бүхий л үе шатны ажлыг төлөвлөгөөнд тусгах учиртай.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын өмнөх тооллогуудад байгаагүй нэг үйл ажиллагаа бол НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр тооллого явуулах арга, аргачлал, удирдлага, зохион байгуулалт, үе шат, төсвийн асуудлыг цогцоор нь тусгасан мастер төлөвлөгөө боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 01/139 дүгээр тушаалаар баталж мөрдсөн явдал байв.

Тооллогын бэлтгэл хангах 41 зүйл заалтыг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг Улсын комиссын 2008 оны 4 дүгээр сарын 17-ны анхдугаар хуралдаанаар баталж, мөрдөж хэрэгжүүлсэн. Түүнчлэн, Мастер төлөвлөгөө, Улсын комиссоос баталсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг нарийвчлан 226 үйл ажиллагаа бүхий дэлгэрэнгүй график төлөвлөгөө боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 01/138 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн.

ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2008 оны 19 дүгээр тогтоолоор тооллогыг удирдан зохион байгуулах Улсын комиссыг батлав. Уг комиссын бүрэлдэхүүнд:

Комиссын дарга:

Монгол Улсын Ерөнхий Сайд

Комиссын орлогч дарга:

Үндэсний статистикийн хорооны дарга

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга

Комиссын гишүүд:

Гадаад харилцааны сайд

Сангийн сайд

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Батлан хамгаалахын сайд

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

Эрүүл мэндийн сайд

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Цагдаагийн ерөнхий газрын дарга

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нар орсон.

Тооллогын Улсын комиссыг байгуулахын зэрэгцээ тооллогын бүтэц, зохион байгуулалтыг орон даяар бий болгох шаардлага гарсан. “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн хоёрт заасныг үндэслэн “Тооллогын комисс байгуулах тухай” Улсын комиссын 2009 оны 02 дугаар тогтоолоор ГХЯ, ХЗДХЯ, БХЯ болон бүх аймаг, нийслэлд тооллого зохион байгуулах чиг үүрэг бүхий комиссыг тухайн шатны Засаг даргаар ахлуулан байгуулсан.

Аймаг, нийслэлийн тооллогын комисс тухайн шатны түр товчоо, сум, дүүргийн тооллогын комиссыг, сум, дүүргийн тооллогын комисс тухайн шатны болон баг, хорооны түр товчоог, төрийн захиргааны төв байгууллагын тооллогын комисс харьяа байгууллагуудад салбар комисс, түр товчоодыг байгуулж ажиллуулсан. Тооллогын бүх шатны комисс нь хариуцсан засаг захиргааны нэгжийн хэмжээнд тооллогыг удирдан зохион байгуулж, шаардагдах хөрөнгө, хүн хүч, байр, унаа, шатахуунаар хангах, тооллогын ажилтныг сургаж бэлтгэх, бүрэн хамралттай явуулах, дүнг нэгтгэн тушаах үндсэн үүрэгтэйгээр ажиллав.

Тооллогын түр товчоог яамдын төвшинд төрийн нарийн бичгийн дарга, төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, аймаг, нийслэлийн төвшинд статистикийн хэлтсийн дарга, сум, дүүргийн төвшинд Засаг даргын орлогчоор ахлуулж, Статистик, бүртгэл, мэдээллийн газар, хэлтсийн болон тамгын газрын гүйцэтгэх ажилтны голлох бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсан. Тооллогын түр товчоод нь тооллогын комиссын удирдлагын дор тооллогын бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах, тооллогын явцын мэдээг гаргах, хяналтын тооллого явуулах, тооллогын баримт бичиг, урьдчилсан дүнг шалгаж хүлээн авах, түүнийг тухайн төвшинд нэгтгэн дүгнэж, дээд шатны тооллогын комисст хүлээлгэн өгөх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэв.

УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

КОМИССЫН ДАРГА



С.БАТБОЛД
Монгол Улсын Ерөнхий Сайд

КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА НАР



С.МЭНДСАЙХАН
Үндэсний статистикийн
хорооны дарга



Ч.ХҮРЭЛБААТАР
Засгийн газрын хэрэг
эрхлэх газрын дарга

КОМИССЫН ГИШҮҮД



Г.ЗАНДАНШАТАР
Гадаад харилцааны сайд



С.БАЯРЦОГТ
Сангийн сайд



Ц.НЯМДОРЖ
Хууль зүй, дотоод хэргийн сайд



Л.БОЛД
Батлан хамгаалахын сайд



Ё.ОТГОНБАЯР
Боловсрол, соёл, шинжлэх
ухааны сайд



Х.БАТТУЛГА
Зам, тээвэр, барилга, хот
байгуулалтын сайд



Т.ГАНДИ
Нийгмийн хамгаалал,
хөдөлмөрийн сайд



С.ЛАМБАА
Эрүүл мэндийн
сайд



Г.МӨНХБАЯР
Нийслэлийн Засаг дарга,
Улаанбаатар хотын
захирагч, Нийслэлийн
тооллогын комиссын дарга



Д.САНДАГ-ОЧИР
Цагдаагийн ерөнхий
газрын дарга



Л.МӨНХБААТАР
Улсын бүртгэлийн ерөнхий
газрын дарга



А.АМАРБАЛ
ҮСХ-ны Хүн ам, орон
сууцны тооллогын
товчооны дарга, Комиссын
нарийн бичгийн дарга

АЙМГИЙН КОМИССЫН ДАРГА НАР



Ё.БААТАРБИЛЭГ
Архангай аймгийн
Засаг дарга



С.ХАВАЛ
Баян-Өлгий аймгийн
Засаг дарга



Д.АМАРСАНАА
Баянхонгор аймгийн
Засаг дарга



М.ОЮУНБАТ
Булган аймгийн
Засаг дарга



Ш.АМГАЛАНБАЯР
Говь-Алтай аймгийн
Засаг дарга



П.ГАНХУЯГ
Дорноговь аймгийн
Засаг дарга



Ц.ЖАНЛАВ
Дорнод аймгийн
Засаг дарга



Д.ЧАНДМАНЬ
Дундговь аймгийн
Засаг дарга



Я.САНЖМЯТАВ
Завхан аймгийн
Засаг дарга



Д.ТОГТОХСҮРЭН
Өвөрхангай аймгийн
Засаг дарга



Б.БАДРАА
Өмнөговь аймгийн
Засаг дарга



Ж.БАТСУУРЬ
Сүхбаатар аймгийн
Засаг дарга



Ж.ЭРДЭНЭБАТ
Сэлэнгэ аймгийн
Засаг дарга



Ц.ЭНХБАТ
Төв аймгийн
Засаг дарга



Э.ЦАСЧИХЭР
Увс аймгийн
Засаг дарга



Г.НЯМДАВАА
Ховд аймгийн
Засаг дарга



Л.ЦЭРЭНЖАВ
Хөвсгөл аймгийн
Засаг дарга



Ч.ЭРДЭНЭБААТАР
Хэнтий аймгийн
Засаг дарга



Г.ЭРДЭНЭБАТ
Дархан-Уул аймгийн
Засаг дарга



Д.ОЮУНБАТ
Орхон аймгийн
Засаг дарга



Ж.БАЯНМӨНХ
Говьсүмбэр аймгийн
Засаг дарга

ГХЯ, ХЗДХЯ, БХЯ хуульд заасан чиг үүргийнхээ дагуу тооллогыг хамрах хүрээндээ амжилттай зохион байгуулсан.

ЗУРАГ 1.1 ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН УДИРДЛАГА,
 ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИСС		
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО		
НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН КОМИСС	1	АЙМГИЙН ТООЛЛОГЫН КОМИСС
НИЙСЛЭЛИЙН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО	1	АЙМГИЙН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО
		ЯАМДЫН ТООЛЛОГЫН КОМИСС
		ЯАМНЫ ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО
ДҮҮРГИЙН ТООЛЛОГЫН КОМИСС	9	СУМЫН ТООЛЛОГЫН КОМИСС
ДҮҮРГИЙН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО	9	СУМЫН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО
ХОРООНЫ ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО	132	БАГИЙН ТООЛЛОГЫН ТҮР ТОВЧОО
ШАЛГАГЧ	ШАЛГАГЧ	ШАЛГАГЧ
ТООЛОГЧ	ТООЛОГЧ	ТООЛОГЧ

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ОНЦЛОГ

Тооллогын тухай тусгай хуулийн хүрээнд зохион байгуулж явуулсан анхны тооллого

Зах зээлийн нөхцөлд тооллогын талаарх төрийн захиргааны төв байгууллагууд болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага хоорондын харилцааг зохицуулах, тооллогын төсвийг бүрдүүлж, эдийн засгийн баталгааг хангах, ард иргэдийн тооллогод хамрагдах эрх, үүргийг хуулиар зохицуулах болон мэргэжлийн, байнгын үйл ажиллагаатай бүтцийг бий болгож, тооллого хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах зайлшгүй шаардлага өмнөх тооллогуудын туршлагаас бий болсон. Анх удаа Улсын Их Хурлаас “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” Монгол Улсын хуулийг 2008 онд баталж хэрэгжүүлсэн.

Гадаадад удаан хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдээ интернэтээр тоолсон анхны тооллого

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 1-ийн 4 дэх заалтыг хэрэгжүүлэх хамгийн өртөг багатай арга зам нь харилцаа холбооны технологийг тооллогод ашиглах явдал байв. Тиймээс гадаадад 6, түүнээс дээш сараар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн мэдээллийг цуглуулах программ хангамж, техник, нууцлалын асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, иргэдээ интернэтээр тоолсон.

Газарзүйн мэдээллийн систем ашигласан анхны тооллого

Дэлхийн олон орон газарзүйн мэдээллийн системийг тооллогын төлөвлөлт, тоолох ажиллагаа, үр дүнг тархаахад түгээмэл ашиглаж байна. Тиймээс тооллогын үр дүнгийн хэрэглээг нэмэгдүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, судалгааны байгууллага, судлаачид болон олон нийтэд мэдээллийг хамгийн энгийн, ойлгомжтой тархаах зорилгоор газарзүйн мэдээллийн системийг үүсгэж ашигласан.

Монгол Улсын түүхэнд тооллогын товыг өөрчилсөн анхны тооллого

Хүн амын дунд 2009 оны 10 дугаар сараас тархаж, нийтийг хамарсан А хүрээний H1N1 вирус халдварын улмаас Засгийн газраас хөл хорио тогтоосонтой холбогдуулан “Тооллогын тов тогтоох тухай” Улсын Их Хурлын 2008 оны 18 дугаар тогтоолын хугацаанд тооллого явуулах боломжгүй болсон. Иймээс тооллогын товыг “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 8 дугаар үйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн “Тооллогын тов өөрчлөн тогтоох тухай” 88 дугаар тогтоолоор өөрчлөн тогтоосон.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТОВЧООНЫ АЖИЛТНУУДЫН ЧАДАВХ

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тушаалаар ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын бүрэлдэхүүнд байнгын үйл ажиллагаатай Хүн ам, орон сууцны тооллогын товчоо (ХАОСТТ)-г байгуулж ажиллуулсан юм.

Тус товчоо нь “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллогын асуулга, бусад дагалдах маягтууд, хэрэглэх ойлголт, тодорхойлолт, тэдгээрийг нөхөх заавар, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх аргачилсан заавар, зөвлөмж боловсруулж батлуулах, бүх шатны комисс болон түр товчоодын ажлын удирдамжийг бэлтгэх, тооллогыг үндсэн нэгжид зохион байгуулж явуулахад заавар, зөвлөгөө өгөх, тооллогын ажилтнуудыг сургах, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ажилтнуудын 46.7 хувь нь хүн ам зүйч мэргэжилтэй, бусад нь мэдээллийн технологи, газарзүй, эдийн засгийн дээд боловсролтой. Товчооны ажилтны бүрэлдэхүүн дэх хүн ам зүйчдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогуудынхаас өндөр байлаа.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын бэлтгэл ажил, тооллогын үр дүнг гаргах, газарзүйн мэдээллийн системийг ашиглахтай холбоотой сэдвүүдээр гадаадад сургалт семинарт оролцох, туршлага судлах зэргээр ХАОСТТ-ны ажилтнуудын чадавхийг бэхжүүлсэн. Газарзүйн мэдээллийн системээр БНХАУ-ын Хонгконг, АНУ-ын Сан-Диего, Денвер, Рэдландс хотуудад давхардсан тоогоор 12 хүн, хүн ам, орон сууцны тооллогын

төлөвлөлт, мэдээлэл тархаалт болон холбогдох бусад асуудлаар БНХАУ-ын Хонгконг, Австрийн Вена, Туркийн Анкара, Австралийн Канбера, Японы Токио, Тайландын Бангкок хотуудад давхардсан тоогоор 13 хүн, хяналтын тооллого, тооллогын мэдээлэл боловсруулах технологийн асуудлаар Тайландын Бангкок, Австралийн Канбера, ОХУ-ын Новосибирск хотод давхардсан тоогоор 6 хүн, тооллогын туршлага судлах сургалтад ОХУ-ын Улаан-Үд, Москва хотуудад давхардсан тоогоор 6 хүн явж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлжээ.

ХАОСТТ-ны ажилтнуудыг гадаадад явуулж мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхийн зэрэгцээ НҮБ-ын Хүн амын сан, Австралийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн шугамаар ҮСХ-нд гадаадын мэргэжилтнүүд ирж, хамтран ажилласан нь тэдний чадавхийг бэхжүүлэхэд нөлөө үзүүлсэн. Ялангуяа, энэ удаагийн тооллогод газарзүйн мэдээллийн системийг үүсгэж ашиглах асуудлаар гадаадын мэргэжилтний туршлага, мэдлэг чухал байлаа. НҮБ-ын Хүн амын сангийн шугамаар газарзүйн мэдээллийн чиглэлийн мэргэжилтэн Вижнанд Дюрк Лангераар 2008 онд 2 удаа, Владко Роланд 2010 онд, Кати Илустре 2011 онд ирж ажилласан. Мөн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийг интернэтээр тоолох ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхтэй холбоотойгоор олон улсын зөвлөх Виктор Каналес 2010 онд ирж ажилласан.

Австралийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн шугамаар тооллогын төлөвлөлт, зохион байгуулалтын асуудлаар Австрали Улсын статистикийн товчооны ажилтан Андриу Хэндэрсон, Пэта Вилкокс, тооллогын үнэлгээ, хяналтын тооллогын асуудлаар Карен МкЛеннан нар ирж, ХАОСТТ-ны ажилтнуудтай хамтран ажиллаж, үнэтэй зөвлөгөө өгсөн юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод гадаадын мэргэжилтнүүдээс гадна дотоодын зөвлөхүүд, тухайлбал тооллогын асуулга, заавар боловсруулахад Б.Батмөнх, тооллогын талаар олон нийтэд сурталчилгаа явуулахад Л.Нинжжамц, тооллогын үндсэн үр дүнг нэгтгэн боловсруулахад Ц.Бадрах нар тодорхой хугацаагаар зөвлөн ажилласан.

ТУРШИЛТЫН ТООЛЛОГО, АСУУЛГЫН СОРИЛ

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос хойш 10 жил өнгөрч, Монгол Улсын нийгэм, эдийн засаг хөгжин, хүн амын амьдралын хэв шинж өөрчлөгдөн хувьссан билээ. Түүнчлэн, дэлхийн цаг уурын өөрчлөлттэй уялдан тус улсын нутаг дэвсгэр байгаль цаг уурын хүчин зүйлийн нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөж байна. Иймээс хүн ам, орон сууцны тооллогыг явуулах цаг үе, тооллогын асуулгын бүтэц, агуулгыг өөрчлөн шинэчлэх, үр дүнг хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх үүднээс цуврал туршилт хийх нь зайлшгүй чухал байлаа. Хамгийн түгээмэл хийгддэг боловсронгуй туршилт бол тооллогын сорилт туршилтын тооллого юм. Тооллогын сорилтын зорилго нь тооллогоор асуух асуулт, асуултын хэллэгийг оновчтой болгох, тооллого явуулах баг, үүний дотор тоологч нарын ярилцлага авах нормативыг тогтоох, тооллогын ажилтны сургалтыг ямар хэлбэрээр явуулбал оновчтой байхыг туршин тогтоох явдал юм. Харин туршилтын тооллогоор тооллогын бүхий л үйл ажиллагааг нэгэн зэрэг туршиж, хүндрэл бэрхшээл, анхаарах асуудлыг тодорхойлдог. Түүнчлэн, олон улсын жишгээс үзэхэд ч туршилтын тооллогоор жижиг аргачлалын чанартай асуудлыг бус, харин тооллогын өргөн хүрээтэй ойлголт, ерөнхий зохион байгуулалтын асуудлыг туршдаг байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тооллогын сорилт, туршилтын тооллогыг хамтад нь явуулсан болно. Туршилтын тооллогод тус улсын байгаль цаг уурын янз бүрийн бүс, хүн амын суурьшил, шилжих хөдөлгөөний байдал зэрэг ээлжит тооллогод ямар нэг хэлбэрээр хүндрэл бэрхшээл гарч болох нутаг дэвсгэрийг сонгож, 2009 оны 1 дүгээр

сард явуулсан. Үүнд: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Ёлт баг, Мөрөн сумын 6 дугаар баг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 2 дугаар баг, Айраг сумын Нард багийг эхний ээлжинд сонгож, нийтдээ 22.4 мянган хүн хамруулав.

Дараагийн туршилтыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар хороонд 2009 оны 6 дугаар сард зохион байгуулсан. Энэ туршилтаар гадаадад суугаа иргэдийг ямар үзүүлэлтээр тоолох, хамгийн гол нь тоон системийн газрын зургийг нийслэлд ямар байдлаар ашиглах асуудлыг тодруулж, ээлжит тооллогын асуулгад гадаадад удаан хугацаагаар оршин суугаа иргэдийн талаарх мэдээллийг монголд байгаа ар гэрийхнээс нь авах үзүүлэлт, загварыг үндсэнд нь тогтсон. Газрын зургийн хувьд нийслэлд тоон системийн газрын зураг ашиглаж, өрх, хүн ам, орон сууцны байршлын цэгийг тодорхойлохдоо тоологч бүрт газарзүйн байршил тогтоох төхөөрөмж (GPS) өгч явуулах эсэх асуудлыг эцэслэсэн. Өөрөөр хэлбэл, нийслэлийн газрын албанаас авч ашигласан хорооны кадастрын тоон зургийг тооллогод ашиглан байршлын цэгийг тодорхойлох бололцоотой гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Төв аймгийн Лүн суманд тооллогын асуулга, өрхийн байршлыг тогтоох туршилтыг 2009 оны 8 дугаар сард хийв. Хөдөөгийн багт тоон газрын зураг ашиглах, хамгийн гол нь туршилтын тооллогоос гарсан үр дүнд үндэслэн шинэчлэн боловсруулсан асуулгын туршилт хийсэн. Тооллогын урьдчилсан үр дүнг гаргахад ашиглаж байсан 5 төрлийн маягт, үзүүлэлтийг багасгаж, тоологч, шалгагч, түр товчооны ажилтнуудад амар хялбар болгов.

Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогын асуулгын эцсийн хувилбарыг турших ажлыг Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян багт 2009 оны 10 дугаар сард зохион байгууллаа. Энэ туршилт нь тооллогын асуулга, нэгтгэлийн маягтыг эцэслэн батлахын өмнөх туршилт байв. Тоологч төв суурин газар, хөдөөд хэвлэсэн газрын зураг болон газарзүйн байршил тогтоох төхөөрөмж ашиглаж өрх, хүн амын байршлын цэгийг тогтоох, тогтоосон цэгүүдийг тулгах, улмаар зөрүүг нь тодорхойлох, тоологч газрын зургийг хэрхэн зурж ашиглах талаарх зааврыг эцэслэн боловсруулсан. Мөн тооллогын асуулга нөхөх заавар, ойлголт, тодорхойлолтод гарч буй хүндрэлийг эцэслэх, сургалтад ашиглах баримт бичгийг боловсруулах суурь эх үүсвэр болсон.

Туршилтын тооллогод сонгогдсон сум, хорооны хилийн цэс бүхий дижитал зургийн санг бий болгож, нийслэлд 1:5000-ны масштабын кадастрын, хөдөөд 1:200'000-ны масштабын байр зүйн зураг хэвлэн хүргүүлж, гар зураг бэлтгэж ашигласан болно. Туршилтын тооллогын дүнг үндэслэн анхаарах асуудлаар дэлгэрэнгүй тайланг гаргаж, ҮСХ-ны даргын зөвлөлд танилцуулж байв.

Дээр дурдсан туршилтуудыг хийснээр ээлжит тооллогын асуулгыг эцэслэн боловсруулж, нөхөх заавар, комисс, түр товчооны ажилтнууд, шалгагч, тоологчийн гарын авлагыг бэлтгэж, хэвлэх, бусад бэлтгэлийг хангах боломж бүрдсэн. Тооллогын асуулгыг эцэслэн баталсны дараа түүнийг НҮБ-ын үйл ажиллагаанд албан ёсоор хэрэглэдэг 5 хэл болон Солонгос хэлээр орчуулж ашигласан болно.

Эцэст нь тооллогын төсөв зохиох, төлөвлөх, асуулга болон бусад маягтын үзүүлэлт, зааварт анхаарах асуудлуудыг ээлжит тооллогод тусгасан.

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ГАЗРЫН ЗУРАГ

Өрх, хүн амыг тооллогод бүрэн хамруулахад газрын зураг чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ удаагийн тооллогод газарзүйн мэдээллийн систем ашиглаж байгаагаас хамааран газрын зураг зурах, түүнийг ашиглах, тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлтэй нягт уялдуулах зэрэг өмнөх тооллогуудад байгаагүй асуудал гарч ирсэн. Тооллогод газрын зураг ашигласнаар нэгд, тооллогыг удирдан явуулж байгаа тооллогын комисс, түр товчоодын ажилтнууд тухайн засаг захиргааны нэгжид оршин суугаа өрх, хүн амыг тоолох ажиллагааг зургийн дагуу төлөвлөж, үйл ажиллагааг зохицуулахад илүү хялбар болгодог, хоёрт, тоологдох өрх, хүн амыг тоологч нарт бүрэн хуваарилж, тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн хил хязгаартай яв цав нийцүүлэн тооллогод бүрэн хамруулахад гол үүрэг гүйцэтгэдэг, гуравт, тооллогын мэдээллээр газарзүйн мэдээллийн сан үүсгэж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоо, сэдэвчилсэн газрын зураг, атлас ашиглах боломжийг олгодог. Ингэснээр тооллогын үр дүнгээс гарах бүтээгдэхүүний төрөл, тоог баяжуулах боломж бүрдүүлдэг.

Газрын зураг боловсруулж хэвлэх, газарзүйн мэдээллийн систем (ГМС) үүсгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, программ хангамжийг бэлтгэж, хэрэглэгдэх байрзүйн болон кадастрын зургийг холбогдох газруудаас цуглуулсан. Хөдөөгийн сум, багт ашиглах 1:200'000-ны масштабтай байрзүйн зураг, төв суурин газарт 1:1100-1:3000-ны масштабтай кадастрын зургийн нийт 2000 гаруй эхийг бэлтгэж, 3700 гаруй зургийг А0 форматаар хэвлэж, орон нутагт хүргүүлэв. Баг, хорооны төвшинд бэлтгэсэн газрын зургаас тоологч өөрийн хариуцах хэсгийн зургийг зуран, тоологдсон өрх, хүн амын байршлын цэгийг тэмдэглэсэн. Энэхүү цэгийг баг, хорооны газрын зурагт буулгаж, тооллогын баримт бичгийн хамт ҮСХ-нд ирүүлсэн юм.

Тооллогын дараа газрын зургуудыг шалгаж, өрх, хүн амын байршлын цэгийг ГМС-д шивж, тооллогын мэдээлэлтэй холбосон бөгөөд үүнд үндэслэн вэбэд суурилсан ГМС-ийг үүсгэж, аль ч төвшинд зохих нууцлалын дагуу ашиглах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

ТООЛЛОГОД ЗОРИУЛСАН ӨРХ, ХҮН АМЫН БҮРТГЭЛ

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хоёрт заасныг үндэслэн тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлийг бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нар зохион байгуулж явуулсан. Тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлийг хийснээр тоолох үед тухайн өрх, орон сууцанд яг хэчнээн хүн тоологдохыг тодорхойлж, төлөвлөлт, зохион байгуулалт, төсөв хөрөнгийг эцэслэн шийдвэрлэхэд оршдог.

Бүртгэлд өрх бүрийг, тухайн өрхөд байнга болон түр хугацаагаар сууж байсан хүн бүрийг хамруулсан бөгөөд орон сууцны төрөл, өрхийн хаяг, өрхийн гишүүдийн овог нэр, суурьшил зэрэг үзүүлэлтийг оруулсан.

Тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлийг өөрчлөн тогтоосон тооллогын товоос сарын өмнө эхлүүлж, хөдөө орон нутагт 2 долоо хоног, нийслэлд 3-4 долоо хоног явуулж дуусгасан. Мөн газрын зураг дээр өрх, хүн амын байршлын цэг тэмдэглэх ажлыг бүртгэлтэй хамт хийсэн. Үүнд 670.0 мянган өрх, 2.5 сая хүн хамрагдсан нь 2009 оны жилийн эцэст байсан суурин хүн амын 93.8 хувь, өрхийн 100.2 хувь болсон. Энэ нь 2009 оны жилийн эцсийн хүн амаас 6.2 хувь дутуу хамрагдсан нь тоолох ажиллагаанд иргэдийг бүрэн хамруулахад анхаарах зарим асуудал байгааг илэрхий болгосон.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод нэг тоологчид төв суурин газарт 300-350 хүн, хөдөөд 30-35 өрх ногдохоор норматив тогтоосон. Тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлийн дүнд үндэслэн өрх, хүн амыг тоологчид хуваарилж өгсөн.

ТООЛЛОГЫН АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ

Хүн ам, орон сууцны тооллогын ажил сайтар зохион байгуулалттай, чанартай явагдах эсэх нь тооллогын ажилтнуудын боловсрол, мэргэжлийн төвшингөөс ихээхэн хамаардаг. Тооллогод оролцох бүх шатны ажилтан, тоологч, шалгагч нарыг ойлголт, тодорхойлолт, аргачлал, заавар журмын талаар нэгдмэл нэг ойлголттой болгох үүднээс ҮСХ сургалтыг шат шатанд зохион байгуулж, дадлагажуулахад ихээхэн анхаарал тавьж, сургалтыг дараах үе шатаар явуулсан.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН СУРГАЛТ

Аймаг, нийслэлийн Засаг дарга бөгөөд тооллогын комиссын дарга нарт зориулсан анхны сургалтыг 2009 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Сургалтаар тооллогын хэрэгцээ, шаардлага, үр дүнгийн хэрэглээ, бэлтгэл ажил, зохион байгуулалт болон санхүүгийн талаарх ерөнхий мэдээлэл өгч, орон нутагт бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

Дараа нь аймаг, сумын тооллогын комисс, бүх шатны түр товчооны дарга, гишүүд, ажилтнуудад зориулсан сургалтыг 2010 оны 5, 6 дугаар сард зохион байгуулж, 21 аймаг, 329 сум, нийслэл, 9 дүүрэг, 132 хорооны нийт 1528 хүнийг хамруулсан. Сургалтад ҮСХ-ны удирдах бүрэлдэхүүн, ХАОСТТ-ны шинжээчид оролцож, тооллогын бэлтгэлийг хангах зохион байгуулалт, төлөвлөлтийн болоод анхаарах асуудлыг танилцуулж, тулгамдаж буй асуудлыг ярилцаж, газар дээр нь шийдвэрлэж байсан нь ихээхэн чухал нөлөө үзүүлсэн юм.

СУРГАГЧ БАГШИЙН СУРГАЛТ

Тооллогын бүх шатны ажилтан, тоологч, шалгагч нарт сургалт явуулах багшийг сонгох, тэднийг сургах нь тооллогын бэлтгэл ажлын гол хэсэг байлаа. Тоологч нар тооллогын гар зураг зурах, өрх, хүн нэг бүртэй ярилцаж, мэдээлэл цуглуулах учраас сургагч багш нарыг сайтар бэлтгэх, сургалтын материалыг энгийн ойлгомжтой боловсруулах асуудал нэн чухал байв.

Сургагч багш нарыг сонгож, томилох асуудалд ихээхэн анхаарсан. Сургагч багшид аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтсийн дарга, ахлах болон хүн амын асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдахаас гадна санхүү, бүртгэл, тооцооны чиглэлээр ажилласан, бусдад хичээл заах зохих чадвар, туршлагатай байх шалгуурыг тавьж, орон нутгаас 112, нийслэлээс 36, нийт 148 хүнийг хамруулсан. Суралцагчдын 39.9 хувь нь эрэгтэй, 60.1 хувь нь эмэгтэйчүүд, 21.6 хувь нь 20-29, 25.0 хувь нь 30-39, 28.4 хувь нь 40-49, 25.0 хувь нь 50 ба түүнээс дээш настай, бүгд дээд боловсролтой хүмүүс байв.

Сургагч багшийн сургалтыг 2010 оны 8 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод нэгдсэн байдлаар зохион байгуулж, тооллогын удирдлага, зохион байгуулалт, бэлтгэл ажил, хэрэглэх ойлголт, тодорхойлолт, тооллогын асуулга, дагалдах маягтын бүтэц, асуулыг асууж нөхөх арга, гар зураг зурж бэлтгэх, газрын зурагт ажиллах зэрэг сэдвээр хичээл зааснаас гадна хүн бүрээр тооллогын асуулга нөхүүлж дадлагажуулан, тестээр шалгалт авсан.

ТООЛОГЧ, ШАЛГАГЧ НАРЫН СУРГАЛТ

Тооллогын мэдээллийн чанар нь тоологч нар тоолох ёстой өрх, хүн амаа бүрэн гүйцэд тоолж, ярилцлага авч, үнэн зөв мэдээлэл цуглуулахаас шууд шалтгаалдаг тул ажиллах хүмүүсийг зөв сонгоход онцгой анхаарсан. Тоологч, шалгагчаар ажиллах хүмүүс нь бүрэн дундаас дээш боловсролтой, цэвэр нямбай алдаагүй гаргацтай бичих чадвартай, харилцааны өндөр соёлтой, хүн ам, мал тооллого, бусад судалгаанд оролцож байсан

дадлага туршлагатай байхын зэрэгцээгээр тооллого эхлэхээс дуусах хүртэл тухайн сум, хороонд байнга суурьших хүмүүсийг сонгосон. Сургалтыг 2010 оны 9-10 дугаар сарыг дуустал аймаг, нийслэлийн түр товчоо удирдан зохион байгуулж, 26.3 мянга орчим хүн сургалтад оролцсон.

БУСАД СУРГАЛТ

Гадаад харилцааны яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яамны тооллогын комисс, түр товчооны ажилтнуудын сургалтыг 2010 оны 10 дугаар сард хийж, тэд тоологч, шалгагч нарынхаа сургалтыг зохион байгуулсан.

Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тооллогын ажилтны сургалтыг Гадаад харилцааны яамны тооллогын түр товчоотой хамтран Ази, зүүн, баруун Европ, АНУ гэсэн чиглэлд явуулсан. Эдгээр сургалтад монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага, холбоод, банк, санхүү, нийгмийн даатгал, ажиллах хүч зуучлах байгууллага, монголчуудад мэдээлэл хүргэдэг цахим хуудас, радио, сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага, хүмүүсийг өргөн оролцуулав.

Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат иргэдийг тоолоход хэлмэрчлэх 85 оюутныг Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Гадаад хэлний сургуулиудаас сонгож, тооллогын ойлголт, тодорхойлолт, асуулга нөхөх талаар сургалт явуулсан юм.

УХУУЛГА, СУРТАЛЧИЛГАА

Тооллогыг амжилттай явуулах, ялангуяа ард иргэдийг тооллогод идэвхтэй бүрэн оролцуулах нь ухуулга сурталчилгааны ажлын үндсэн зорилт байв. Бүх шатны сургуульд суралцагчид, төр засгийн байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллагчид, өндөр настан, ажилгүй хүмүүст тооллогод бүрэн хамрагдахын ач холбогдлыг ухуулан ойлгуулах нь сурталчилгааны ажлын үндсэн чиглэл байлаа.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын бүх баримт бичигт байх тооллогын бэлгэдэл /эмблем/ гаргасан нь сурталчилгааны ажлын эхлэл байв. Тооллогын бэлгэдлийн загвар, уриа шалгаруулах уралдаан зарлаж, ҮСХ-ны даргын тушаалаар баталсан бөгөөд энэ удаагийн тооллогыг үндэстэн, угсаатны эв нэгдлийг илэрхийлсэн бэлгэдэл **“Хүмүүнд төр эрхэм-Төрд хүмүүн эрдэнэ”** уриан дор зохион байгуулсан нь тооллогын утга учир, ач холбогдлыг сурталчлах, хүмүүсийн эх оронч ухамсрыг хөгжүүлэх замаар тооллогод бүх нийтийг хамруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Тооллогын цахим хуудас [“www.toollogo2010.mn”](http://www.toollogo2010.mn)-ыг 2010 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр ажиллуулж эхэлсэн нь тооллоготой холбоотой бүхий л мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчилгааны ажлын нэг гол хэсэг байлаа. Дэлхийн хүн амын өдөр жил бүрийн 7 дугаар сарын 11-нд тохиодогтой хамтруулан **“Эх дэлхийн хүн бүрийг тоолж байна”** уриан дор тус өдрийг орон даяар тэмдэглэн өнгөрүүлэв. Энэ ажлын хүрээнд улс орон даяар телевиз, радио, интернэт, сонингоор тооллого болох хугацаа, зорилго, ач холбогдлыг тусгасан мэдээ, мэдээлэл, сурталчилгааг явуулж, хулдаасан самбарыг олон нийтийн хөл хөдөлгөөнтэй газрууд, тухайлбал нийслэлд төв замын дагуу, аймгийн төвүүдэд байрлуулсан. Мөн Дэлхийн статистикийн өдрийг (2010 оны 10 дугаар сарын 20) тохиолдуулан Зууны мэдээ, Өдрийн сонинд тооллогын сэдвээр бүтэн нүүр бэлтгэж нийтлэв.

Сурталчилгааг зохион байгуулах ажлын хүрээнд мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн 2 багийг гаднаас сонгон шалгаруулсан. МҮОНТ-ийн сэтгүүлч, редактор Ц.Алтанцэцэгийн **“Шинэ эрин”** багийг НҮБ-ын ХАС-ийн санхүүжилтээр, сурталчилгааны зөвлөх

Л.Нинжжамцийн “Юнайтэд ПР” багийг ҮСХ-ны төсвөөс санхүүжүүлж, гэрээ байгуулсан. Мөн үндэсний аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулан “Түншлэгчдийн уулзалт” зохион байгуулж, тэднээр дамжуулан сурталчилгааг хамтран зохион байгуулснаас гадна ГХЯ хилийн чанадад оршин суугаа иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр голлох үүрэгтэй ажилласан.

Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд сурталчилгааг дараах мэдээллийн хэрэгсэл ашиглан бололцоотой бүх л сувгаар явуулав. Үүнд:

1. Телевиз, радио
2. Интернет, И-майл маркетинг
3. Сонин
4. Зурагт хуудас, нугалбар, хулдаасан самбар
5. Үүрэн утас

Эдгээрээс гадна уулзалт, электрон самбар, олон нийтийг хамарсан яриа, ухуулгыг ашигласан. Мөн 2010 оны 10 дугаар сарын 13-наас 11 дүгээр сарын 21 дуустал “121” тусгай дугаарын утас ажиллуулж иргэдийн болон тооллогын ажилтны санал хүсэлтийг хүлээн авч, хариулт өгөх ажлыг шинээр зохион байгуулсан.

ТООЛОХ АЖИЛЛАГАА

Тоолох үе бол тооллогын бэлтгэл ажилтай харьцуулахад маш богино хугацаанд явагддаг. Тооллогын бэлтгэл хэр хангагдсаныг шалгах шалгуур болдог. Тоолох ажиллагаа 2010 оны 11 дүгээр сарын 11-ний өглөөний 8 цагаас эхэлж, 17-ны шөнийн 12 цаг хүртэл 7 хоног үргэлжлэв.

Хүн ам, орон сууцны тооллогод хүн бүр оролцохын чухлыг ойлгуулах талаар ухуулга сурталчилгааг эрчимтэй явуулахын зэрэгцээ төр засгаас явуулж байгаа арга хэмжээ, ялангуяа эх орны хишиг, хувь хүртээхэд тооллого, бүртгэлд хамрагдаж, иргэн хүний үүргээ биелүүлсэн байх тухай иргэдэд таниулсан. Үүнийг олон нийт ойлгон ухамсарлаж, тооллогод идэвхтэй оролцож байгаа нь тооллогын эхний өдрөөс мэдэгдэж байлаа.

Тооллогын эхний өдөр УИХ-ын дарга УИХ-ын чуулганы нээлт дээр үг хэлж, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, тэдний гэр бүлийг тоолж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Монгол Улсын Ерөнхий сайд, хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын дарга С.Батболд “Тооллогын ажлыг амжилттай явуулахад манай нийт иргэдийн оролцоо, эх оронч сэтгэл нэн чухлыг тэмдэглээд, улс орны төдийгүй дэлхийн хэмжээнд ач холбогдолтой 10 жилд ганцхан удаа явагддаг хүн ам, орон сууцны тооллогод иргэн бүр нийгмийн өмнө хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу идэвхтэй оролцохыг уриалж байна” гэж хэлсэн нь ард иргэдийг тооллогод идэвхтэй оролцоход зохих түлхэц болсон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комиссын дарга нар тооллогын нээлтийн ажиллагааг зохион байгуулж, орон нутгийнхаа хамгийн өндөр настай иргэнээс тооллогыг эхэлж, энэ талаараа өргөн дэлгэр сурталчилсан нь нэг талаас ахмадаа хүндэтгэдэг уламжлал, ёс заншлаа дээдэлсэн арга хэмжээ болсон төдийгүй тооллогод ард иргэдийг идэвхтэй оролцохыг уриалсан ухуулга болсон.

Тооллогын өдрүүдэд бүх шатны түр товчоодод шуурхай жижүүр өдөр бүрийн 8-22 цаг хүртэл ажиллаж, иргэдийн асуултад хариулт өгч байсны хамтад, гадаадаас интернэтээр холбогдсон иргэдийн асуулт, хүсэлтийг ҮСХ өдөр бүрийн 8-02 цагийн хооронд жижүүр гарган хүлээн авч, шийдвэрлэж байв. Түүнчлэн, ҮСХ-нд 121 дугаарын лавлах утас ажиллуулж, нийслэл, дүүргийн тооллогын түр товчоодтой өдөр бүр холбоотой ажиллаж, шаардлагатай туслалцаа үзүүлж байв. Тооллогын комисс, түр товчоод анхан шатны

нэгжид хүрч, тэнд ажиллаж байгаа тоологч, шалгагч нарын ажилтай танилцан, ажил үүргээ гүйцэтгэсэн эсэхийг шалгах, удирдан чиглүүлэх, заавар зөвлөгөө өгч, төв суурин газрын тоологч нар ажлын явцаа өдөр бүр тайлагнах, хүндрэлтэй асуудлаа хэлэлцэж тохирох, хөдөө орон нутагт 2-3 хоногт шалгагчтай уулзаж заавар зөвлөгөө авахаар зохион байгуулж байв.

ҮСХ болон ГХЯ-ны ажилтнуудын бүрэлдэхүүнтэй багийг АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, ХБНГУ, Турк, Франц, Европын хэд хэдэн хотуудад ажиллуулсан нь гадаадад ажиллаж амьдардаг Монгол Улсын иргэдийг тооллогод аль болох бүрэн хамруулахад чухал ач холбогдолтой ажил болсон.

Тоологдсон өрх, хүн амын тоог дараагийн өдөрт нь нэгтгэн авч, явцыг хянаж байснаас гадна 11 дүгээр сарын 11-13-ны өдрийн явцын мэдээг 14-нд, 14-17-ны явцын мэдээг 19-нд тооллогын Улсын комиссын гишүүдэд танилцуулж, олон нийтэд мэдээлсэн. Эхний 3 өдрийн мэдээгээр улсын хэмжээнд нийт өрхийн 56.7 хувь, Улаанбаатарт 61.5 хувь нь тоологдсон байв.

Албан болон хувийн ажлын шалтгаанаар тоолох үеийн өмнө болон тооллогын өдрүүдэд гадаад, дотоодод зорчих иргэдийг урьдчилан баг, хороон дээр нь тоолох чиглэл өгч, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Улаанбаатар хотын Буянт-Ухаа боомтуудад иргэдийг тоолж, хил нэвтрүүлж байв. Мөн аймаг, хот хооронд бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчигчдын тоологдсон эсэхийг шалгаж, хяналт тавьсан нь давхар тоолуулахаас сэргийлсэн арга хэмжээ болсон юм. Иргэдийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын ажилтнуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор Говь-Алтай, Говьсүмбэр, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл зэрэг аймгууд согтууруулах ундаа худалдаалах цагийг хязгаарлах, бүрэн хориглох зэрэг зохицуулалт хийжээ.

Байнга оршин суух газаргүй, дээвэр, орц, хонгил, дулааны шугам сүлжээний сувагт орогнодог орон гэргүй иргэд, албан бусаар ашигт малтмал олборлогчдыг ЦЕГ-ын бие бүрэлдэхүүнтэй хамтарч тоолсон бөгөөд орон гэргүй иргэдийг улсын хэмжээнд 11 дүгээр сарын 14-нөөс 15-нд шилжих шөнө нэгэн зэрэг тооллогод хамруулсан.

Тооллогын сүүлчийн өдрүүдэд оюутнуудыг байгаа газарт нь тоолохгүй байна гэсэн иргэдийн санал, гомдлын дагуу оюутны томоохон байруудад шалгалт хийж, 11 дүгээр сарын 17-ны өдөр МУИС, ШУТИС, ЭМШУИС, МУБИС, ХААИС дээр тоологдоогүй оюутнуудыг харьяалах дүүргийн тооллогын түр товчоодтой хамтран тоолов.

Шалгагч нар тоологч нарын ажилд туслах, тоологчийн авсан асуулгыг шалгах, тэдэнд зөвлөгөө өгч, ажил дээр давтан сургалт явуулсан нь тооллогын ерөнхий чанарыг сайжруулахад зохих хувь нэмэр болсон. Ялангуяа, шалгагч нар тоологч нарын тоолсон өрхөөр орж, тооллогын хамрагдалтыг шалгаж байсан нь тоологч нар ажлаа чанартай хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

ХЯНАЛТЫН ТООЛЛОГО

Хяналтын тооллого нь бие даасан, хараат бус тооллогын үнэлгээний гол арга юм. Хяналтын тооллого хийх үндсэн зорилго нь ээлжит тооллогын хамралтын болон агуулгын алдаа, сонгосон асуултаар хариултуудыг харьцуулах, тооллогын нэгж, түүний хамрах хүрээг түүвэр судалгаанд ашиглахад үнэлгээ өгөх, дараагийн тооллогод зориулж зөвлөмж боловсруулахад оршино. Хяналтын тооллогын асуулга нь хаягийн хэсэг, хувь хүний тухай ерөнхий мэдээллийн 9 асуултаас бүрдсэн.

Хяналтын тооллогод Монгол Улсын нийт хүн амын нэг орчим хувийг хамруулахаар тооцож, 153 баг, хороог сонгов. Аймаг, нийслэл, дүүргийн тооллогын түр товчоо ҮСХ-оос өгсөн үзэл баримтлал, удирдамжийн дагуу хяналтын тооллогыг урдчилан

сонгогдсон тооллогын нутаг дэвсгэрийн нэгжид явуулсан бөгөөд хяналтын тооллогын материалын нууцлал, хадгалалт, бүрэн бүтэн байдлыг хангаж, ҮСХ-нд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.

ТООЛЛОГЫН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл боловсруулах систем

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод интернэт технологи, газарзүйн зургийн систем нэвтрүүлсэн нь өмнөх тооллогуудаас давуутай боллоо.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын мэдээлэл боловсруулалтад бэлтгэж байсан үетэй харьцуулбал үндэсний статистикийн салбарын техник технологийн нөхцөл байдал өндөр төвшинд хүрсэн. Статистикийн салбарын төв аппарат 1000Mbps хурдтай дотоод сүлжээ, 2048Kbps хурдтай интернэтийн бие даасан шугамтай, дотоод, гадаад сүлжээний найдвартай ажиллагааг хангах үүрэг бүхий тусгаар зонд байрлуулсан сервер компьютерүүд, нууцлал хамгаалалтын тусгай зориулалтын төхөөрөмжтэйгээр ажилласан.

“Статистикийн тухай”, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд, Статистикийн салбарын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдлын журам, тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийг хэрэглэгчдэд ашиглуулах түр журам, тооллогын мэдээллийг хүлээж авах, шивэх, шалгаж засварлах үйл ажиллагаанд мөрдөх журам зэрэг баримт бичгүүд нь тооллогын мэдээлэл боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн юм.

Тооллогын мэдээлэл боловсруулах техникийн орчин, сүлжээний бүтцийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Компьютер, төхөөрөмжүүд	Тоо ширхэг	Техникийн үзүүлэлт	Үйлдлийн систем
1 Ширээний компьютер	70ш	CPU -P4 2.26-Dual core 2.2 GHz HDD- 60Gb – 160Gb RAM -512Mb -1Gb 17"LCD display	Windows XP service pack2
2 Сервер компьютер	2ш	Intel Xeon 2.4 GHz(16 CPU), 16Gb ram, 2x1TB (raid 5/0 - 2.8 TB) HDD, RAID controller	Windows server 2008 service pack 2
3 Мэдээлэл хадгалах төхөөрөмж	1ш	Intel Xeon 2.27 GHz(16 CPU), 16Gb ram, 9x1TB (raid 5/0 - 4.6 TB) HDD, RAID controller	Windows server 2008R2
4 Мэдээлэл хадгалах туузан диск	2ш	400/800Gb	
5 Сүлжээний свич	4ш	24 порт 10/100/1000Mb	

Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хадгалах, хамгаалах зорилгоор шивэлтийн сүлжээг байгууллагын сүлжээнээс физик холболтын хувьд тусдаа зохион байгуулсан. Сүлжээг windows системийн зохион байгуулалтаар тусдаа дотоод удирдлагын толгой сервер /домайн контроллер/ зохион байгуулж удирдсан. Шивэлт хийх компьютерүүдийг уг толгой компьютерт холбож мэдээллийг алдах, эвдэх, засварлах зэргээс хамгаалах тохиргоог хийсэн. Мэдээллийн нөөцлөх ажлыг өдөрт 2 удаа 15:10, 22:10 цагуудад автоматаар архивлаж, 23:00 цагт бүтэн өдрийн архивыг дискэнд (TAPE) бичиж хадгалж байв.

Тоног төхөөрөмжүүдийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангах, эвдрэл гэмтлийн үед шуурхай засварлах, хэвийн ажиллагаанд оруулах тоног төхөөрөмж, сэлбэгийн нөөцийг ч бүрдүүлсэн юм. Шивэлтийн компьютер, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан.

Мэдээлэл боловсруулалтад сүүлийн үеийн багц программууд (CSPRO, SPSS) ашигласан. Түүнчлэн, ангилал, код, стандартуудаас хайлт хийж, сүлжээний орчинд тооллогын асуулгыг кодлох болон боловсруулалтын явцын мэдээний хяналтын программ хангамжийг ашигласан (NET хэлээр хөгжүүлсэн) болно.

ИНТЕРНЭТ ТООЛЛОГЫН БОЛОВСРУУЛАЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын нэг онцлог бол гадаадад удаан хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийг интернэтээр тоолсон явдал байлаа. Тиймээс вэбэд суурилсан программ хангамж боловсруулах, вэб үйлчилгээ бүрдүүлэх, мэдээллийн нууцлалтай холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний дата төв, Тагнуулын ерөнхий газар зэрэг байгууллагуудын чиг үүргийн эрх зүйн зохицуулалтад нийцсэн зохион байгуулалт хийх нөр их ажил өрнөсөн. Интернэтээр мэдээлэл цуглуулсан анхны тооллого тул мэргэжлийн болон зохион байгуулалтын туршлага дутаж, түүнчлэн төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахад эрх зүйн орчны хүндрэл гарч байлаа.

Иргэдийг интернэтээр бүртгэх, зөвшөөрөл олгох, тооллогын асуулгыг интернэтээр нөхүүлэх, хариу мэдээлэл өгөх үндсэн программ хангамжийг YCX Symphony framework технологиор боловсруулж, Үндэсний дата төв вэб үйлчилгээг нь хэрэгжүүлсэн юм.

Гадаадад оршин суугаа иргэдийн ажиллаж, амьдарч байгаа орчны технологийн нөхцөл адил биш, зарим иргэдэд зохих төвшний технологийн мэдлэг дутагдаж байсан тул тооллогын асуулгыг хэвлэж нөхүүлээд YCX-нд хүргүүлэх арга хэмжээг Монгол Улсаас тухайн оронд суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд зохион байгуулсан.

Мэдээлэл боловсруулалтын явцад нөхөж ирүүлсэн асуулгыг шивэх, ХАОСТ-1 маягтаар ар гэрийхэн нь тооллуулсан хүмүүсийн давхардлыг шалгах зэрэг ажлыг хийж, тооллогын дүнд оруулсан болно.

МЭДЭЭЛЛИЙГ КОДЛОХ, ШИВЭХ, ЗАСВАРЛАХ

Тооллогын мэдээлэл боловсруулалтыг богино хугацаанд дуусгаж, үр дүнг хэрэглэгчдэд хүргэх гол зорилгод үндэслэн 136 түр ажилтан ажиллуулав. Түр ажилтнуудын ажлын өрөөний хүрэлцээнээс хамаарч 6 хэсэгт хуваарилан 3 өрөөнд тоног төхөөрөмж суурилуулж, сүлжээнд холбон, хоёр ээлжээр ажиллуулсан. Нийт 6 ээлжийн ахлагч, 130 оператор боловсруулалтын ажилд оролцов. Тооллогын асуулгыг шат шатны түр товчоод шалгаж хүлээн аваад, тусгайлсан графикт хуваарийн дагуу YCX-нд хүлээлгэн өгч байв.

Тооллогын баримт бичгийг шалгаж хүлээн авах, кодлох, шивэх, засварлах ажлын боловсруулалт тодорхой хугацаанд зэрэг хийгдэж, үйл ажиллагаа нь тасралтгүй хэрэгжихээр зохион байгуулалтыг хийсэн. Кодлолт 2010 оны 12 дугаар сарын 13-нд, шивэлт 2011 оны 1 дүгээр сарын 7-нд эхэлж, 4 дүгээр сарын 16-нд үндсэн болон хяналтын тооллогын асуулгыг шивэх, давтан шивэлт хийх ажлууд дуусав. Мэдээллийг шалгах, засварлах ажил 2011 оны 4 дүгээр сарын 18-нд эхэлж, 5 дугаар сарын 5-нд дууссан. Хүн ам, орон сууцны тооллогын товчооноос боловсруулсан арга зүйд үндэслэсэн программын аргаар хийх автомат засвар 5 дугаар сарын 10-нд дуусч, үр дүнгийн хүснэгтүүдийг гаргаж эхэлсэн.

ТООЛЛОГЫН ҮР ДҮН

Тооллогын үр дүнг боловсруулах хүснэгтийг хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, НҮБ-ын зөвлөмжийг үндэслэн ХАОСТТ-ны ажилтнууд боловсруулсан. Үр дүнгийн хүснэгтэд хүн амын асуудлаар 84, орон сууцны асуудлаар 29, интернэт, гар утасны хэрэглээгээр 12 хүснэгт, бодлогын даалгавар боловсруулж, асуулгын боломжит бүх үзүүлэлтийг үр дүнгийн хүснэгтэд тусгасан. Эдгээр хүснэгтийн хоорондын уялдаа холбоо, программын болон бусад алдааг шалган засварлаж, эцсийн дүнг 2011 оны 5 дугаар сард гарган авав.

Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо, нас, хүйс, байнга сууж байсан аймаг, нийслэлийн мэдээллийг Монгол Улсын суурин хүн амын нас, хүйс, аймаг, нийслэлийн хүн амын тооцоонд нэгтгэн оруулж, хоёрдугаар бүлэгт багтаасан. Харин Монгол Улсын нутаг дэвсгэрт тоологдсон Монгол Улсын иргэн, удаан хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат иргэн, харьяалалгүй хүмүүсийн мэдээлэлд боловсруулалт хийж, бусад бүлгүүдийг бичсэн бөгөөд арван нэгдүгээр бүлэгт гадаадад тоологдсон Монгол Улсын харьяат иргэдийн судалгааг тусад нь оруулав.

ТООЛЛОГЫН ҮР ДҮНГ ХЭВЛЭН НИЙТЛЭХ, ХЭРЭГЛЭГЧДЭД ТАРХААХ

Хүн ам, орон сууцны тооллогын үе шатны сүүлчийн хариуцлагатай ажил нь тооллогын үр дүнд гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээ хийж, хэвлэн нийтэлж, хэрэглэгчдэд богино хугацаанд хүргэх явдал билээ. Төр засгийн болон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, хэрэглэгчид тооллогын үр дүнгээс ямар мэдээлэл авах эрэлт хэрэгцээг судлах, тэдэнд үйлчлэх нь статистикийн байгууллагын нэг зорилт юм.

Тооллогын үндсэн үр дүнг 2011 оны 6 дугаар сард олон нийтэд албан ёсоор зарласан. Цаашид бүх аймаг, нийслэлийн хэмжээнд тооллогын тайланг тус тусад нь бэлтгэж хэвлүүлнэ. Эдгээрээс гадна статистикийн эмхтгэл, сэдэвчилсэн, гүнзгийрүүлсэн судалгааг 2011-2012 оны эхний улиралд багтаан хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргүүлэхээр бэлтгэж байна. Энэ удаагийн тооллого нь газарзүйн мэдээллийн системийг ашиглаж хийсэн анхны тооллого учраас өмнөх тооллогын дүнгээр гаргаж байгаагүй үндэсний хэмжээний болон аймаг, нийслэлээр атлас хэвлүүлж, нийтийн хүртээл болгоно. Үүний зэрэгцээ тооллогын үр дүнг тооллогын цахим хуудас, бусад электрон хэлбэрээр дамжуулан гадаад, дотоодын хэрэглэгчдэд хүргэнэ.

ТООЛЛОГЫН АСУУЛГА БОЛОВСРУУЛАЛТ, ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын хамрах хүрээ, асуулгыг боловсруулахдаа дараах үндсэн зарчмыг баримталсан. Үүнд:

- “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 10, 11 дүгээр зүйл;
- “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийн 2 дахь хэвлэл;
- Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үр дүнтэй зэрэгцэхүйц байх;

НҮБ-аас бэлтгэж, гишүүн орнууддаа зөвлөмж болгосон “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийн 2 дахь хэвлэлд хүн амын тооллогод тусгах үндсэн 31, орон сууцны тооллогын үндсэн 19 үзүүлэлт зөвлөмж болгосноос хүн амын 31, орон сууцны 18 үзүүлэлтийг асуулгад оруулсан.

Тооллогын асуулгын үзүүлэлтүүд дараах онцлогтой байлаа. Үүнд:

- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн зарим үзүүлэлт, тухайлбал гар утас, интернэтийн хэрэглээ, ундны усны эх үүсвэр, зэрэг үзүүлэлтийг оруулсан.

- Бүх өрхөөс асуух зориулалттай нас баралт, эхийн эндэгдлийн асуулга тусдаа боловсруулсан.
- Интернэт тооллогын асуулгыг тусад нь боловсруулж, мэдээлэл цуглуулсан.

Хүн амын тооллогын нэг онцлог бол тооллогын товын талаарх асуудал юм. Энэ нь хүн төрөх, нас барах, засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд эсвэл гадаадад шилжин явах, ирэх зэргээр байнгын хөдөлгөөнд орж байдагтай холбоотойгоор улс орны хүн амын тоог тодорхой хугацаагаар тасалбар болгодог олон улсын жишиг ойлголт юм. Тооллогын товыг 2010 оны 11 дүгээр сарын 10-наас 11-нд шилжих шөнийн 00 цагаар тогтоосон.

Тооллогын үр дүнг боловсруулахдаа бэлэн, суурин хүн ам гэсэн ойлголтыг аль алиныг нь хэрэглэсэн. Бэлэн хүн ам нь тооллогын товын үед тухайн засаг захиргааны нэгжид байнга болон түр сууж байсан хүн амын тооны нийлбэрээр, суурин хүн ам нь тооллогын товын үед тухайн засаг захиргааны нэгжид байнга сууж байсан болон түр эзгүй байгаа хүн амын тооны нийлбэрээр тодорхойлогддог.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
---	---------	--------------

ӨРХ, ХҮН АМ

1. Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.
2. Үндсэн өрх	“Үндсэн өрх” гэж сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
3. Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
4. Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-аас дээш настай, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
5. Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тоолох үед тухайн өрх айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ.
-----------------------------	---

7. Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
8. Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
9. Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "харах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
10. Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааний чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
11. Хэл ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "ярих" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
12. Хөдөлгөөний	Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
13. Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх, ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцооны дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.

СУУРЬШИЛ

14. Байнга суудаг	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
15. Түр эзгүй	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааныхаа нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
16. Түр суугаа	Тооллогын товоос өмнө өөр засаг захиргааны нэгжээс ирж, тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн

БОЛОВСРОЛ

17. Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2010 онд ЕБС-ын 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
18. Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
19. Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл), 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал), 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн

20. Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг (2006 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
21. Техникийн болон мэргэжлийн боловсрол	МСҮТ (хуучнаар ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
22. Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
23. Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Түүнчлэн, Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг мөн энэ ангилалд хамааруулна.
24. Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
25. Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэж үзнэ.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

26. Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
27. Батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
28. Батлуулаагүй	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
29. Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.
30. Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ.
31. Бэлбэсэн	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг Бэлбэсэн гэж үзнэ.

АЖИЛ ЭРХЛЭЛТ

32. Ажил эрхэлдэг хүн	Тооллогын товын үед тогтмол ажил эрхэлж байгаа, эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалинтай ажил эрхэлсэн хүн
-----------------------	---

33. **Ажилгүй хүн** Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсвэл бүртгүүлээгүй, тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүн

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТ

34. **Менежер** Менежер нь Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтанг хамруулна. Тухайлбал, төрийн болон хувийн аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын бүх төвшний дарга, захирал, хууль тогтоогч, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, бүх төвшний засаг дарга, захирагч, ТББ-ын удирдах албан тушаалтан, менежер гэх мэт.
35. **Мэргэжилтэн** Мэргэжтэн нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, тэдгээрийг системтэйгээр заах сургах буюу мэргэжлийн өндөр төвшин шаардсан ажил гүйцэтгэгч байна. Тухайлбал, шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн, эмч, сувилагч, багш, судлаач, бизнесийн болон захиргааны мэргэжилтэн, программ зохиогч, шашны мэргэжилтэн, уран бүтээлч, дуучин, жүжигчин гэх мэт.
36. **Техникч болон туслах/дэд мэргэжилтэн** Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэд уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна. Физик, инженерийн ухааны техникч, уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч, технологи процесс, чанар шалгагч, амьд ертөнц судлах ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн, усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч гэх мэт.
37. **Контор, үйлчилгээний ажилтан** Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуулчлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Компьютерийн операторч, үйлчилгээний туслах ажилтан, тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан, конторын бусад туслах ажилтан гэх мэт.
38. **Худалдаа, үйлчилгээний ажилтан** Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юмуу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хувийн үйлчилгээний ажилтан, худалдааны ажилтан, хувь хүн асрах ажилтан, хамгаалах үйлчилгээний ажилтан гэх мэт.
39. **Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан** Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан, өрхийн хэрэгцээний шинжтэй фермерч, загасчин, анчин болон түүн цуглуулагч гэх мэт.

<p>40. Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан</p>	<p>Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металлд хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ. Металл, машин, механизм, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан, гар урлал, хэвлэлийн ажилтан, цахилгаан болон цахим техникч, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч гэх мэт.</p>
<p>41. Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч</p>	<p>Хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, эд анги, хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заавар, журам, стандарт, шаардлагын дагуу угсрах ажил эрхэлнэ. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч гэх мэт.</p>
<p>42. Энгийн ажил, мэргэжил</p>	<p>Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. Цэвэрлэгч, туслагч, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил, хүнс бэлтгэлийн туслах ажил, гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил, бусад энгийн ажил гэх мэт.</p>
<p>43. Зэвсэгт хүчний ажил, мэргэжил</p>	<p>Зэвсэгт хүчний офицерийн цол бүхий Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерийн алба гэнэ. Зэвсэгт хүчний офицер нь төрөл бүрийн энгийн ажил, мэргэжилд байдаг ижил төстэй үүрэг гүйцэтгэж болно. Энэ бүлэгт Зэвсэгт хүчинд алба хааж байгаа дунд офицер, ахлах офицер, дээд офицерийн нийт бие бүрэлдэхүүн багтана.</p>

ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

<p>44. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур</p>	<p>Мал, амьтны болон таримал, байгалийн ургамлын нөөцийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа орно. Үүнд: газар тариалан эрхлэх, мал, амьтныг өсгөх, үржүүлэх, түүний ашиг шимийг авах; загас барих; ан агнуур; ойжуулалт, мод бэлтгэл; фермерийн аж ахуйн үйл ажиллагаа зэрэг хамаарна.</p>
<p>45. Уул уурхай, олборлолт</p>	<p>Байгалийн хатуу (нүүрс, хүдэр), шингэн (нефть) эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялгийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.</p>
<p>46. Боловсруулах үйлдвэрлэл</p>	<p>Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эд, материалыг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно. Мөн бусад боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох түүхий эд материал, бодис эсвэл бүтээгдэхүүнийг хувиргахад орох түүхий эд байна. Барааг шинэчлэх, сэргээн босгох, өөрчлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байна.</p>

47. **Цахилгаан, хий, уур, агааржуулалт** Энэ салбарт дэд бүтцийн /сүлжээ/ шугам хоолойгоор дамжуулан цахилгаан эрчим хүч, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах үйл ажиллагаа хамрагдана. Түүнчлэн, нэгдсэн сүлжээгүй орон нутгийн чанартай барилга байгууламжийн бие даасан эх үүсвэр бүхий цахилгаан, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах, түгээх ажиллагаа мөн багтана.
48. **Ус хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа** Энэ салбарт өрхийн болон үйлдвэрийн хатуу эсвэл хатуу бус, бохирдсон талбай зэргийн хог, хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах явцтай холбоотой үйл ажиллагаа багтана. Хог хаягдал, бохир ус боловсруулах үйл ажиллагааны үр дүнд ариутгасан эсвэл шинэ бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа байж болно. Усан хангамжийн үйл ажиллагаа нэгтгэгдэн энэ салбарт орно. Ус хангамжийн үйл ажиллагаа ихэнхдээ бохир усыг цэвэрлэх, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байдаг ба аж ахуйн нэгжүүд эдгээр үйл ажиллагааг хамтруулан хийдэг байж болно.
49. **Барилга** Их барилга угсралт болон иргэний инженерийн байгууламж, байшин, барилгыг угсрах болон мэргэжсэн барилгын үйл ажиллагаа энэ салбарт багтана. Энд шинэ ажил, барилга засвар, нэмэлт болон жижиг засвар, угсармал барилга, барилгын талбай, түр зуурын чанартай барилга угсрах үйл ажиллагаа орно.
50. **Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ** Бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, тухайлбал хувирган өөрчлөхгүй худалдаалах, барааг худалдан авах явцад гарах үйлчилгээ мөн машин, мотоциклийн засвар, үйлчилгээ хамаарна.
51. **Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа** Хий дамжуулах хоолой, төмөр зам, авто зам, усан ба агаарын тээврийн тогтсон хуваарьтай, хуваарьгүй ачаа ба зорчигч тээвэрлэлт, агуулах, ачаа, тээшийн үйлчилгээ, автомашины зогсоол, гарааш зэрэг үйл ажиллагаа орно. Түүнчлэн, тээврийн хэрэгслийг ажиллуулагч хүнтэй нь түрээслэх үйл ажиллагаа энэ салбарт багтана. Мөн шуудан, холбооны үйл ажиллагаа орно.
52. **Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа** Түр зуурын зочин, бусад аялагчдыг богино хугацаагаар байр сууцаар хангах, шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа орно. Энэ салбарт тусгагдаж байгаа нэмэгдэл үйлчилгээний хэмжээ, төрөл нь нэлээд их байна.
53. **Мэдээлэл, холбоо** Энэ салбарт мэдээлэл, соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт, энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, тухайлбал холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах болон мэдээллийн үйлчилгээтэй холбоотой бусад үйл ажиллагаа орно.
54. **Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа** Даатгалын үйл ажиллагаа, давхар даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, мөн санхүүгийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагааг оруулан санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа энэ салбарт орно. Холдинг компани, траст, сан болон санхүүгийн бусад үйл ажиллагаа зэрэг холдинг хөрөнгийн үйл ажиллагаа энэ салбарт багтана.

55. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Энд лизингийн үйлчилгээ олгогчид, агентууд, брокеруудын үл хөдлөх хөрөнгө арилжаалах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, үнэлгээ хийх зэрэг үл хөдлөх хөрөнгийн бусад үйлчилгээ орно. Энэ салбарын үйл ажиллагаа нь төлбөр, гэрээний үндсэн дээр хийгдэж эзэмшигчийн эсвэл лизингээр авсан өмчийг ашиглах үйл ажиллагаа байж болно. Мөн энд эзэмшигчийн эсвэл лизингийн баригдаж байгаа барилга болон барилга, байгууламжийг оруулна. Энэ салбарт үл хөдлөх хөрөнгийн менежерийн үйл ажиллагаа багтана.
56. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Мэргэшсэн мэргэжил, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа энэ салбарт орно. Эдгээр үйл ажиллагаа нь өндөр төвшний сургалт, мэргэшсэн мэдлэг олгох, хэрэглэгчдэд ур чадвар олгох зэрэг байна.
57. Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Ерөнхий бизнесийн үйл ажиллагааг дэмжих төрөл бүрийн үйл ажиллагааг энд хамруулна.
58. Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Төрийн удирдлагаар хэрэгждэг үйл ажиллагаа орно. Үүнд хуулийн тайлбар, тогтоол ба тэдгээрийн зохицуулалт, тэдгээр дээр суурилсан үйл ажиллагаануудын удирдлага, хууль тогтоох үйл ажиллагаа, татвар, улсын батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа, цагаачлалын үйлчилгээ, гадаад харилцааны үйл ажиллагаа ба засгийн газрын хөтөлбөрүүдийн удирдлагын үйл ажиллагаа зэрэг орно. Мөн энэ салбарт албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа багтана.
59. Боловсрол	Энэ салбарт бүх шатны, бүх мэргэжлийн боловсролыг өдөр, орой, эгнээ хэлбэрээр анги, танхим, радио, телевиз болон бусад мэдээллийн хэрэгсэл, зайн сургалтаар дамжуулан олгосон боловсролын үйл ажиллагаа орно. Төрөл бүрийн сургалтын байгууллагын албан болон албан бус сургалт багтана. Түүнчлэн, насанд хүрэгчдийн боловсрол, бичиг үсэг тайлагдалтын хөтөлбөр зэрэг орно. Мөн бүх насны цэргийн сургууль, академи, хорихын сургууль хамрагдана.
60. Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Энэ салбарт эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа орно. Үйл ажиллагаанд нь эмнэлгийн анагаахын мэргэжилтнүүдэд эмнэлэг болон бусад сургалтын сургагдсан эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанаас эхлэн хүн амыг асрах үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээ болон заавал мэргэжлийн эмнэлгийн ажилтан бус нийгмийн ажилтны үйл ажиллагаа багтана.
61. Урлаг, үзвэр, тоглоом наадам	Энэ дэд салбарт өргөн цар хүрээг хамарсан төрөл бүрийн соёлын уулзалт, үзвэр болон олон нийтийг хамарсан сонирхолтой тоглоом наадам багтахын зэрэгцээ амьд үзүүлбэр, музейн үйлчилгээ, мөрийтэй спорт, амралт зугааллыг үйл ажиллагаа хамрагдана.
62. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Энэ салбарт байгууллагуудын гишүүнчлэлтэй холбоотой үйл ажиллагаа, компьютерын болон хувь хүн, өрхийн хэрэглээний барааны засвар үйлчилгээ орох бөгөөд өмнөх, бүлэг, ангид ороогүй хувь хүнтэй холбоотой төрөл бүрийн бусад үйлчилгээний үйл ажиллагаа орно.


- | | |
|---|--|
| 63. Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; Өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ | Гэрийн үйлчлэгч, тогооч, зөөгч, цэвэрлэгч, барлаг, шивэгчин, угаагч, цэцэрлэгч, манаач, малчин, ногоочин, байнгын харгалзагч, жолооч, хаалгач, гэрийн хүмүүжүүлэгч, хүүхэд асрагч, гэрийн багш, нарийн бичиг зэрэг ажил, үйлчилгээг айл, өрхөд цалин хөлстэйгээр хийх үйл ажиллагаа орно.
Энд зөвхөн өөрийн хэрэглээ, амь зуулгандаа зориулан, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй хэд хэдэн төрлийн бараа болон үйлчилгээ явуулдаг өрх хамрагдана. |
| 64. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | Энэ ангид Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн төлөөлөгчид, Олон улсын валютын сан, Дэлхийн Банк, Дэлхийн гаалийн байгууллага, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Нефть экспортлогч орнуудын байгууллага, Европын холбоо, Европын худалдааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагын үйл ажиллагаа орно. Тухайн улс оронд байрлаж буй дипломат болон консулын төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь аль улсыг төлөөлж байгаагаас үл хамааран энэ ангид мөн багтана. |

ОРОН СУУЦ

- | | |
|------------------------------------|---|
| 65. Орон сууцны байшин | Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. |
| 66. Бие даасан тохилог сууц | Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна. |
| 67. Сууцны тусдаа байшин | Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно. |
| 68. Оюутан сурагчдын нийтийн байр | Бүх шатны сургуулиудийн оюутан, сурагчдын хамтран амьдрахад зориулагдсан байр |
| 69. Ажиллагчдын нийтийн байр | Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид нийтээр амьдрахад зориулсан байр |
| 70. Нийтийн зориулалтын бусад байр | Амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байр |
| 71. Өрөөний тоо | Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно. |
| 72. Сууцны талбай (кв.метр) | Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө/ туслах өрөө, тасалгаа /гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах/-ны талбайн нийлбэр |

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ



ХҮН АМЫН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Монгол Улсын суурин хүн амын тоо 2010 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар 2754.7 мянга болов. Суурин хүн амаас гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд 107.1 мянга байна (1 дүгээр бүлгийн тооллогын үр дүн гэсэн хэсгийн тайлбарыг үзнэ үү). Мөн тус улсын нутаг дэвсгэрт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат иргэд, харьяалалгүй 16.4 мянган хүн оршин сууж байна.

ЗУРАГ 2.1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМЫН ТОО, 2010 ОН



Суурин хүн амын 49.5 хувь нь эрэгтэйчүүд, 50.5 хувь нь эмэгтэйчүүд байна. 2000 оны тооллогоор суурин хүн амын тоо 2373.5 мянга байв. 2000-2010 оны хоорондох 11 жил орчмын хугацаанд Монгол Улсын суурин хүн ам 381.2 мянган хүнээр өссөн нь 1989-2000 оны тооллого хоорондын өсөлтөөс 51.6 мянган хүнээр илүү юм.

ХҮСНЭГТ 2.1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1918	647.5	330.2	317.3	104.1
1935	738.2	370.8	367.4	100.9
1944	759.1	371.3	387.8	95.7
1956	845.5	420.3	425.2	98.8
1963	1017.1	508.0	509.1	99.8
1969	1197.6	597.4	600.2	99.5
1979	1595.0	798.9	796.1	100.4
1989	2044.0	1020.7	1023.3	99.7
2000	2373.5	1178.0	1195.5	98.5
2010	2754.7	1363.9	1390.8	98.1


Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) 2000 оны тооллогын төвшинд хэвээр хадгалагдаж байна. Ер нь хүйсийн харьцаа 1979 оноос хойш бага зэрэг буурч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байдагтай холбоотой.

ХҮН АМЫН ӨСӨЛТ

Хүн амын тооны өөрчлөлтийг төрөх, нас барах, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлдог. 2000-2010 оны хоорондох 11 жилийн хугацаанд хүн ам 16.1 хувиар өсч, жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь болж байна. Өсөлтийн энэ хувь өмнөх тооллого хоорондынхоос 0.1 пунктээр илүү байв.

Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Хүн ам 1950-иад оны дунд үе хүртэл жилд дунджаар 0.9 хувиас багаар өсч байснаа 1956 оноос огцом нэмэгдэж, 1989 он хүртэл жилд дунджаар 2.5 хувиас илүү өссөн байна (зураг 2.2). 1918-1935, 1935-1944 оны тооллого хоорондын хүн амын өсөлт бага байгаа нь 1930-аад оны их хэлмэгдүүлэлт, 1939 оны Халх голын дайн ба дэлхийн 2 дугаар дайн зэрэг нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас гадна хүн амын дунд тархсан өвчлөл их байснаас нас баралт өндөр, төрөлт бага байсантай холбоотой. 1956-1989 оны хооронд хүн ам жилд дунджаар 2.5-2.9 хувь тогтвортой өсч иржээ. Энэ нь ард түмний аж амьдрал үүний дотор, хүн амын эрүүл мэндийн төвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээгээр нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай холбоотой. Харин 1989-2000 оны тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт 1.4 хувь болсон нь өмнөх 10 жилийнхээс 1.1 пунктээр буурчээ. Энэ хугацаанд хүн амын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь гадаад шилжих хөдөлгөөн байлаа. 1989-1990 онд Монгол Улсад ажиллаж, амьдарч байсан хуучин Зөвлөлт Холбоот Улсын 50 шахам мянган иргэн нутаг буцаж, 1990-ээд оны дундуур 50 гаруй мянган казах иргэд Казахстан улсад хөдөлмөрийн гэрээтэй ажиллахаар явж, шилжин суурьшсаны зэрэгцээ манай улсын олон мянган залуучууд гадаадад хөдөлмөр эрхэлж, суралцах болсноос шалтгаалсан юм.

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН 1918-2010 ОНЫ ТООЛЛОГО ХООРОНДЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ХУВИАР



2000-2010 оны тооллого хоорондын жилийн дундаж өсөлт нь өмнөх 11 жилийнхээс арай нэмэгдсэн нь хүн амын ердийн өсөлтөөс хамаарчээ. Тус улсад 2000-2010 онд нийтдээ 583.8 мянган хүүхэд төрж, 179.4 мянган хүн нас барж, ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт 404.5 мянга хүн болсон байна.

ХҮСНЭГТ 2.2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2000-2010 ОН

Он	Ерөнхий коэффициент		
	Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
2000	20.4	6.5	13.9
2001	20.5	6.6	13.9
2002	19.1	6.4	12.6
2003	18.4	6.4	11.9
2004	18.1	6.5	11.6
2005	18.0	6.5	11.5
2006	19.0	6.5	12.6
2007	21.7	6.2	15.4
2008	24.0	5.6	18.2
2009	25.5	6.2	19.3
2010	22.9	6.6	16.3

Төр засгаас хэрэгжүүлсэн нийгмийн халамжийн арга хэжээний дүнд 2006-2009 онд төрөлт өмнөх жилүүдийнхээс нэлээд нэмэгдэж, хүн амын өсөлтөд эерэг нөлөөлсөн юм.

ХҮСНЭГТ 2.3. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР 1979-1989, 1989-2000, 2000-2010 ОН

Аймаг, нийслэл	1989/1979 (%)	2000/1989 (%)	2010/2000 (%)	Жилийн дундаж өсөлт (%)		
				1979-1989	1989-2000	2000-2010
БҮГД	128.2	116.1	116.06	2.51	1.37	1.46
Архангай	109.0	114.9	87.12	0.86	1.27	-1.17
Баян-Өлгий	127.5	100.2	96.69	2.46	0.02	-0.30
Баянхонгор	118.4	113.7	89.75	1.70	1.17	-0.93
Булган	122.9	119.0	86.85	2.08	1.59	-1.20
Говь-Алтай	112.4	101.4	84.16	1.17	0.13	-1.44
Дорноговь	137.2	88.6	115.89	3.22	-1.10	1.44
Дорнод	138.5	93.0	92.28	3.31	-0.66	-0.70
Дундговь	126.9	104.5	75.36	2.41	0.40	-2.24
Завхан	110.7	101.7	72.76	1.03	0.15	-2.48
Өвөрхангай	117.1	115.4	90.93	1.59	1.31	-0.82
Өмнөговь	128.9	110.4	130.85	2.57	0.90	2.80
Сүхбаатар	117.8	110.5	91.40	1.65	0.91	-0.78
Сэлэнгэ	136.7	114.9	97.63	3.17	1.27	-0.22
Төв	125.3	99.2	85.79	2.28	-0.07	-1.29
Увс	116.7	107.2	81.44	1.55	0.64	-1.69
Ховд	122.3	113.4	88.53	2.04	1.15	-1.04
Хөвсгөл	115.1	116.9	96.53	1.41	1.43	-0.32
Хэнтий	141.8	96.1	92.76	3.55	-0.36	-0.66
Дархан-Уул	192.4	97.1	113.63	6.77	-0.26	1.24
Улаанбаатар	142.6	138.6	163.15	3.61	3.01	5.74
Орхон	356.0	127.4	126.81	13.54	2.23	2.44
Говьсүмбэр	-	-	108.26	-	-	0.75

Тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойших аймаг, нийслэлийн хүн амын өсөлт эрс тэс ялгаатай болсон нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Энэ нь гагцхүү шилжих хөдөлгөөнтэй холбоотой гэж үзэж болно. Учир нь хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент бүх аймагт сүүлчийн 10 жилд дунджаар 14-20 промилл байсан. 2000-2010 онд хүн амынх нь өсөлт бусад аймгаас хамгийн өндөр хувиар буурсан Завхан аймгийн хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент сүүлчийн 10 жилд 14.0-18.2 промилл, Дундговь аймгийнх 12.0-20.0 промиллын хооронд хэлбэлзэж байжээ.

Аймгуудын хүн амын тооллого хоорондын жилийн дундаж өсөлтийн дүр төрх 1989-2000 онд өмнөх 10 жилийнхээс нэлээд ялгаатай, тухайлбал 1979-1989 онд бүх аймаг, нийслэлийн хүн ам жигд шахуу өсч байсан бол 1989-2000 онд 5 аймгийн хүн ам өмнөхөөс буурсан. Гэтэл 2000-2010 онд нийслэл, 5 аймгийн хүн амын тоо өсч, бусад бүх аймгийн хүн амын тоо буурчээ. Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас өндөр байна. Ялангуяа, Улаанбаатар

хотын хүн амын өсөлт улсын дунджаас бараг 4 дахин өндөр байгаа нь нийслэл рүү чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой. Улаанбаатар хотод сүүлчийн 5 жилд бусад аймгаас 185.5 мянга, сүүлчийн нэг жилийн дотор 61.3 мянга, Орхон аймагт сүүлчийн 5 жилд 14.6 мянган хүн шилжин суурьшжээ. Харин Дархан-Уул аймгийн хүн амын тоо 1989-2000 онд буурч байсан бол шилжих хөдөлгөөний нөлөөгөөр сүүлчийн 11 жилд өсөв. /Дотоод шилжих хөдөлгөөний дүр төрхийг “Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт” гэсэн 5-р бүлгээс үзнэ үү/.

ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Нийт хүн амын тоонд насны бүлэг тус бүрийн хүн амын эзлэх хувийн жин 2010 онд 2000 оныхоос зарим насанд өөрчлөгдөв. Тухайлбал, 0-4 насанд 2000 оныхоос бага зэрэг өссөн нь 2006-2009 онуудад төрөлт нэмэгдсэнтэй холбоотой. Харин 5-19 насны бүлэг дэх хүн амын хувийн жин өмнөх 10 жилийнхээс буурсан нь 2005 оноос өмнөх жилүүдэд төрөлт бага байсан (Төрөлтийн ерөнхий коэффициент 2001-2005 онд 19 орчим промилл)-тай холбон тайлбарлаж болох юм.

ХҮСНЭГТ 2.4. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	2000		2010		Хүйсийн харьцаа ¹	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2000	2010
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	98.5	98.1
0-4	10.6	10.2	10.9	10.4	102.4	103.2
5-9	12.3	11.8	8.2	7.7	102.1	103.8
10-14	13.5	13.2	8.9	8.5	100.8	102.8
15-19	11.3	10.9	9.9	9.5	102.5	102.4
20-24	10.0	9.8	11.6	11.1	100.3	101.7
25-29	9.2	9.1	9.9	9.6	99.4	100.4
30-34	7.9	8.0	8.8	8.6	97.0	99.6
35-39	7.2	7.3	7.8	7.8	96.6	97.7
40-44	5.3	5.4	6.7	6.9	96.9	95.9
45-49	3.4	3.5	5.8	6.0	96.0	94.4
50-54	2.4	2.5	4.3	4.7	92.0	90.1
55-59	2.3	2.4	2.5	2.8	96.1	86.2
60-64	1.8	1.8	1.6	2.0	96.7	80.7
65-69	1.4	1.6	1.3	1.5	82.5	82.2
70+	1.5	2.4	0.0	0.0	64.0	66.8

¹ 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо


Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь зүй ёсны үзэгдэл бөгөөд тооллогын мэдээллийн чанар сайн байгааг харуулж байна. Дэлхийн хүн ам зүйн олон жилийн судалгаанаас үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа дунджаар 104-106 хооронд байдаг зүй тогтолтой. Монгол Улсад төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа сүүлчийн 5 жилд 103-104 байсан нь тооллогын дүнгээс харагдаж байна. Олон улсын жишиг хандлагаас үзэхэд амьдралын эхний жилүүдэд эрэгтэй хүүхдийн нас баралт илүү байж, цаашдаа хүйсийн харьцаа тэнцвэржиж байснаа нас ахих тутам буурдаг ажээ.

Манай улсын нийт хүн амд 20-24 насныхны эзлэх хувь өндөр байгаа нь 1980-аад онд төрөлт өндөр байсныг гэрчилнэ.

Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй илүү байдагтай холбоотой бөгөөд үүнийг ахимаг насны бүлэгт, жишээлбэл, 70, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 64, 66 болж огцом буурч байгаагаас харж болно. Насны бүлэг дэх хүйсийн харьцаа нь төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжих хөдөлгөөнөөс шалтгаалдаг.

Нас, хүйсийн бүтцийг харуулах өөр нэг гол үзүүлэлт бол хүн амын нас, хүйсийн суварга билээ.

ЗУРАГ 2.3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН



Хүн амын ердийн хөдөлгөөний өөрчлөлтөөс шалтгаалан 20-иос доош насанд суваргын хэлбэр өөрчлөгдөж байна. Тухайлбал, 2000 оны суваргын суурь нэлээд нарийссан нь 1990-ээд оны дунд үеийн төрөлтийн бууралттай холбоотой бол 2010 оны суваргын 5-14 насанд нарийсч байгаа нь 2001-2005 онуудад төрөлт буурснаас шалтгаалсан. Төрөлтийн ерөнхий коэффициент 2000 онд 20 байсан бол 2003-2005 онд 18 болж буурсан байна. Харин 2010 оны суваргын суурь 0-4 насанд өргөн байгаа нь 2006-2009 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой билээ.

Хорин таваас дээш насанд суваргын хэлбэр аажмаар нарийсч байгаа нь 1990-ээд оноос өмнө төрөлт тогтмол өндөр байж, насны бүлэг ахих тутам нас баралтын нөлөөгөөр тухайн насны хүн амын тоо буурч байгаагаар тайлбарлагдана.

Аймаг, нийслэлийн хүн амын хүйсийн харьцаа 2000 онтой ижил төвшинд байна (хүснэгт 2.5). Өмнөговь, Говьсүмбэр, Булган, Дундговь, Хэнтий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод аймгийн хүн амын хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс нэмэгдсэн нь шилжих хөдөлгөөнөөс шалтгаалжээ. Ялангуяа, Өмнөговь аймагт хүйсийн харьцаа 33 пунктээр нэмэгдсэн нь уул уурхайн хайгуул, үйлдвэрлэлийг дагаж эрэгтэйчүүд олноороо шилжин суурьшиж байгаатай холбоотой. Цаашид энэ асуудлыг гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй. Ийм байдалтай удвал тус аймгийн хүн ам зүйн асуудалд сөрөг нөлөө үүсэхийг үгүйсгэх аргагүй.

ХҮСНЭГТ 2.5. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙС,
ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2000, 2010 ОН

Аймаг, нийслэл	2000 он			2010 он			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2000	2010
БҮГД	2 373 493	1 177 981	1 195 512	2754685	1363923	1390762	98.5	98.1
Архангай	97 091	48 579	48 512	84583	42218	42365	100.1	99.7
Баян-Өлгий	91 068	45 813	45 255	88056	44127	43929	101.2	100.5
Баянхонгор	84 779	42 037	42 742	76085	38237	37848	98.4	101.0
Булган	61 776	31 153	30 623	53653	27621	26032	101.7	106.1
Говь-Алтай	63 673	31 492	32 181	53591	26830	26761	97.9	100.3
Дорноговь	50 575	25 515	25 060	58612	29537	29075	101.8	101.6
Дорнод	75 373	37 639	37 734	69552	35134	34418	99.7	102.1
Дундговь	51 517	25 719	25 798	38820	19727	19093	99.7	103.3
Завхан	89 999	45 032	44 967	65481	32916	32565	100.1	101.1
Өвөрхангай	111 420	55 578	55 842	101314	50879	50435	99.5	100.9
Өмнөговь	46 858	23 488	23 370	61314	35137	26177	100.5	134.2
Сүхбаатар	56 166	28 585	27 581	51334	26165	25169	103.6	104.0
Сэлэнгэ	99 949	51 067	48 882	97584	49624	47960	104.5	103.5
Төв	99 268	51 374	47 894	85168	44395	40773	107.3	108.9
Увс	90 037	45 512	44 525	73328	37049	36279	102.2	102.1
Ховд	86 831	43 213	43 618	76869	38366	38503	99.1	99.6
Хөвсгөл	119 063	59 060	60 003	114924	57192	57732	98.4	99.1
Хэнтий	70 946	35 651	35 295	65811	33633	32178	101.0	104.5
Дархан-Уул	83 271	40 844	42 427	94620	46486	48134	96.3	96.6
Улаанбаатар	760 077	369 146	390 931	1240048	597347	642701	94.4	92.9
Орхон	71 525	35 320	36 205	90699	44488	46211	97.6	96.3
Говьсүмбэр	12 230	6 163	6 067	13239	6815	6424	101.6	106.1


Хот, хөдөөд хүн амын хүйсийн харьцаа эрс ялгаатай байна. Хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа улсын дунджаас нэлээд өндөр байгаа нь хөдөөнөөс хот руу гол төлөв эмэгтэйчүүд илүү шилжиж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2.6. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2000, 2010 ОН

Хот, хөдөө	2000 он			2010 он		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
Улсын дундаж	1 177 981	1 195 512	98.5	1 313 968	1 333 577	98.1
Хот	657 081	687 435	95.6	915 799	975 953	94.0
Хөдөө	520 900	508 077	102.5	448 124	414 809	108.0

Монгол Улсын хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгааг зураг 2.4-өөс харж болно. Гэхдээ нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин тооллогоос тооллогод багасч байгаа нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс төрөлт буурсаар байгаатай холбоотой. Төрөлт сүүлчийн 20-иод жилийнх шиг тасралтгүй буурвал хүн амын насны бүтэц удахгүй өөрчлөгдөх хандлагатай болохоор байна.

ЗУРАГ 2.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ХУВИАР, 1989, 2000, 2010 ОН



Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа тэр зааг насыг голч нас гэсэн ойлголтоор илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, 2010 онд голч нас 25.8 болсон нь хүн амын тэн хагас нь 25.8-аас доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна гэсэн үг юм. Голч нас 1989 оноос хойш тогтвортой нэмэгдэж байгаа нь төрөлтийн бууралттай холбоотой (хүснэгт 2.7).

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэдэг. Энэхүү үзүүлэлт нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хүний хүчин зүйл, тэр дундаа, насны бүтэц хэр нөлөөлж байгааг харуулдаг.

ХҮСНЭГТ 2.7. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1989, 2000, 2010 ОН

Үзүүлэлтүүд	1989	2000	2010
Голч нас /жилээр/	18.8	21.6	25.8
Хүн ам зүйн ачаалал /хувиар/	84.9	64.6	45.0
Үүнээс:			
Хүүхэд	77.4	58.9	39.6
Хөгшид	7.5	5.7	5.4
Хөгшрөлтийн индекс	9.7	9.7	13.6

Манай улсын хүн ам зүйн ачаалал 2010 онд 1989 оныхоос бараг 2 дахин буурсан нь ажлын байр олноор нэмэгдсэн нөхцөлд түүнд ажиллах хөдөлмөрийн насны хүний нөөц хангалттай байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын хүн амын тоо 2000-2010 оны хооронд жилд дунджаар 1.5 хувиар өссөн нь өмнөх тооллого хоорондхоос 0.1 пунктээр илүү юм. Энэ нь хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт сүүлчийн арван жилд өмнөхөөсөө илүү байсан болон 1990-ээд оны эхний хагасынхтай адил гадаадад шилжих хөдөлгөөн гараагүйтэй холбоотой.

Аймгуудын хүн амын тооллого хоорондын жилийн дундаж өсөлтийн дүр төрх өмнөх 10 жилийнхтэй ерөнхийдөө төстэй. 2000-2010 онд 6 аймаг, нийслэлээс бусад бүх аймгийн хүн амын тоо багассан нь шилжих хөдөлгөөнөөс хамаарч байна.

Хүн амын насны бүтцэд зарим өөрчлөлт гарчээ. Тухайлбал, нийт хүн амд эзлэх хувийн жин 0-4 насанд 2000 оныхоос бага зэрэг өсөв. Энэ нь 2006-2009 онуудад төрөлт нэмэгдсэнтэй холбоотой. Харин 2005 оноос өмнөх жилүүдэд төрөлт бага байснаас хамаарч 5-19 насны бүлэг дэх хувийн жин буурсан байна.

Хүйсийн харьцаа дүнгээрээ өмнөх тооллогын үеийнхтэй ижил төвшинд байгаа боловч, насны бүлэг ахих тутам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байдагтай холбоотой. Харин Өмнөговь аймгийн хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс 33 пунктээр нэмэгдсэн нь уул уурхайн хайгуул, үйлдвэрлэлийг дагаж эрэгтэйчүүд олноороо шилжин суурьшиж байгаагаас шалтгаалжээ. Цаашид энэ асуудлыг гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй.

Монгол Улсын хүн ам залуу насны бүтэцтэй хэвээр байгаа боловч нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин тооллогоос тооллогод багасч байгаа нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс төрөлт буурсаар байгаатай холбоотой.

Хүн ам зүйн ачаалал 2010 онд 2000 оныхоос 19.6 пунктээр буурч, хүн амын насны бүтцийн ийм тааламжтай үе тохиож байгаатай холбогдуулан ажлын байрыг олноор нэмэгдүүлбэл ажиллах хүчний хангалттай нөөц байгааг харуулж байна.

ГУРАВЛУГААР БҮЛЭГ

УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС УГСАА, ШАШИН



ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ


Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа суурин хүн амын 99.4 хувь нь Монгол Улсын харьяат, 0.6 хувь нь гадаадын харьяат иргэн байна. Аль нэг улсын харьяалалгүй хүн 108 байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬААЛЛААР, 2010 ОН



Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн тоо 2000 оныхоос 2 дахин өсчээ. Гадаадын харьяат иргэдийн дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 8.7 мянга буюу нийт гадаадын харьяат иргэдийн 53.2 хувийг, Оросын Холбооны Улсын иргэн 2.5 мянга буюу 15.2 хувийг, Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн 1.5 мянга буюу 9.3 хувийг, Америкийн Нэгдсэн Улсын иргэн 0.7 мянга буюу 4.0 хувийг тус тус эзэлж байгаа нь бусад орнуудынхаас олон юм. БНХАУ, БНСУ-ын харьяат иргэд өмнөх тооллогын үеийнхээс 2 илүү дахин нэмэгдэж, харин ОХУ-ынх бараг 3 дахин буурчээ.

ЗУРАГ 3.2. МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭД, УЛСААР, ХУВИАР, 2000, 2010 ОН



Нийслэлд оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхтэй ойролцоо буюу 2000 онд нийт гадаадын харьяат иргэдийн 56.2 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2010 онд 56.7 хувь байна. Улсын хүн амын 43.5 хувь нь нийслэлд амьдарч байгаатай зэрэгцүүлэхэд дээрх хувь нэлээд өндөр юм. Харин уул уурхайн хайгуул, үйлдвэрлэлийг дагаж нийт гадаадын харьяат иргэдийн 24.0 хувь нь Өмнөговь аймагт оршин сууж байгаа нь өмнөх тооллогын үеэс эрс ялгаатай байна. Өмнөговь аймагт улсын хүн амын дөнгөж 2.3 хувь нь амьдарч байхад аймгийн хүн амын 6.4 хувийг гадаадын харьяат иргэд эзэлж байна. Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын харьяат иргэдийн 89.1 хувь нь нийслэл, Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт амьдарч байна.

ХҮСНЭГТ 3.1. МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Аймаг, нийслэл	2000		2010	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	8 128	100.0	16 320	100.0
Архангай	13	0.2	21	0.1
Баян-Өлгий	53	0.7	71	0.4
Баянхонгор	10	0.1	43	0.3
Булган	14	0.2	42	0.3
Говь-Алтай	2	0.0	8	0.0
Дорноговь	101	1.2	319	1.9
Дорнод	87	1.1	284	1.7
Дундговь	11	0.1	28	0.2
Завхан	16	0.2	45	0.3
Өвөрхангай	11	0.1	21	0.1
Өмнөговь	8	0.1	3 913	24.0
Сүхбаатар	1	0.0	156	1.0
Сэлэнгэ	225	2.8	323	2.0
Төв	217	2.7	183	1.1
Увс	4	0.0	32	0.2
Ховд	19	0.2	191	1.2
Хөвсгөл	13	0.2	41	0.2
Хэнтий	580	7.1	240	1.5
Дархан-Уул	326	4.0	255	1.6
Улаанбаатар	4 566	56.2	9 254	56.7
Орхон	1 842	22.7	807	4.9
Говьсүмбэр	9	0.1	43	0.3


Гадаадын харьяат иргэдийн насны бүтцийг Монгол Улсын хүн амын насны бүтэцтэй харьцуулахад ялгаатай байна. Монгол Улсад амьдарч байгаа гадаадын харьяат 2 хүн тутмын нэг нь 25-44 насныхан байна. Энэ нь гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насны хүн ам байгааг харуулна. Харин гадаадын харьяат иргэдийн дунд 0-14, 15-24 насны хүн амын эзлэх хувь нийт хүн амтай харьцуулахад бага байна. Онцлох нэг зүйл нь гадаадын харьяат иргэдийн хүйсийн харьцаа Монгол Улсынхаас эрс ялгаатай, гол төлөв эрэгтэйчүүд ирж суурьшдаг аж.

ХҮСНЭГТ 3.2. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Суурин хүн амын насны бүтэц	Гадаадын харьяат иргэд			
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	284.3
0-14	28.0	7.9	5.6	14.4	110.1
15-24	20.8	12.3	10.5	17.3	173.1
25-34	17.8	21.8	22.4	20.3	313.5
35-44	14.4	28.3	31.8	18.5	487.9
45-54	10.6	20.0	21.2	16.6	362.8
55+	8.4	9.7	8.5	12.9	188.7

Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын харьяат иргэдийн 36.1 хувь нь дээд боловсролтой, 50.2 хувь нь бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой, 3,6 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 3.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2010 ОН



Гадаадын харьяат иргэдийн 83.8 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 7.1 хувь нь ажил олгогч, 6.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Нийт ажил олгогч гадаадын харьяат иргэдийн 46.9 хувь нь БНХАУ, 26.1 хувь БНСУ-ын харьяат иргэд байгаа нь тухайн улсын харьяат иргэдийн 5.4 хувь, 29.8 хувийг тус тус эзэлж байна. Харин тэдний ажил эрхлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал 32.5 хувь нь барилга, 24.9 хувь нь уул уурхайн хайгуул, олборлолтын салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 3.4. ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУВИАР, 2010 ОН



ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор Монгол Улсын харьяат иргэдийн үндэс угсааны талаарх мэдээллийг цуглуулахдаа өмнөх тооллогоос дэлгэрэнгүй бүлгээр авсан. Өмнөх тооллогод үндэс угсааг 27 бүлэг байсныг 29 болгож өргөжүүлсэн. Тооллогын үр дүнгийн танилцуулгад 100-аас цөөн хүн амтай бүлгийг “Бусад” гэж нэгтгэсэн болно.

ХҮСНЭГТ 3.3. МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2000, 2010 ОН

Үндэс угсаа	2000		2010 ¹	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ- БҮГД	2 365 269	100.0	2 631 117	100.0
Халх	1 934 674	81.8	2 168 141	82.4
Казак	102 983	4.4	101 526	3.9
Дөрвөд	66 706	2.8	72 403	2.8
Баяд	50 824	2.1	56 573	2.2
Буриад	40 620	1.7	45 087	1.7
Захчин	29 766	1.3	32 845	1.2
Дарьганга	31 909	1.3	27 412	1.0
Урианхай	25 183	1.1	26 654	1.0
Дархад	19 019	0.8	21 558	0.8
Өөлд	14 634	0.6	15 520	0.6
Хотогойд	7 237	0.3	15 460	0.6
Торгууд	12 628	0.5	14 176	0.5
Хотон	9 014	0.4	11 304	0.4
Мянгад	6 082	0.3	6 592	0.3
Тува	4 778	0.2	5 169	0.2
Барга	2 506	0.1	2 989	0.1
Үзэмчин	2 386	0.1	2 577	0.1
Элжигэн	151	0.0	1 340	0.1
Сартуул	1 540	0.1	1 286	0.0
Хамниган	565	0.0	537	0.0
Цаатан	303	0.0	282	0.0
Узбек	380	0.0	260	0.0
Харчин	266	0.0	152	0.0
Цахар	123	0.0	132	0.0
Бусад	338	0.0	601	0.0
Бусад үндэстэн	654	0.0	541	0.0

¹ Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

Монгол Улсын харьяат суурин хүн амын 82.4 хувийг халхчууд эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 0.6 пунктээр өссөн байна. Казахуудын эзлэх хувийн жин өнгөрсөн 10 гаруй жилд 0.5 пунктээр буурч, 3.9 хувийг эзэлж байгаа нь халхчуудын дараа орж байна. Дөрвөд, Баяд, Буриад, Захчингуудын эзлэх хувийн жин өөрчлөгдөөгүй бол, Дарьгангачуудын эзлэх хувийн жин бага зэрэг буурч Хотогойдуудынх нэлээд өссөн байна.

ХҮСНЭГТ 3.4. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010 ОН

Үндэс угсаа	Насны бүлэг						
	Бүгд	0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ- БҮГД	100.0	28.1	20.8	17.8	14.3	10.6	8.4
Халх	100.0	27.7	21.0	18.0	14.4	10.6	8.3
Казак	100.0	35.5	20.8	16.2	12.2	8.3	7.0
Дөрвөд	100.0	29.5	20.8	16.6	14.2	10.5	8.4
Баяд	100.0	29.6	20.4	16.5	14.3	10.3	8.9
Буриад	100.0	24.4	19.1	17.2	14.1	12.8	12.4
Захчин	100.0	30.5	20.7	16.5	13.2	10.0	9.1
Дарьганга	100.0	26.2	17.1	17.1	15.6	12.2	11.8
Урианхай	100.0	28.5	19.8	16.7	14.5	10.7	9.8
Дархад	100.0	30.1	20.7	16.1	14.1	10.8	8.2
Өөлд	100.0	25.2	20.0	17.2	14.7	11.5	11.4
Хотогойд	100.0	29.7	18.1	17.4	14.2	10.8	9.8
Торгууд	100.0	27.1	19.9	16.6	14.8	11.9	9.7
Хотон	100.0	38.0	21.2	15.7	11.5	7.7	5.9
Мянгад	100.0	28.6	19.8	17.0	14.8	10.4	9.4
Тува	100.0	31.2	20.5	16.3	13.2	9.9	8.9
Барга	100.0	22.4	20.8	18.4	14.8	12.3	11.3
Үзэмчин	100.0	27.1	20.1	17.6	13.5	11.5	10.2
Элжигэн	100.0	33.2	14.9	17.5	15.0	10.7	8.7
Сартуул	100.0	20.3	18.6	20.2	16.7	12.1	12.1
Хамниган	100.0	23.1	14.0	16.2	15.6	14.3	16.8
Цаатан	100.0	29.8	18.1	16.7	13.5	9.9	12.0
Узбек	100.0	32.3	17.7	17.7	12.3	9.6	10.4
Харчин	100.0	21.7	18.4	13.2	16.5	11.8	18.4
Цахар	100.0	18.9	15.9	16.7	10.6	21.2	16.7
Бусад	100.0	22.3	19.3	17.5	12.8	13.1	15.0
Бусад үндэстэн	100.0	26.4	14.2	15.7	13.7	12.4	17.6

Хотон, казахуудын дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувийн жин тус бүр 38.0, 35.5 хувь байж, бусдаас нэлээд өндөр байгаа нь тэдний дунд төрөлт өндөр байгаатай холбоотой юм. Харин Цахар, Хамниган, Харчингуудын дунд 45-аас дээш настай хүний эзлэх хувийн жин 30 хувиас илүү байгаа нь насжилтыг илэрхийлж байна.

Байршлын хувьд Халхчууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байгаагийн дотор Баян-Өлгий аймагт хамгийн цөөн буюу тухайн аймгийн нийт хүн амын 0.5 хувийг,

харин Баянхонгор, Дундговь, Завхан, Өвөрхангай аймгийн нийт хүн амын 99-өөс дээш хувь нь халхчууд байна. Олон угсаатны өлгий нутаг Ховд аймгийн нийт хүн амын дотор Захчин 26.0 хувь, Халх 25.7 хувь, Казах 11.9 хувь, Урианхай, Торгууд тус бүр 8.2 хувь, Дөрвөд 6.8 хувь, Өөлд 6.5 хувь, Мянгадууд 4.9 хувь байгаа нь бусад аймгаас онцлог юм. Дөрвөдүүдийн 42.9, Баядуудын 45.4 хувь нь Увс аймагт оршин суудаг нь тухайн аймгийн нийт хүн амын 42.6, 35.2 хувийг тус тус эзэлж байна. Сүхбаатар аймгийн нийт хүн амын 42.2 хувийг Дарьгангачууд эзэлж байгаа нь нийт дарьгангачуудын 78.4 хувь нь юм. Мөн Дорнод аймгийн нийт хүн амын 2.9 хувь нь Баргууд, 2.7 хувь нь Үзэмчингүүд байгаа нь эдгээр угсаатны хамгийн олноороо суудаг аймаг бөгөөд тухайн угсаатны бүлгийн 66.5 ба 72.0 хувийг тус тус төлөөлж байна. Хотогойдуудын 84.6 хувь нь зөвхөн Хөвсгөл аймагт оршин суудаг ба энэ нь тухайн аймгийн нийт хүн амын 11.4 хувь ажээ.

ХҮСНЭГТ 3.5. ХҮН АМЫН ТАРХАН СУУРШИЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010 ОН


Аймаг, нийслэл	Монгол Улсын харьяат - Бүгд	Халх	Казах	Дөрвөд	Буриад	Баяд	Дарьганга	Урианхай	Захчин
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	3.2	3.7	0.0	0.2	0.1	0.2	0.0	0.0	0.1
Баян-Өлгий	3.2	0.0	75.6	1.1	0.0	0.0	0.0	19.9	0.2
Баянхонгор	2.9	3.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.1
Булган	2.0	2.3	0.0	0.4	1.9	1.5	0.1	0.3	0.2
Говь-Алтай	2.0	2.4	0.2	0.1	0.0	0.1	0.0	0.2	0.4
Дорноговь	2.2	2.6	0.1	0.2	0.5	0.2	1.3	0.4	0.2
Дорнод	2.6	2.1	0.1	0.5	35.4	0.2	3.1	0.3	0.5
Дундговь	1.5	1.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Завхан	2.5	3.0	0.1	0.1	0.0	0.1	0.0	0.0	0.1
Өвөрхангай	3.8	4.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1
Өмнөговь	2.2	2.6	0.0	0.3	0.3	0.2	0.1	0.2	0.2
Сүхбаатар	1.9	1.3	0.0	0.0	0.3	0.1	78.4	0.0	0.0
Сэлэнгэ	3.6	3.7	0.9	4.5	2.7	6.2	0.1	7.6	3.5
Төв	3.2	3.6	0.9	1.7	1.8	2.0	0.1	1.8	1.0
Увс	2.8	0.4	0.1	42.9	0.1	45.4	0.0	0.4	0.2
Ховд	2.9	0.9	8.9	7.1	0.1	0.5	0.0	23.4	60.3
Хөвсгөл	4.3	3.6	0.0	0.1	2.3	0.1	0.1	12.0	0.1
Хэнтий	2.5	2.6	0.5	0.5	12.1	0.2	1.0	2.9	0.1
Дархан-Уул	3.4	3.4	2.4	5.6	2.4	6.9	0.3	3.9	4.9
Улаанбаатар	43.5	47.8	9.7	31.3	38.2	32.5	15.0	23.0	26.2
Орхон	3.3	3.5	0.6	2.9	1.6	3.1	0.2	3.5	1.7
Говьсүмбэр	0.5	0.6	0.1	0.2	0.1	0.4	0.1	0.1	0.1

Аймаг, нийслэл	Дархад	Торгууд	Өөлд	Хотон	Мянгад	Барга	Үзэмчин	Харчин	Цахар
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	0.1	0.1	16.4	0.3	0.1	0.2	0.1	0.0	3.0
Баян-Өлгий	0.0	0.3	0.3	0.1	0.2	0.0	0.0	0.7	0.0
Баянхонгор	0.0	0.1	0.4	0.0	0.2	0.4	0.0	5.3	0.0
Булган	0.8	0.1	0.5	0.7	0.4	0.2	0.0	0.0	0.0
Говь-Алтай	0.0	0.3	0.4	0.2	0.3	0.1	0.0	0.0	1.5
Дорноговь	0.1	0.4	0.6	0.1	0.3	1.0	0.3	2.0	1.5
Дорнод	1.0	0.7	0.3	0.3	0.6	66.5	72.0	3.9	2.3
Дундговь	0.0	0.0	0.1	0.0	0.1	0.1	0.0	1.3	0.0
Завхан	0.0	0.2	0.2	0.0	0.5	0.7	0.0	0.0	0.0
Өвөрхангай	0.0	0.0	0.2	0.1	0.3	0.5	0.0	4.6	0.0
Өмнөговь	0.1	0.2	0.6	0.2	0.3	0.3	0.0	3.9	0.0
Сүхбаатар	0.0	0.1	0.1	0.0	0.1	0.7	12.4	0.0	0.0
Сэлэнгэ	1.8	4.3	1.3	14.4	2.0	0.3	0.2	0.7	34.1
Төв	0.5	1.0	1.4	0.4	0.5	1.6	0.5	5.3	1.5
Увс	0.0	0.2	0.4	47.6	2.7	0.0	0.1	0.7	0.0
Ховд	0.1	44.1	32.1	0.5	57.0	0.3	0.0	2.0	0.0
Хөвсгөл	82.2	0.1	0.4	0.2	0.3	0.3	0.1	5.9	2.3
Хэнтий	0.2	0.1	0.3	0.1	0.1	1.5	0.3	0.0	0.0
Дархан-Уул	1.2	6.3	3.1	5.6	1.9	0.9	0.3	8.6	3.0
Улаанбаатар	9.1	40.3	38.9	11.9	29.7	23.6	12.8	52.0	49.2
Орхон	2.6	0.8	2.2	17.3	2.3	0.2	0.7	2.6	1.5
Говьсүмбэр	0.0	0.2	0.0	0.1	0.1	0.3	0.0	0.7	0.0

Аймаг, нийслэл	Хотогйд	Элжигэн	Цаатан	Сартуул	Тува	Узбек	Хамниган	Бусад	Бусад үндэстэн
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	0.1	0.5	0.4	0.7	0.0	0.0	0.0	0.5	0.4
Баян-Өлгий	0.0	0.0	0.0	2.8	30.3	14.2	2.6	7.0	0.0
Баянхонгор	0.0	0.0	0.0	3.5	0.0	0.0	0.0	2.0	0.4
Булган	0.2	0.0	0.0	0.8	0.0	0.0	0.0	0.0	3.1
Говь-Алтай	0.0	0.0	0.0	0.2	0.1	0.4	0.0	0.3	0.0
Дорноговь	0.1	0.0	0.0	0.8	0.2	0.0	0.0	0.2	1.3
Дорнод	0.1	0.0	1.1	0.5	0.2	0.0	18.1	2.8	1.3
Дундговь	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.7	0.6
Завхан	0.2	0.0	0.4	2.0	0.0	0.0	0.0	0.0	0.4
Өвөрхангай	0.0	0.0	1.1	1.6	0.0	0.4	0.0	0.0	0.9
Өмнөговь	0.1	0.0	0.0	0.1	0.0	0.0	1.1	0.7	0.7
Сүхбаатар	0.0	0.0	0.0	0.3	0.0	0.0	0.0	30.9	2.6
Сэлэнгэ	0.8	0.2	1.4	3.7	17.7	1.2	0.9	2.3	5.5
Төв	0.5	0.7	0.0	6.1	10.1	1.5	0.9	1.2	4.6
Увс	0.1	93.3	1.1	17.5	0.2	1.9	0.7	2.0	5.5
Ховд	0.1	0.1	0.4	1.5	12.4	66.2	0.6	6.2	1.5
Хөвсгөл	84.6	1.2	86.5	2.1	3.7	0.0	0.0	0.8	1.1
Хэнтий	0.1	0.0	0.4	1.7	0.3	0.0	49.9	3.2	0.7
Дархан-Уул	1.0	0.1	1.4	2.3	10.8	5.8	1.7	2.8	2.6
Улаанбаатар	10.6	3.9	6.0	45.7	10.8	5.8	23.1	35.4	64.1
Орхон	1.4	0.1	0.0	5.8	3.0	2.7	0.4	0.8	2.6
Говьсүмбэр	0.0	0.0	0.0	0.5	0.2	0.0	0.0	0.2	0.0

Дархад, Хотогойд, Тува, Элжигэн, Хамниган, Цаатан зэрэг угсаатан гол төлөв хөдөө суурьшиж байгааг дараах зургаас харж болно.

ЗУРАГ 3.5. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Хотон, Казах, Дархад, Элжигэн, Цаатануудын боловсролын төвшин бусдаас арай доогуур байгааг Хүснэгт 3.6-аас ажиглаж болно. Харин Цахар, Харчин, Өөлд, Буриад, Торгууд, Халхчуудын боловсролын төвшин харьцангуй өндөр байгааг дээд боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх хувийн жингээс харж болох юм.

ХҮСНЭГТ 3.6. ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010 ОН

Үндэс угсаа	10, түүнээс дээш насны хүн ам	Боловсролтой хүн ам						Боловсролгүй хүн ам			
		Бүгд	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Бүгд	Бичиг үсэг мэддэг	Бичиг үсэг мэддэггүй
МОНГОЛЫН ХАРЬАТ- БҮГД	100.0	85.7	16.8	5.3	2.6	29.6	16.6	14.8	14.3	11.8	2.5
Халх	100.0	86.5	17.5	5.3	2.5	30.9	16.3	14.0	13.5	11.2	2.3
Казах	100.0	77.2	9.7	4.5	3.3	18.7	17.5	23.4	22.8	18.9	3.9
Дөрвөд	100.0	83.3	14.2	5.1	3.2	26.1	18.1	16.6	16.7	13.7	3.0
Баяд	100.0	83.7	16.2	5.6	2.7	24.9	16.5	17.8	16.3	13.5	2.9
Буриад	100.0	88.3	20.1	6.7	3.0	29.3	16.9	12.3	11.7	9.9	1.9
Захчин	100.0	83.6	13.8	5.1	2.6	27.5	17.0	17.5	16.4	13.5	2.9
Дарьганга	100.0	81.6	13.5	6.2	4.6	18.6	21.6	17.0	18.4	13.9	4.5
Урианхай	100.0	83.6	11.1	4.6	2.9	25.9	19.8	19.4	16.4	13.4	3.0
Дархад	100.0	79.1	7.0	3.3	1.8	20.4	20.2	26.4	20.9	16.7	4.1
Өөлд	100.0	87.6	21.0	6.3	2.6	27.9	14.6	15.3	12.4	10.1	2.3
Хотогойд	100.0	81.8	10.4	4.2	2.8	20.8	18.5	25.1	18.2	14.4	3.9
Торгууд	100.0	87.3	18.7	7.0	2.7	30.6	14.4	13.8	12.7	10.6	2.1
Хотон	100.0	75.0	6.5	2.6	2.5	19.0	21.6	22.7	25.0	19.7	5.3
Мянгад	100.0	84.0	14.9	5.4	2.5	27.2	18.2	15.8	16.0	12.9	3.1
Тува	100.0	80.9	7.9	4.4	3.3	23.7	19.2	22.4	19.1	15.8	3.3
Барга	100.0	88.7	13.8	6.3	3.8	27.5	22.9	14.5	11.3	8.2	3.1
Үзэмчин	100.0	82.6	9.7	4.4	3.2	23.3	25.0	16.9	17.4	12.2	5.2
Элжигэн	100.0	79.7	10.8	5.9	3.1	18.4	20.9	20.6	20.3	17.5	2.8
Сартуул	100.0	88.6	15.7	7.1	3.4	28.1	18.8	15.3	11.4	8.4	3.0
Хамниган	100.0	80.5	10.7	5.5	4.3	21.3	17.1	21.6	19.5	15.2	4.3
Цаатан	100.0	79.8	4.1	1.2	2.5	15.7	25.6	30.6	20.2	16.9	3.3
Узбек	100.0	76.3	7.5	4.4	5.3	21.1	16.7	21.5	23.7	20.6	3.1
Харчин	100.0	88.1	21.6	9.7	6.0	26.1	14.2	10.4	11.9	9.0	3.0
Цахар	100.0	91.7	33.1	9.1	1.7	23.1	11.6	13.2	8.3	7.4	0.8
Бусад	100.0	91.9	32.7	3.4	2.9	23.8	14.1	14.9	8.1	6.9	1.2
Бусад үндэстэн	100.0	87.9	23.9	5.3	3.3	23.6	13.8	13.7	8.8	7.5	1.3

Хүн амын ажил эрхлэлтийг үндэс угсаагаар ангилж үзвэл Цаатан, Дархад, Хотогойд, Хотонгуудын дунд цалин хөлстэй ажил эрхлэлт хамгийн бага, харин хувиараа хөдөлмөр эрхлэх болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцох байдал харьцангуй өндөр байна. Дурдсан угсаатнууд голдуу хөдөө амьдарч байгаатай холбоотойгоор тэдний 60-аас илүү хувь нь хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлж байна.

ХҮСНЭГТ 3.7. ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010 ОН

Үндэс угсаа	Хөдөлмөр эрхэлдэг хүн ам	Цалин хөлстэй ажиллагч	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Нөхөрлөл, хоршооллын гишүүн	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	Бусад
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ - БҮГД	100.0	55.9	2.5	28.0	0.2	13.1	0.4
Халх	100.0	57.8	2.6	27.3	0.2	11.7	0.4
Казак	100.0	41.3	1.0	34.0	0.3	23.2	0.3
Дөрвөд	100.0	51.6	1.8	31.0	0.2	15.1	0.3
Буриад	100.0	59.1	2.9	24.8	0.3	12.5	0.4
Баяд	100.0	45.2	2.4	33.4	0.1	18.7	0.3
Дарьганга	100.0	42.7	1.8	29.6	0.1	25.5	0.2
Урианхай	100.0	47.3	1.3	31.4	0.3	19.3	0.5
Захчин	100.0	48.6	1.9	31.1	0.2	17.9	0.2
Дархад	100.0	25.1	1.2	36.4	0.2	37.0	0.2
Торгууд	100.0	59.5	3.7	25.1	0.6	10.9	0.3
Өөлд	100.0	57.6	2.6	28.5	0.2	10.8	0.3
Хотон	100.0	35.4	0.9	35.9	0.3	27.3	0.1
Мянгад	100.0	54.1	1.8	27.9	0.2	15.8	0.3
Барга	100.0	59.7	2.1	24.9	0.1	12.9	0.3
Үзэмчин	100.0	49.6	1.8	28.6	0.5	19.2	0.4
Харчин	100.0	63.9	8.3	22.2	0.0	5.6	0.0
Цахар	100.0	51.9	11.5	23.1	0.0	13.5	0.0
Хотогойд	100.0	29.4	1.6	35.7	0.3	32.9	0.2
Элжигэн	100.0	45.4	0.5	41.1	0.3	12.2	0.5
Цаатан	100.0	22.1	2.9	41.2	0.0	33.8	0.0
Сартуул	100.0	51.1	1.2	30.1	0.2	16.6	0.8
Тува	100.0	36.5	0.7	35.0	0.1	27.3	0.4
Узбек	100.0	26.3	5.3	44.7	2.6	21.1	0.0
Хамниган	100.0	40.4	7.9	32.6	0.0	19.1	0.0
Бусад	100.0	38.7	3.9	35.7	0.9	20.4	0.4
Бусад үндэстэн	100.0	60.3	6.0	28.8	0.0	4.3	0.5

ШАШИН

Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хуулийн “Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” гэсэн 3 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт “Аливаа шашныг шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна”¹ гэж заасан. Шашин шүтлэгийн талаар өмнөх тооллогуудад асууж байгаагүй. Хүн ам, орон сууцны тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан нь энэ удаагийн тооллогын нэг онцлог байлаа.

Арван тав, түүнээс дээш насны нийт хүний 38.6 хувь нь ямар нэг шашингүйчүүд, 61.4 хувь нь буюу 1170.2 мянган хүн шашинтан байгаагийн 86.2 хувь нь буддын шашинтан ажээ.

Шашинтангуудын дотор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон байгаа нь дараах хүснэгтээс харагдана. Шашинтан эмэгтэйчүүдийн 2.7 хувь буюу 26.0 мянган хүн христийн шашинтан байна.


ХҮСНЭГТ 3.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Шашны төрөл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	38.6	42.9	34.4
Шүтдэг	61.4	57.1	65.6
Будда	53.0	49.4	56.4
Ислам	3.0	3.1	3.0
Бөө	2.9	2.7	3.1
Христ	2.2	1.6	2.7
Бусад	0.4	0.4	0.4

Шашинтангуудын 86.2 хувь нь буддын шашинтан болох нь тооллогын дүнгээс харагдлаа.

¹ Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл. IV боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 541.

ЗУРАГ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАНГУУД,
ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН



Шашинтангууд нас ахих тутам монголын уламжлалт шашин будда илүү шүтдэг ажээ. Тухайлбал, 15-19 насны шашинтангуудын 81.0 хувь нь будда шүтэж байхад 50-59 насныхны 88.6 хувь, 60-69 насныхны 90.7 хувь, 70, түүнээс дээш насныхны 91.8 хувь нь буддын шашинтан байна. Нөгөө талаар христийн шашинтан нас ахих тутам буурч байна. Тухайлбал, 15-19 насны нийт хүний 5.3 хувь нь христийн шашинтан байхад 60-69 насанд 2.5 хувь, 70 ба түүнээс дээш насанд 1.7 хувь болж буурч байна.

ХҮСНЭГТ 3.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАН, НАСНЫ БҮЛЭГ,
ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Шашинтан	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	86.2	3.5	4.9	4.7	0.6
15-19	100.0	81.0	5.3	7.3	5.8	0.6
20-29	100.0	84.0	4.0	5.2	6.2	0.6
30-39	100.0	87.3	2.9	4.7	4.6	0.6
40-49	100.0	87.4	3.3	4.4	4.3	0.6
50-59	100.0	88.6	3.3	4.0	3.5	0.5
60-69	100.0	90.7	2.5	4.0	2.2	0.6
70+	100.0	91.8	1.7	4.4	1.5	0.6
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	11.3	10.6	17.0	16.8	13.9	11.1
20-29	26.7	26.0	30.3	28.0	34.9	28.8
30-39	22.7	23.0	18.7	21.6	22.0	22.8
40-49	18.5	18.8	17.5	16.3	16.8	18.2
50-59	11.3	11.6	10.7	9.1	8.5	10.0
60-69	5.4	5.7	3.9	4.4	2.5	5.2
70+	4.1	4.4	2.0	3.7	1.3	3.9

Казахуудын 14.3 хувь шашингүйчүүд байгаа нь бусад угсаатны бүлэгтэй харьцуулахад хамгийн бага байгаагаараа онцлог юм. Тэдний 83.7 хувь нь исламын шашинтан байна. Казахууд Монгол Улсын ислам шашинтаны 95 хувийг эзэлж байна.

Арван тав, түүнээс дээш насны шашинтангуудыг үндэс угсаагаар авч үзвэл Буриадуудын 21.0 хувь, Дархадуудын 41.5 хувь, Тувачуудын 46.2 хувь, Хамниганчуудын 30.6 хувь, Цаатангуудын 85.0 хувь бөө мөргөл шүтдэг нь бусад угсаатны бүлгээс ихээхэн ялгаатай юм.

ХҮСНЭГТ 3.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГ, ҮНДЭС УГСАА, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Үндэс угсаа	15, түүнээс дээш насны хүн ам-Бүгд	Шүтдэггүй	Шашинтан					
			Бүгд	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	38.6	61.4	53.0	2.2	3.0	2.9	0.4
Монголын харьяат-Бүгд	100.0	38.4	61.6	53.3	2.0	3.0	2.9	0.3
Халх	100.0	38.4	61.6	56.4	2.1	0.0	2.8	0.3
Казах	100.0	14.3	85.7	0.8	0.4	83.7	0.2	0.5
Дөрвөд	100.0	41.4	58.6	54.7	1.6	0.1	1.7	0.4
Баяд	100.0	40.9	59.1	55.1	1.4	0.0	2.1	0.4
Буриад	100.0	44.4	55.6	41.3	2.1	0.1	11.7	0.5
Захчин	100.0	54.8	45.2	40.2	2.5	0.0	1.7	0.8
Дарьганга	100.0	35.1	64.9	63.4	0.6	0.0	0.7	0.2
Урианхай	100.0	45.8	54.2	48.1	2.1	0.2	3.2	0.5
Дархад	100.0	66.3	33.7	17.8	0.9	0.0	14.0	1.0
Өөлд	100.0	41.9	58.1	52.7	2.3	0.0	2.4	0.6
Хотогойд	100.0	31.5	68.5	64.4	0.6	0.0	3.1	0.4
Торгууд	100.0	48.6	51.4	45.8	1.9	0.1	2.5	1.2
Хотон	100.0	41.4	58.6	23.6	2.9	22.8	1.4	7.8
Мянгад	100.0	49.0	51.0	46.1	2.5	0.0	2.1	0.2
Тува	100.0	45.2	54.8	25.6	2.2	1.1	25.3	0.6
Барга	100.0	55.7	44.3	41.1	1.0	0.0	1.7	0.4
Үзэмчин	100.0	54.5	45.5	43.8	0.5	0.0	0.9	0.3
Элжигэн	100.0	37.2	62.8	56.0	1.2	0.0	5.5	0.1
Сартуул	100.0	30.4	69.6	60.5	2.0	3.3	3.4	0.4
Хамниган	100.0	43.8	56.2	31.5	2.2	4.4	17.2	1.0
Цаатан	100.0	32.8	67.2	10.1	0.0	0.0	57.1	0.0
Узбек	100.0	27.3	72.7	4.5	3.4	63.6	0.6	0.6
Харчин	100.0	34.5	65.5	58.8	1.7	0.0	5.0	0.0
Цахар	100.0	50.5	49.5	45.8	1.9	0.0	1.9	0.0
Бусад	100.0	39.7	60.3	40.6	1.2	12.1	6.3	0.1
Бусад үндэстэн	100.0	48.8	51.2	29.4	15.9	0.3	3.2	2.3
Гадаад	100.0	40.4	59.6	11.2	29.9	13.9	0.2	4.5

ДҮГНЭЛТ

Хүн амын иргэний харьяалал

Монгол Улсад 6, түүнээс сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн тоо 2000 оныхоос 2 дахин өссөний дотор БНХАУ, БНСУ-ын иргэд өмнөх тооллогын үеийнхээс 2 илүү дахин нэмэгдсэн бол харин ОХУ-ынх бараг 3 дахин буурчээ. Гадаадын иргэдийн 89.1 хувь нь нийслэл, Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт амьдарч байна.

Монгол Улсад оршин суугаа гадаадын харьяат иргэдийн дийлэнх нь хөдөлмөрийн насныхан байгаагийн дотор гол төлөв эрэгтэйчүүд байна. Гадаадын харьяат иргэдийн 36.1 хувь нь дээд боловсролтой юм. Гадаадын харьяат иргэд гол төлөв барилга, уул уурхайн хайгуул, олборлолтын салбарт ажиллаж байна.

Хүн амын үндэс угсаа

Монгол Улсын харьяат суурин хүн амын 82.4 хувийг Халхчууд, 3.9 хувийг Казахууд, 2.8 хувийг Дөрвөдүүд, 2.2 хувийг Баядууд, 1.7 хувийг Буриадууд эзэлж байгаа нь улсын нийт хүн амын 93 орчим хувь болж байна.

Байршлын хувьд Халхчууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байгаагийн дотор Баян-Өлгий аймагт хамгийн цөөн буюу тухайн аймгийн нийт хүн амын 0.5 хувийг, харин Баянхонгор, Дундговь, Завхан, Өвөрхангай аймагт хамгийн олон буюу тухайн аймгийн нийт хүн амын 99 хувиас илүүг эзэлж байгаа нь бусдаас түгээмэл юм.

Хотон, Казах, Дархад, Элжигэн, Цаатангуудын боловсролын төвшин бусдаас арай доогуур байгаа бол Цахар, Харчин, Өөлд, Буриад, Торгууд, Халхчуудын боловсролын төвшин харьцангуй өндөр байна.


Цаатан, Дархад, Хотогойд, Хотонгуудын дунд цалин хөлстэй ажил эрхлэлт хамгийн бага, харин хувиараа хөдөлмөр эрхлэх болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцох байдал харьцангуй өндөр байгаа нь тэд гол төлөв хөдөө амьдарч байгаагаар холбоотой.

Шашин

Арван тав, түүнээс дээш насны нийт хүний 38.6 хувь нь шашингүйчүүд, 61.4 хувь нь буюу 1170.2 мянган хүн шашинтан байгаагийн 86.2 хувь нь буддын шашинтан байна. Хэдийгээр буддын шашинтан нийт хүн амын дунд түгээмэл байгаа боловч насны бүлгээр авч үзэхэд 15-19 насны өсвөр үеийнхэн илүү их христ, исламын шашинтан байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ



ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн янз бүрийн бүст оршдог, байгалийн баялаг улс орны нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран аймаг, нийслэлийн хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн төвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ. Хүн амын суурьшлыг хот, хөдөө, бүс нутгаар тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

Хүн амын суурьшлын ерөнхий дүр төрх өнгөрсөн 11 жилийнхээс бага зэрэг өөрчлөгдсөн байна. Энэ нь төв суурин газар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, ялангуяа баруун бүсээс төвийн бүс, нийслэлд олон мянган хүн шилжсэн нь бүс нутгийн хүн ам сийрэгжихэд нөлөөлжээ (хүснэгт 4.1).

Хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд² нийт хүн амын 44 хувь нь Улаанбаатар хот, 19 хувь нь хангайн бүс, 17 хувь нь төвийн бүс, 13 хувь нь баруун бүс, 7 хувь нь зүүн бүсэд оршин сууж байна.

Төв суурин газар руу 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн шилжилт сүүлчийн 10 гаруй жилд үргэлжилсэн хэвээр байна. Тухайлбал, 10 гаруй жилийн өмнө манай улсын арван хүний гурав нь нийслэлд амьдарч байсан бол 2010 онд 4 болж нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Бүс	Хүн ам (мян.хүн)		2010 2000 %	Дүнд эзлэх хувь	
	2000	2010		2000	2010
БҮГД	2373.5	2647.5	11.5	100.0	100.0
Баруун	421.6	352.5	-16.4	17.8	13.3
Хангай	545.7	514.7	-5.7	23.0	19.4
Төв	443.7	440.7	-0.7	18.7	16.6
Зүүн	202.5	185.3	-8.5	8.5	7.0
Улаанбаатар	760.1	1154.3	51.9	32.0	43.6

Ерөнхийдөө хүн амын шилжилт хөдөлгөөн Улаанбаатар руу чиглэж байгаа нь олон баримтаас харагдана. Учир нь дийлэнх аймгийн хүн амын тоо буурч, улсын дүнд эзлэх хувийн жин нь багасахад Улаанбаатарынх эрчимтэй өсч байгааг дараах хүснэгтээс харж болно.

² Улсын Их хурлаас баталсан “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” 2003 он.

Бүсүүдэд хамаарах аймаг, нийслэлийн нэр:

- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Улаанбаатарын бүсэд: Нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотуудыг хамруулдаг.

ХҮСНЭГТ 4.2. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Аймаг, нийслэл	Хүн ам (мян.хүн)		2010 2000 %	Дүнд эзлэх хувь	
	2000	2010		2000	2010
БҮГД	2373.5	2647.5	11.5	100.0	100.0
Архангай	97.1	84.1	-13.4 ↓	4.1	3.2
Баян-Өлгий	91.1	85.2	-6.4 ↓	3.8	3.2
Баянхонгор	84.8	75.7	-10.7 ↓	3.6	2.9
Булган	61.8	53.1	-14.0 ↓	2.6	2.0
Говь-Алтай	63.7	53.2	-16.4 ↓	2.7	2.0
Дорноговь	50.6	57.9	14.5 ↑	2.1	2.2
Дорнод	75.4	68.9	-8.6 ↓	3.2	2.6
Дундговь	51.5	38.6	-25.1 ↓	2.2	1.5
Завхан	90.0	64.9	-27.9 ↓	3.8	2.5
Өвөрхангай	111.4	100.4	-9.9 ↓	4.7	3.8
Өмнөговь	46.9	60.9	30.0 ↑	2.0	2.3
Сүхбаатар	56.2	51.1	-9.0 ↓	2.4	1.9
Сэлэнгэ	100.0	95.8	-4.2 ↓	4.2	3.6
Төв	99.3	83.8	-15.6 ↓	4.2	3.2
Увс	90.0	72.9	-19.0 ↓	3.8	2.8
Ховд	86.8	76.3	-12.1 ↓	3.7	2.9
Хөвсгөл	119.1	114.3	-4.0 ↓	5.0	4.3
Хэнтий	70.9	65.3	-8.0 ↓	3.0	2.5
Дархан-Уул	83.3	90.6	8.8 ↑	3.5	3.4
Улаанбаатар	760.1	1154.3	51.9 ↑	32.0	43.6
Орхон	71.5	87.1	21.8 ↑	3.0	3.3
Говьсүмбэр	12.2	13.1	7.1 ↑	0.5	0.5

Монгол Улсад сүүлчийн 20 гаруй жилд хотжих үйл явц улам бүр нэмэгдсээр байна. 2000 оноос хойш хөдөө аж ахуйд тохиолдсон ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл малчдад хүндээр тусч, нийслэл болон бусад томоохон хот, суурин газар руу шилжих хөдөлгөөн нэмэгджээ. Хот, суурингууд нь эрүүл мэнд, боловсрол болон ахуйн үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр олох найдвартай газар болж, хүмүүс ихээр татагдаж байгаа нь хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Дээрх шалтгааны улмаас хотын хүн ам эрс өсч, 2000 онд нийт хүн амын 57 хувь буюу 1345 мянган хүн хот, суурин газар амьдарч байсан бол 2010 онд нийт хүн амын 67.9 хувь буюу 1798.1 мянга нь амьдарч байна. Гэхдээ бүсүүдийн хотжилтын төвшин нэлээд ялгаатай байгааг хүснэгт 4.3-аас харж болно.

ХҮСНЭГТ 4.3. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Бүс нутаг	Хот			Хөдөө	
	Хот, тосгоны тоо	Хүн ам (мян.хүн)	Бүсийн хүн амд эзлэх хувь	Хүн ам (мян.хүн)	Бүсийн хүн амд эзлэх хувь
БҮГД	39	1798.1	67.9	849.4	32.1
Баруун	8	122.3	34.7	230.1	65.3
Хангай	10	225.1	43.8	289.6	56.2
Төв	11	211.4	48.0	229.2	52.0
Зүүн	9	84.9	45.8	100.4	54.2
Улаанбаатар	1	1154.3	100.0	-	-

Хүн амын суурьшлаар харвал Улаанбаатар хотын дараа төвийн бүс нутаг хотжилт хамгийн өндөр бүс болжээ. Тухайлбал, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь аймгуудад уул уурхайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимжсэн, хатуу хучилттай зам, төмөр зам гэх мэт дэд бүтэц сайтай, БНХАУ-тай хиллэдэг зэрэг нь бүсийн хотжих үйл явцад нөлөөлж байна.

Баруун бүс нутаг харьцангуй олон хүн амтай, суурьшлын хувьд нягт хэдий ч хотжих явц эрчимтэй биш байна.

Аймгуудын хотжилтын төвшин хоорондоо нэлээд ялгаатай юм. Аймгийн төвүүдийн үйлдвэр, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөнөөс илүү байгаа нь шилжигсдийг татаж, аймгийн нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөжээ. Хотын хүн амын эзлэх хувь төмөр замын дагуу байрладаг Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорнод, Дорноговь аймгуудад өндөр байна (Хүснэгт 4.4).


ХҮСНЭГТ 4.4. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Хот		Хөдөө	
	Хүн ам (мян.хүн)	Аймаг, нийслэлийн хүн амд эзлэх хувь	Хүн ам (мян.хүн)	Аймаг, нийслэлийн хүн амд эзлэх хувь
БҮГД	1798.1	67.9	849.4	32.1
Архангай	20.6	24.5	63.5	75.5
Баян-Өлгий	30.7	36.0	54.6	64.0
Баянхонгор	29.8	39.4	45.9	60.6
Булган	14.1	26.6	38.9	73.4
Говь-Алтай	18.0	33.7	35.3	66.3
Дорноговь	33.9	58.6	24.0	41.4
Дорнод	38.6	56.1	30.3	43.9
Дундговь	13.7	35.5	24.9	64.5
Завхан	17.5	26.9	47.4	73.1
Өвөрхангай	38.0	37.9	62.4	62.1
Өмнөговь	18.8	30.9	42.1	69.1
Сүхбаатар	16.2	31.6	34.9	68.4
Сэлэнгэ	47.0	49.1	48.8	50.9
Төв	13.3	15.9	70.5	84.1
Увс	27.2	37.3	45.7	62.7
Ховд	29.0	38.1	47.2	61.9
Хөвсгөл	38.4	33.6	75.9	66.4
Хэнтий	30.1	46.0	35.2	54.0
Дархан-Уул	75.0	82.7	15.7	17.3
Улаанбаатар	1154.3	100.0	-	-
Орхон	84.2	96.6	2.9	3.4
Говьсүмбэр	9.7	74.5	3.3	25.5

Хүн ам харьцангуй олон Архангай, Төв зэрэг аймгуудын хотын хүн амын эзлэх хувийн жин харьцангуй бага, хөдөөгийн хүн амын эзлэх хувийн жин 70-аас илүү хувийг эзэлж байна. Энэ нь эдгээр аймгийн нутаг дэвсгэр байгаль, цаг уурын таатай нөхцөлд оршдогтой холбоотой байж болох юм. Төв аймаг өөрийн гэсэн онцлогтой. Нийслэл хот өргөжих тутам түүний хил хязгаар өөрчлөгдсөн ч Төв аймгийн хөдөөгийн хүн амын эзлэх хувь бараг хэвээрээ хадгалагдсан байна. Гэхдээ Төв аймгийн иргэд аймгийн төв рүүгээ шилжихийг гол болгохгүй нийслэлд шууд шилжиж байгаа онцлог ч бас бий юм.

Өмнөговь аймагт сүүлчийн 10 жилд уул уурхайн хайгуул, олборлолт хөгжиж байгаатай уялдан зарим сумын хүн амын тоо өсч байгаа нь цаашид хот суурингийн хүн амын тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Дундговь аймгийн төв нийт хүн амын 30-аас илүү хувийг бүрдүүлж байгаа нь зөвхөн хөдөөнөөс шилжин ирэгсэдээс шалтгаалсан аж.

ЗУРАГ 4.1. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ



ХҮН АМЫН НЯГТРАЛ

Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газарзүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, улмаар хүн амын нягтралд нөлөөлдөг. Бүс нутаг, аймаг, нийслэлийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлсийн нэгд шилжих хөдөлгөөн орж байна.


Монгол Улсын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 1.5 хүн ногдож байсан бол 2010 онд 0.2 пунктээр өсч 1.7 болов. Манай улс дэлхийн хамгийн сийрэг суурьшилтай орны нэг хэвээр байна.

ХҮСНЭГТ 4.5. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

Бүс нутаг	Хүн ам		Нутаг дэвсгэр		1 км ² -т ногдох хүн
	мян. хүн	Эзлэх хувь	мян.км ²	Эзлэх хувь	
БҮГД	2647.5	100.0	1564.1	100.0	1.7
Баруун	352.5	13.3	415.3	26.6	0.8
Хангай	514.7	19.4	384.3	24.6	1.3
Төв	440.7	16.6	473.6	30.3	0.9
Зүүн	185.3	7.0	286.2	18.3	0.6
Улаанбаатар	1154.3	43.6	4.7	0.3	245.6

Улаанбаатар хот хүн ам нягтралаараа хамгийн өндөр хэвээр байна. Нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 162 хүн ногдож байснаа 2010 онд 246 болж, 1.5 дахин өсчээ. Улаанбаатар хот Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа хүн амын 43.6 хувь нь оршин сууж, энэ байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Бусад бүс нутгийн хүн амын нягтрал харьцангуй сийрэг байгаа ч хоорондоо нэлээд ялгаатай. Ерөнхийдөө хангайн болон төвийн бүс нутаг хот, хот маягийн суурин олон байдагтай холбоотойгоор баруун болон зүүн бүсийг бодвол харьцангуй нягтрал ихтэй байна. Харин байгаль, цаг уурын харьцангуй тааламжтай нөхцөл бүхий Хангайн бүсэд нэг квадрат километрт 1.3 хүн ногдож байгаа нь зүүн бүсээс 2 дахин их юм.

ЗУРАГ 4.2. ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН



Аймгуудын хүн амын нягтрал нь суурьшлын нэн сонирхолтой дүр төрхийг харуулна. Улаанбаатар хотоос гадна Орхон (нэг квадрат километр 109 хүн), Дархан-Уул аймгийн (нэг квадрат километр 28 хүн) хүн амын нягтрал бусад аймгаас хамгийн өндөр байна.

ХҮСНЭГТ 4.6. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Аймаг, нийслэл	2000			2010		
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²	мян.хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²
БҮГД	2373.5	100	1.5	2647.5	100.0	1.7
Архангай	97.1	4.1	1.8	84.1	3.2	1.5
Баян-Өлгий	91.1	3.8	2.0	85.2	3.2	1.9
Баянхонгор	84.8	3.6	0.7	75.7	2.9	0.7
Булган	61.8	2.6	1.3	53.1	2.0	1.1
Говь-Алтай	63.7	2.7	0.5	53.2	2.0	0.4
Дорноговь	50.6	2.1	0.5	57.9	2.2	0.5
Дорнод	75.4	3.2	0.6	68.9	2.6	0.6
Дундговь	51.5	2.2	0.7	38.6	1.5	0.5
Завхан	90.0	3.8	1.1	64.9	2.5	0.8
Өвөрхангай	111.4	4.7	1.8	100.4	3.8	1.6
Өмнөговь	46.9	2.0	0.3	60.9	2.3	0.4
Сүхбаатар	56.2	2.4	0.7	51.1	1.9	0.6
Сэлэнгэ	100.0	4.2	2.4	95.8	3.6	2.3
Төв	99.3	4.2	1.3	83.8	3.2	1.1
Увс	90.0	3.8	1.3	72.9	2.8	1.0
Ховд	86.8	3.7	1.1	76.3	2.9	1.0
Хөвсгөл	119.1	5.0	1.2	114.3	4.3	1.1
Хэнтий	70.9	3.0	0.9	65.3	2.5	0.8
Дархан-Уул	83.3	3.5	25.4	90.6	3.4	27.5
Улаанбаатар	760.1	32.0	161.7	1154.3	43.6	245.6
Орхон	71.5	3.0	85.1	87.1	3.3	108.9
Говьсүмбэр	12.2	0.5	2.2	13.1	0.5	2.4

Аймгуудын хүн амын нягтрал шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор ерөнхийдөө буурах хандлагатай ажээ. Дээр дурдсан 3 аймаг, хотын дараагаар тэдгээртэй харьцуулахад бага нягтралтай, нэг квадрат км нутаг дэвсгэрт 2.3-2.4 хүн ногдож байгаа Сэлэнгэ, Говьсүмбэр аймгууд орж байна. Харин Өмнөговь, Дорноговь, Дорнод болон баруун бүсийн Говь-Алтай аймагт хүн амын нягтрал хамгийн сийрэг, нэг квадрат километр нутаг дэвсгэрт 0.5 хүн ногдож байна.


ДҮГНЭЛТ

Монгол Улсын хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.5 хүн ногдож байсан бол 2010 онд 1.7 болж өссөн нь үндэсний төвшинд хүн амын ердийн цэвэр өсөлтийн нөлөө юм. Аймаг, нийслэлийн хүн амын нягтралын өөрчлөлтөд дээр дурдсан хүчин зүйлсээс гадна гадаад, дотоод шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2000-2010 оны хооронд 51.9 хувь, Орхон аймгийнх 28 хувиар тус тус өссөн нь мөн л шилжих хөдөлгөөнтэй холбоотой. Ийм шалтгааны улмаас Дархан-Уул аймгийн нягтрал 2000 оноос өссөн байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ХОТЖИЛТ



Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөн сүүлчийн 20 орчим жилд маш их идэвхжсэн. Тооллогоор байнга оршин сууж байсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс (аймаг, нийслэлийн төвшинд) өөр газар руу 6, түүнээс дээш сарын хугацаагаар шилжин суурьшсан хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзсэн. Тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс, гол төлөв хөдөөнөөс мэргэжил, боловсрол эзэмших, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээнд ойртох, хөдөлмөр эрхлэх зэрэг шалтгаанаар төв суурин газар руу шилжих нь нэмэгдэв. Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсгийн “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй”³ гэсэн заалт нь иргэд шилжих хөдөлгөөнд сайн дураараа чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.

Шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэг. Тооллогоор шилжих хөдөлгөөнийг тооллогын товын үед:

- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 5 жил 11 сарын хөдөлгөөнийг хамруулав);
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 11 сарын хөдөлгөөнийг хамруулав) гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Шилжих хөдөлгөөнийг тухайн хүн дээрх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлд шилжсэн нутаг дэвсгэрийн байдлаар, нутаг дэвсгэрийг байнга оршин сууж байсан аймгаас нийслэлд эсвэл өөр аймагт, нийслэлээс аймагт шилжсэн байдлаар тодорхойлов. Шилжих хөдөлгөөнд оролцогчдын шинж төрхийг тодорхойлохдоо гол төлөв шилжин ирсэн нутаг дэвсгэр, хүн амын шинж төрхтэй нь харьцуулан судалсан. Аймаг, нийслэл, бүс нутгийн ойрын болон дунд хугацааны бодлого хөтөлбөр боловсруулахад эдгээр мэдээлэл чухал ач холбогдолтой билээ.

ЗУРАГ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН



³ Монгол Улсын үндсэн хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл I боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 5

Төрсөн аймаг, нийслэлдээ тооллогын товын үед байнга оршин сууж байсан хүн амыг “Төрснөөсөө хойш сууж байгаа” буюу амьдралынхаа туршид оршин суугаа газраа өөрчлөөгүй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, амьдралынхаа аль нэг хугацаанд өөр хэдэн газар амьдарч байсныг үл харгалзан төрсөн газраа тооллогын товын үед байнга оршин сууж байсан гэсэн шалгуурыг гол болгож үзсэн. Харин тооллогын товын үед төрсөн аймаг, нийслэлээсээ өөр газар байнга оршин сууж байгаа хүмүүсийг “Төрснөөсөө хойш шилжигсэд” гэж үзэв.

Шилжих хөдөлгөөний урсгал, шилжин суурьшсан хугацааг тооллогын товын үед байнга оршин сууж байсан газраа шилжиж ирсэн хүн бүрээс оршин суугаа хугацаа, өмнө нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийн нэрийг асууж тодорхойлов.

Олон улсад шилжих хөдөлгөөний чиг хандлагыг цаг хугацаагаар хэмжин судалдаг жишгийг үндэслэн хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн таван жилийн өмнөх шилжих хөдөлгөөнийг судалсан. Үүнийг тоолуулагч 2005 оноос өмнө болон хойших хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан товын үед болон товоос таван жилийн өмнө байнга сууж байсан газраар тооцоолсон болно. Анхаарах асуудал нь 2000 оны тооллогын тов 1 дүгээр сарын 4-өөс 5-нд шилжих шөнө байсан бол 2010 оных 11 дүгээр сарын 10-аас 11-нд шилжих шөнө байсан гэдгийг судлаачид харгалзаж үзэх нь зүйтэй. Тав хүртэлх насны хүүхдүүд тооллого явуулахаас таван жилийн өмнө төрөөгүй байсан тул зөвхөн тав, түүнээс дээш насны хүмүүсээс уг асуултыг асуусан.

Шилжих хөдөлгөөнийг хэмжих хамгийн чухал хэмжүүр нь нутаг дэвсгэр буюу засаг захиргааны нэгж юм. Тооллогод аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнийг асууж тодорхойлсон.

ЗУРАГ 5.2. СҮҮЛЧИЙН ТАВАН ЖИЛИЙН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН




Сүүлчийн нэг жил (2010 оны 1 дүгээр сараас хойш) тухайн аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүмүүсийг судалсан (зураг 5.3). Гэхдээ шилжих хөдөлгөөнийг өөр өөр цаг хугацаа, оноор нарийвчлан судлах боломж тооллогын баримтад байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ЗУРАГ 5.3. СҮҮЛЧИЙН НЭГ ЖИЛИЙН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН



Шилжих хөдөлгөөний судалгааг энгийн болгох үүднээс энэхүү тайланд зөвхөн бүсүүдийн хоорондын шилжих хөдөлгөөнийг авч үзсэн бөгөөд аймаг болон аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнийг бүсээр нэгтгэж, бүс нутаг хоорондын шилжих хөдөлгөөнийг тодорхойлов (бүс нутгийн ангиллыг эл номын 4 дүгээр бүлгээс үзнэ үү). Тиймээс бүс нутгийн хэмжээнд шилжих хөдөлгөөнийг тодорхойлоход төрсөн бүс нутаг, шилжин ирсэн бүс нутгаас өөр бөгөөд шилжигсдийн тоо аймаг хоорондынхоос бага байх болно. Харин аймаг болон аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөний судалгааг хийж, хотжилтын судалгаанд ашиглав.

ЗУРАГ 5.4. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2010 ОН



Шилжих хөдөлгөөний хамгийн сүүлчийн хугацаа, нутаг дэвсгэрийн хамгийн ерөнхий төвшин болох бүс нутаг хоорондын сүүлчийн 1 жилийн шилжих хөдөлгөөнд оролцогч 101.2 мянга хүн байгаа нь 2000 оныхоос 1.6 дахин нэмэгдэв. Төрснөөс хойш аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч 1097.6 мянган хүн байгаа нь суурин хүн амын 41.5 хувь болж, 2000 оныхоос 2 дахин (2000 онд 20.7 хувь) өсчээ. Төрснөөс хойш аймаг, нийслэл хооронд шилжигчдийн 28.9 хувь нь 2005 оноос хойш, 10.4 хувь нь сүүлчийн нэг жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцжээ.

Бүс нутаг хоорондын шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнөөс 10.3 хувиар бага байгаа нь олон хүн шилжин ирж, суурьших болсон Улаанбаатар хот дангаараа нэг бүсийг төлөөлж байгаатай, нөгөө талаар бүс нутаг доторх ялангуяа төвийн бүсийн аймаг хоорондын шилжих хөдөлгөөн харьцангуй их байгаатай холбоотой.

ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг хугацаа үл харгалзан тухайн хүний төрсөн болон тоолох үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг үндэслэн тооцов. Тиймээс тоолох үед тухайн нутаг дэвсгэрээс өөр газар төрсөн бүх хүнийг шилжин ирээд байнга амьдарч байгаа хугацааг үл харгалзан шилжин ирэгсэд гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн хүн төрснөөсөө хойш 2010 оны 11 дүгээр сар буюу тоолох үе хүртэлх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан зөвхөн сүүлчийнхийг хамруулж байгаа болно. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний үндсэн агуулга нь аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хүн амын хэдэн хувь нь уугуул нутагтаа амьдарч байгааг илэрхийлэхэд оршино. Энэхүү мэдээллийг ашиглахад дутагдалтай тал нь шилжих хөдөлгөөнд оролцсон хугацаа тодорхой бус байдаг явдал юм.

ХҮСНЭГТ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ТӨРСӨН ГАЗАР, БҮС НУТГААР, 2010 ОН

Төрсөн бүс нутаг	Хүн амын тоо	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгсэд	Шилжин явагсад	
БҮГД	2 647 545	1 860 535	787 010	787 010	0
Баруун	595 596	344 993	7 544	250 603	- 243 059
Хангай	680 933	464 447	50 279	216 486	- 166 207
Төв	481 974	315 203	125 490	166 771	- 41 281
Зүүн	256 881	172 001	13 298	84 880	- 71 582
Улаанбаатар	610 646	563 891	590 399	46 755	543 644
Гадаад ¹	21 515	-	-	21 515	- 21 515

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Нийт хүн амын 29.7 хувь буюу 787.0 мянган хүн төрснөөсөө хойш бүс нутаг хооронд шилжих хөдөлгөөнд оржээ. Үүнийг өнгөрсөн тооллогын үетэй зэрэгцүүлж өссөн эсвэл буурсан гэсэн дүгнэлт гаргах боломжгүй юм. Учир нь өмнөх тооллогын үед төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон хүмүүс энэ тоонд давхардан орж байгаагаас гадна бүсүүдийн хил хязгаар өөрчлөгдсөн билээ.

Тодорхой нэг үеийг илэрхийлэхгүй ч гадаадын харьяат иргэд болон Монгол Улсын иргэдээс гадаад улс оронд төрсөн хүнийг оруулан тооцвол төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогч шилжин ирсэн, явсан хүний тоо тэнцүү байх нь зүй ёсны хэрэг юм. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний ерөнхий төрхөөс харахад Улаанбаатар руу чиглэсэн хөдөлгөөн нь бусад бүсээс өндөр хэвээр байна. 2010 оны тооллогын пүнгээр нийслэлийн хүн амын 51.1 хувь нь шилжин ирж суурьшсан байна.

Бүс нутгийн шилжих хөдөлгөөний төрх байдлыг үзвэл төвийн бүсэд шилжин ирэгсэд (Улаанбаатараас бусад) давамгайлж байгааг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 5.2. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН

Төрсөн газар	Хүн амын тоо	Тоолох үед байнга оршин сууж байсан газар					ШИЛЖИН ЯВСАН
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	2 647 545	352 537	514 726	440 693	185 299	1 154 290	-
Баруун	595 596	344 993	24 889	48 194	2 472	175 048	250 603
Хангай	680 933	1 951	464 447	35 728	2 073	176 734	216 486
Төв	481 974	1 402	10 181	315 203	3 350	151 838	166 771
Зүүн	256 881	376	2 069	9 308	172 001	73 127	84 880
Улаанбаатар	610 646	3 287	12 002	26 958	4 508	563 891	46 755
Гадаад ¹	21 515	528	1 138	5 302	895	13 652	21 515
ШИЛЖИН ИРСЭН	-	7 544	50 279	125 490	13 298	590 399	787 010

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Баруун бүсээс бусад бүс нутагт руу 250.6 мянган хүн шилжин явсан байхад тухайн бүс нутагт дөнгөж 7.5 мянган хүн шилжин ирсэн нь шилжин явагчид хамгийн олонтой бүс нутаг болж байна. 2010 оны тооллогоор баруун бүсэд төрсөн хүн амын 57.9 хувь нь л тухайн бүсдээ амьдарч байгаа ажээ. Нөгөө талаар, баруун бүсэд амьдарч байгаа иргэдийн 97.9 хувь нь уугуул иргэд (тухайн бүсэд төрөөд тэндээ амьдарч байгаа) байхад энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн бага буюу 48.9 хувь, төвийн бүсэд 71.5 хувь байна.

Сийрэг суурьшилтай зүүн бүсийн хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн харьцангуй бага нөлөө үзүүлдэг ажээ. Тухайлбал, тооллогоор баруун бүсэд төрсөн бүх хүн амын 42.1 хувьтай тэнцэх хүн ам тус бүсээс шилжин явсан бол зүүн бүсэд энэ үзүүлэлт 33.1 хувь байна. Өөрөөр хэлбэл, баруун бүсийн цэвэр шилжилт (шилжин ирсэн, явсан хүний зөрүү) -243.1 мянган хүн байхад зүүн бүсэд энэ үзүүлэлт -71.6 мянган хүн байна.

Төвийн бүсийн хот, суурин газруудын хөгжилд Улаанбаатар хот, бусад бүс нутаг, хөрш орнуудтай холбосон төмөр зам, Өмнөговь аймагт өрнөж буй уул уурхайн бүтээн байгуулалт илүү боломж бий болгож байгаа учир Улаанбаатараас гадна төвийн бүс нутагт 98.5 мянган хүн буюу хамгийн их хүн шилжин суурьшжээ. Төвийн бүс нутгийн нэг

онцлог нь шилжин ирсэн, явсан хүний зөрүү хамгийн бага (41.3 мянган хүн) бөгөөд бусад бүс нутгаас Улаанбаатар руу шилжигсэдийн дамжин суурьшдаг бүс байсаар байна.

Төрснөөс хойших шилжигсэдийн урсгалыг бүс нутгаар тодорхойлсон байдлаас харахад (хүснэгт 5.3) нэлээд сонирхолтой дүр зураг ажиглагдана. Улаанбаатар хотод төрөөд тоолох үед нийслэлд байнга сууж байсан хүн амын эзлэх хувь 92.3 байгаа нь хамгийн өндөр бөгөөд өнгөрсөн тооллогын үеийнхээ төвшинд байна. Улаанбаатар хотод төрөөд 2010 оны тооллогоор тоологдсон хүн амын 4.4 хувь нь төвийн бүсэд, 0.5 хувь нь баруун бүсэд, 2.0 хувь нь хангайн бүсэд, 0.7 хувь нь зүүн бүсэд шилжин суурьшсан нь Улаанбаатар хотод төрсөн хүн өөр бүсэд шилжин суурьших сонирхол тун бага байгааг харуулж байна.

Төрсөн бүс нутагтаа төрснөөсөө хойш амьдарч байгаа хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотын дараа хамгийн өндөрт хангайн бүс нутаг орж байна. Хүн ам нь хамгийн ихээр шилжин явсан бүс нутаг нь баруун бүс гэдгийг өмнө тэмдэглэсэн. Баруун бүс нутагт төрөөд тоолох үед Улаанбаатар хотод оршин суугаа хүн ам баруун бүсэд тоолуулсан хүн амын 49.7 хувьтай тэнцэж байна. Энэ нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн их үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 5.3. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

Төрсөн газар	Бүгд	Тоолох үед байнга оршин сууж байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
БҮГД	100.0	13.3	19.4	16.6	7.0	43.6
Баруун	100.0	57.9	4.2	8.1	0.4	29.4
Хангай	100.0	0.3	68.2	5.2	0.3	26.0
Төв	100.0	0.3	2.1	65.4	0.7	31.5
Зүүн	100.0	0.1	0.8	3.6	67.0	28.5
Улаанбаатар	100.0	0.5	2.0	4.4	0.7	92.3
Гадаад ¹	100.0	2.5	5.3	24.6	4.2	63.5
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	22.5	97.9	4.8	10.9	1.3	15.2
Хангай	25.7	0.6	90.2	8.1	1.1	15.3
Төв	18.2	0.4	2.0	71.5	1.8	13.2
Зүүн	9.7	0.1	0.4	2.1	92.8	6.3
Улаанбаатар	23.1	0.9	2.3	6.1	2.4	48.9
Гадаад ¹	0.8	0.1	0.2	1.2	0.5	1.2

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Хүснэгт 5.3-т хүн амын эзлэх хувийг тоолох үед байнга оршин сууж байсан бүс нутгаар харуулав. Тоолох үед Улаанбаатар хотын хүн амын 51.1 хувь бусад бүсээс шилжин ирж суурьшсан байгаа нь хамгийн өндөр, үүний дараагаар төвийн бүс, харин хүн ам хамгийн бага шилжин ирж суурьшсан бүс нь баруун бүс байна.

ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨХТЭЙ ХАРЬЦУУЛСАН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 5 жилийн шилжих хөдөлгөөнийг 2005 оны 1 дүгээр сард байнга сууж байсан аймаг, нийслэлээр авсан.

ХҮСНЭГТ 5.4. ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, 5 ЖИЛИЙН ӨМНӨ БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН

2005 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан газар	5, түүнээс дээш насны хүн ам	5 жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгсэд	Шилжин явагсад	
БҮГД	2 321 148	2 038 750	282 398	282 398	0
Баруун	348 358	292 011	11 121	56 347	- 45 226
Хангай	493 075	425 698	23 723	67 377	- 43 654
Төв	391 445	332 898	53 822	58 547	- 4 725
Зүүн	182 152	153 452	8 275	28 700	- 20 425
Улаанбаатар	884 407	834 691	185 457	49 716	135 741
Гадаад ¹	21 711	-	-	21 711	- 21 711

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөний ерөнхий төрх, төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийхтэй төстэй юм. Нийслэл хотоос бусад бүх бүс нутагт шилжих хөдөлгөөний урсгал гадагшаа чиглэсэн байна. Баруун бүсээс бусад бүс нутаг руу шилжсэн хөдөлгөөн хамгийн их, үүний дараа хангайн бүс орж байна. Бусад бүс нутагт цэвэр гадагш шилжсэн хөдөлгөөн их биш байна. Улаанбаатар хотын хүн ам 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 135.7 мянган хүнээр нэмэгдсэн нь тоологдсон хүн амын 11.8 хувийг эзэлж байна. Гэтэл баруун бүс нутгаас 5 жилийн дотор цэвэр шилжин явсан хүн амын тоог, тоологдсон хүн амын тоотой харьцуулахад 12.8 хувь болж байна. Өөрөөр хэлбэл, баруун бүс 2005 оноос хойш одоо байгаа хүнийхээ 12.8 хувьтай тэнцэх хүнийг гадагш алдсан гэсэн үг. Хэрэв баруун бүсээс гадагш шилжих хөдөлгөөн ийм их байгаагүй бол тооллогоор тухайн бүсэд оршин суугаа хүн ам нэлээд олон байх байжээ.

ХҮСНЭГТ 5.5. ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, 2005 ОНЫ 1 ДҮГЭЭР САР БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА СУУЖ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН

2005 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан газар	5, түүнээс дээш насны хүн ам	Тоолох үед байнга оршин сууж байсан газар					ШИЛЖИН ЯВСАН
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	2 321 148	303 132	449 421	386 720	161 727	1 020 148	-
Баруун	348 358	292 011	5 355	11 204	379	39 409	56 347
Хангай	493 075	1 430	425 698	9 642	441	55 864	67 377
Төв	391 445	1 117	4 382	332 898	1 439	51 609	58 547
Зүүн	182 152	120	431	3 409	153 452	24 740	28 700
Улаанбаатар	884 407	7 721	12 572	24 038	5 385	834 691	49 716
Гадаад ¹	21 711	733	983	5 529	631	13 835	21 711
ШИЛЖИН ИРСЭН	-	11 121	23 723	53 822	8 275	185 457	282 398

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Хүснэгтээс харахад баруун бүсээс шилжин явсан хүний тоо хангайн болон төвийн бүстэй харьцуулахад харьцангуй цөөн мэт харагдаж байгаа боловч шилжин ирсэн хүн хамгийн бага (шилжин явсан нь хамгийн их) байна. Төвийн бүсээс гадагш олон хүн шилжин явсан боловч тухайн бүсэд гаднаас олон хүн шилжин ирсэн нь энэ бүс нутгийн хүн амын тоонд онцын өөрчлөлт оруулаагүй ажээ.

2005 оны 1 дүгээр сард Улаанбаатарт байнга сууж байсан хүн амын 94.4 хувь нь Улаанбаатар хотод тоологджээ (хүснэгт 5.6). Бусад бүс нутагт амьдарч байсан хүн амын 84-86 хувь нь тухайн бүс нутагтаа тоологджээ.

Харин хүснэгт 5.6-ийн дүнд эзлэх хувиас Улаанбаатар хотод сүүлчийн 5 жилийн хугацаанд шилжин суурьшсан хүн ам хамгийн их (18.2 хувь) байхад, баруун бүсэд хамгийн бага (3.7 хувь) байна.

ХҮСНЭГТ 5.6. ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ТОО, 2005 ОНЫ 1 ДҮГЭЭР САР БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА СУУЖ БАЙСАН БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

2005 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан газар	Бүгд	Тоолох үед байнга оршин сууж байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
БҮГД	100.0	13.1	19.4	16.7	7.0	44.0
Баруун	100.0	83.8	1.5	3.2	0.1	11.3
Хангай	100.0	0.3	86.3	2.0	0.1	11.3
Төв	100.0	0.3	1.1	85.0	0.4	13.2
Зүүн	100.0	0.1	0.2	1.9	84.2	13.6
Улаанбаатар	100.0	0.9	1.4	2.7	0.6	94.4
Гадаад ¹	100.0	3.4	4.5	25.5	2.9	63.7
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	15.0	96.3	1.2	2.9	0.2	3.9
Хангай	21.2	0.5	94.7	2.5	0.3	5.5
Төв	16.9	0.4	1.0	86.1	0.9	5.1
Зүүн	7.8	0.0	0.1	0.9	94.9	2.4
Улаанбаатар	38.1	2.5	2.8	6.2	3.3	81.8
Гадаад ¹	0.9	0.2	0.2	1.4	0.4	1.4

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Тооллогын товоос өмнөх нэг жилийн шилжих хөдөлгөөн нь төрснөөс хойш болон 5 жилийн өмнөхийг бодвол богино хугацаатай учир тоолуулж байгаа хүн хариулахад хялбар байдаг. Тиймээс төрснөөс хойш болон 5 жилийн өмнөх шилжих хөдөлгөөний талаар өгсөн мэдээллээс илүү бодитой байж болох талтай.

Тооллогын товоос өмнөх нэг жил улсын хэмээнд 101.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцсон нь Өвөрхангай аймгийн суурин хүн амын тоотой тэнцүү юм. Энэ үзүүлэлт улсын хэмжээний суурин хүн амын 3.8 хувийг эзэлж байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт билээ.

ХҮСНЭГТ 5.7. НЭГ ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ЖИЛИЙН ӨМНӨ БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН


Жилийн өмнө байнга амьдарч байсан газар	Хүн амын тоо	Сүүлчийн нэг жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал			
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгсэд	Шилжин явагсад	Цэвэр шилжих хөдөлгөөн
БҮГД	2 647 545	2 546 378	101 167	101 167	0
Баруун	365 998	347 989	4 548	18 009	- 13 461
Хангайн	530 152	506 142	8 584	24 010	- 15 426
Төвийн	435 318	417 104	23 589	18 214	5 375
Зүүн	191 418	182 146	3 153	9 272	- 6 119
Улаанбаатар	1 113 649	1 092 997	61 293	20 652	40 641
Гадаад ¹	11 010	-	-	11 010	- 11 010

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний дүр төрх өмнөх 2 үеийн шилжих хөдөлгөөнтэй ижил байгаа нь тус улсын шилжих хөдөлгөөний урсгал чиглэл ерөнхийдөө ижил төстэй явагдаж ирснийг харуулна.

Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний урсгалын талаарх тоо баримтыг бүс нутагт тоологдсон хүн амын тоотой харьцуулан цэвэр шилжилтийн коэффициентийг тооцож үзэхэд нэлээд сонирхолтой дүр төрх харагдана.

ЗУРАГ 5.5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, БҮС НУТГААР, 2010 ОН



Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний өмнөх үеүдээс ялгарах онцлог нь төвийн бүсийн цэвэр шилжилт эерэг утга гарч байгаа нь тооллогын товын өмнөх нэг жилд төвийн бүсэд олон хүн шилжин суурьшсаныг харуулж байна. Ялангуяа, сүүлчийн нэг жилийн хугацаанд Өмнөговь аймаг руу 8.5 мянган хүн шилжжээ.

ХҮСНЭГТ 5.8. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан газар	Хүн амын тоо	Тоолох үед байнга оршин сууж байсан газар					ШИЛЖИН ЯВСАН
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	2 647 545	352 537	514 726	440 693	185 299	1 154 290	-
Баруун	365 998	347 989	1 632	3 083	130	13 164	18 009
Хангай	530 152	570	506 142	4 137	178	19 125	24 010
Төв	435 318	409	1 551	417 104	488	15 766	18 214
Зүүн	191 418	61	158	1 227	182 146	7 826	9 272
Улаанбаатар	1 113 649	3 077	4 838	10 746	1 991	1 092 997	20 652
Гадаад ¹	11 010	431	405	4 396	366	5 412	11 010
ШИЛЖИН ИРСЭН	-	4 548	8 584	23 589	3 153	61 293	101 167

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Жилийн өмнө Улаанбаатар хотод сууж байсан бүх хүний 98.1 хувь нийслэлд тоологдсон нь бусад бүсүүдээс хамгийн өндөр юм. Харин Улаанбаатар хотод тоологдсон нийт хүний 5.3 хувь нь сүүлчийн нэг жилийн дотор шилжин ирсэн хүмүүс байгааг дараах хүснэгтээс харагдаж байна.

ХҮСНЭГТ 5.9. ХҮН АМЫН ТОО ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА СУУЖ БАЙСАН БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан газар	Бүгд	Тоолох үед байнга оршин сууж байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
БҮГД	100.0	13.3	19.4	16.6	7.0	43.6
Баруун	100.0	95.1	0.4	0.8	0.0	3.6
Хангай	100.0	0.1	95.5	0.8	0.0	3.6
Төв	100.0	0.1	0.4	95.8	0.1	3.6
Зүүн	100.0	0.0	0.1	0.6	95.2	4.1
Улаанбаатар	100.0	0.3	0.4	1.0	0.2	98.1
Гадаад ¹	100.0	3.9	3.7	39.9	3.3	49.2
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	13.8	98.7	0.3	0.7	0.1	1.1
Хангай	20.0	0.2	98.3	0.9	0.1	1.7
Төв	16.4	0.1	0.3	94.6	0.3	1.4
Зүүн	7.2	0.0	0.0	0.3	98.3	0.7
Улаанбаатар	42.1	0.9	0.9	2.4	1.1	94.7
Гадаад ¹	0.4	0.1	0.1	1.0	0.2	0.5

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Төрснөөс хойш, 5 болон нэг жилийн өмнөх шилжих хөдөлгөөний урсгалыг харахад аль ч бүсээс Улаанбаатар руу чиглэсэн урсгал хамгийн их байгаа боловч төвийн бүсэд шилжин ирж суурьшигч бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн олон байна. Энэ нь төвийн бүсийн аймгуудын хөгжил, төрөөс баримталж буй бодлого зэрэг олон татах хүчин зүйлстэй холбоотой юм. Цаашид төвийн бүсийн аймгуудад уул уурхайн бүтээн байгуулалт өрнөх, аж үйлдвэрийн томоохон цогцолбор байгуулах, зам, харилцаа, дэд бүтцийг сайжруулах зэрэг олон ажил хийгдэх учраас шилжих хөдөлгөөнийг энэ бүс рүү илүү ихээр татах болно.

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Шилжих хөдөлгөөнийг хугацаа, нутаг дэвсгэрээс гадна хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, тухайлбал нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн идэвх, орлого, өрхийн сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамж зэрэг олон үзүүлэлттэй хамааруулан судлах нь илүү ач холбогдолтой юм. Хэдийгээр тооллогоор цуглуулсан мэдээлэл, үзүүлэлтүүд хязгаарлагдмал ч энэ сэдвээр олон талаас нь нарийвчлан судлах боломж бий бөгөөд дараа дараагийн түүвэр судалгаа хийх хамгийн өргөн хүрээний эх олонлог болно.


ХҮСНЭГТ 5.10. СҮҮЛЧИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИГСЭД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Шилжигсэд					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	114 022	100.0	60 953	100.0	53 069	100.0
0-4	9 389	8.2	4 776	7.8	4 613	8.7
5-9	4 738	4.2	2 384	3.9	2 354	4.4
10-14	4 606	4.0	2 370	3.9	2 236	4.2
15-19	22 898	20.1	10 645	17.5	12 253	23.1
20-24	25 722	22.6	13 239	21.7	12 483	23.5
25-29	12 250	10.7	6 988	11.5	5 262	9.9
30-34	8 682	7.6	5 307	8.7	3 375	6.4
35-39	7 009	6.1	4 441	7.3	2 568	4.8
40-44	5 855	5.1	3 841	6.3	2 014	3.8
45 +	12 873	11.3	6 962	11.4	5 911	11.1

Сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцсон эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 7.9 мянгаар илүү байгаа нь эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд давамгайлж байгааг харуулна. Ялангуяа, 20-54 насанд эрэгтэйчүүд илүү байгаа юм. Ахимаг насанд эрэгтэйчүүдийн шилжих хөдөлгөөн давамгайлж байгааг тэд эхлээд зорьсон газраа ганцаараа очиж, дараа ар гэрийнхнийгээ татаж авч байгаатай холбон тайлбарлаж болно. Шилжигсэдийн дотор 15-29 насны залуучууд илүү ихээр шилжсэн (нийт шилжигсэдийн 53.4 хувь) нь их, дээд, мэргэжлийн сургуульд суралцагчдыг тоолох үед байгаа газарт нь тоолсонтой холбоотой. Нөгөө талаар 15-аас доош насны хүүхдүүд, 60-аас дээш насны өндөр настнууд багагүй хэмжээгээр шилжих хөдөлгөөнд оролцсон байгаагаас үзэхэд гэр бүлийн шилжилт байгааг

гэрчилнэ. Онолын хувьд хүүхэд, өндөр настнууд эцэг эх болон асран хамгаалагчийнхаа хамт шилждэг билээ (зураг 5.5).


ЗУРАГ 5.6. СҮҮЛЧИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИГСЭД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН



ХОТЖИЛТ

Хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг шилжих хөдөлгөөний өсөлт бүрдүүлдэг. Нийслэлээс гадна аймгийн төвүүд нь орон нутагтаа боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээний чанараар хөдөөнөөс илүү байдгийн зэрэгцээгээр, үйлдвэрлэл, үйчилгээ эрхлэх, ажлын байр олох боломж илүү байдаг нь тодорхой юм. Ялангуяа, сүүлчийн жилүүдэд тохиолдож байгаа байгалийн гамшигт үзэгдлүүд малчдад хүндээр тусч, төв, суурин газарт шилжих нь нэмэгдсэнээс манай улсын хотжих үйл явц өмнөхөөсөө илүү хурдацтай явагдаж байна. Хотуудын хүн амын 2000-2010 оны өсөлтийг дөрөвдүгээр бүлгээс үзнэ үү.

ЗУРАГ 5.7. УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРЭГЧИД, БҮС НУТГААР, 2010 ОН (ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮГЭЭР, МЯН.ХҮН)



Хотуудын хүн амын өсөлт хурдацтай явагдаж байгааг дээр тэмдэглэсэн. Улаанбаатар хотын хүн амын өсөлт бусад хотуудаас ихээхэн илүү байгаа төдийгүй 2 тооллогын хооронд 349.2 мянган хүнээр (51.9 хувь) нэмэгдэж, 2010 оны тооллогын дүнгээр улсын нийт хүн амын 43.2 хувийг эзэлдэг болов.

Сүүлчийн арван жилд хотжих үйл явц хамгийн их явагдсан бүс нутаг бол хангайн бүс бөгөөд энэ бүсэд аялал, жуулчлал, амралт, сувиллын салбар илүүтэй хөгжсөн болон улсын 2 дахь том хот болох Эрдэнэт оршдогтой холбоотой. Өвөрхангай аймгийн хотын хүн ам 2 дахин, Баянхонгор аймгийнх 35 хувиар өсч улсад тэргүүлжээ. Өвөрхангай аймгийн хотын хүн ам ийнхүү эрчимтэй нэмэгдсэн нь аялал жуулчлал өргөн хөгжиж, Хархорин сумын төв тосгоны статустай болсонтой холбоотой юм.

Мөн Монгол Улсын төмөр замын дагуу хотжих үйл явц хурдацтай явагдаж байгааг 5.12 дугаар хүснэгтийн тоо баримтаас харж болно. Төвийн бүсэд Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул аймаг хотод шилжин ирэгчид олонтой аймагт орж байна. Дорноговь аймаг БНХАУ-тай хиллэдэг бөгөөд хилийн боомт хот Замын-Үүд бүс нутгийн хамгийн тохиромжтой худалдааны төв болон өргөжсөөр байна. Цаашдаа уул уурхай хайгуул, үйлдвэрлэл дагасан тосгон суурингууд буй болж, хүн ам ихээр төвлөрөх болсон Өмнөговь аймгийн хотын хүн ам эрчимтэй нэмэгдэхээр байна.

ХҮСНЭГТ 5.11. ХОТЫН ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Хотын хүн амын тоо		Өсөлтийн хувь	Дүнд эзлэх хувь	
	2000	2010		2000	2010
БҮГД	1 344 516	1 798 147	133.7	100.0	100.0
Баруун бүс	122 701	122 334	99.7	9.1	6.8
Баян-Өлгий	28 060	30 663	109.3	2.1	1.7
Говь-Алтай	18 023	17 962	99.7	1.3	1.0
Завхан	24 276	17 485	72.0	1.8	1.0
Увс	26 319	27 178	103.3	2.0	1.5
Ховд	26 023	29 046	111.6	1.9	1.6
Хангайн бүс	175 681	225 221	128.2	13.1	12.5
Архангай	18 519	20 619	111.3	1.4	1.1
Баянхонгор	22 066	29 829	135.2	1.6	1.7
Булган	16 239	14 116	86.9	1.2	0.8
Орхон	68 310	84 187	123.2	5.1	4.7
Өвөрхангай	19 058	38 027	199.5	1.4	2.1
Хөвсгөл	31 489	38 443	122.1	2.3	2.1
Төвийн бүс	201 357	211 451	105.0	15.0	11.8
Говьсүмбэр	8 983	9 742	108.4	0.7	0.5
Дархан-Уул	65 791	74 985	114.0	4.9	4.2
Дорноговь	25 210	33 932	134.6	1.9	1.9
Дундговь	14 517	13 664	94.1	1.1	0.8
Өмнөговь	14 183	18 781	132.4	1.1	1.0
Сэлэнгэ	56 446	47 008	83.3	4.2	2.6
Төв	16 227	13 339	82.2	1.2	0.7
Зүүн бүс	84 700	84 851	100.2	6.3	4.7
Дорнод	41 714	38 615	92.6	3.1	2.1
Сүхбаатар	15 133	16 150	106.7	1.1	0.9
Хэнтий	27 853	30 086	108.0	2.1	1.7
Улаанбаатар	760 077	1 154 290	151.9	56.5	64.2

ДҮГНЭЛТ

Хүн амын шилжих хөдөлгөөний сүүлчийн 11 жилийн дүр төрх өмнөх 11 жилийнхтэй ерөнхийдөө төстэй ажээ. Төрснөөс хойших шилжигчдийн урсгалаас харахад нэлээд сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Улаанбаатар хотод төрсөн, тоолох үед нийслэлд байнга оршин сууж байгаа хүн амын эзлэх хувь 92.3 байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээ төвшинд байна. Улаанбаатар хотод төрсөн хүмүүс өөр бүсэд шилжин суурьших сонирхол тун бага байгааг сүүлчийн хоёр тооллогын дүн харуулав.

Таван жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийхтэй ерөнхийдөө адил юм. Нийслэл хотоос бусад бүс нутгийн шилжих хөдөлгөөний урсгал гадагшаа чиглэжээ. Баруун бүс нутгаас бусад бүс нутаг руу шилжсэн хүний тоо хамгийн олон, дараа нь хангайн бүс орж байна. Баруун бүсээс бусад бүс нутгийн шилжих хөдөлгөөний цэвэр урсгал (Шилжин ирсэн явсан хүний зөрүү) тийм ч их биш байгаа юм. Улаанбаатар хотын хүн ам 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 135.7 хүнээр нэмэгдсэн нь тоолох үед байнга оршин сууж байсан хүн амын 11.8 хувийг эзэлж байна. Гэтэл баруун бүсээс 5 жилийн дотор цэвэр шилжин явсан хүн амын тоо, тоолох үед тухайн бүсэд тоологдсон хүн амын 12.8 хувь болж байна. Өөрөөр хэлбэл, баруун бүс 2005 оноос хойш одоо байгаа хүнийхээ 12.8 хувьтай тэнцэх хүнийг гадагш алджээ.

Тооллогын товоос өмнөх нэг жилд улсын хэмээнд 101.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцсон нь Өвөрхангай аймгийн суурин хүн амтай тэнцүү юм. Энэ үзүүлэлт улсын хэмжээний суурин хүн амын 3.8 хувийг эзэлж байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт бөгөөд хот хоорондын зорчигч тээвэр болон бусад шилжих хөдөлгөөнд оролцогчдын нийгмийн асуудлыг зохицуулахад энэ үзүүлэлт гол үндэслэл болох учиртай.

Хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг шилжих хөдөлгөөний өсөлт бүрдүүлж байна. Нийслэлээс гадна аймгийн төвүүд орон нутагтаа боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээний чанараар хөдөөнөөс илүү байдгийн зэрэгцээгээр, үйлдвэрлэл, үйчилгээ эрхлэх, ажлын байр олох боломж илүү байдаг нь тодорхой юм. Ялангуяа, сүүлчийн жилүүдэд тохиолдож байгаа байгалийн гамшигт үзэгдлүүд малчдад хүндээр тусч, төв, суурин газарт шилжих нь нэмэгдсэнээс манай улсын хотжих үйл явц өмнөхөөсөө илүү хурдацтай явагдаж байна.

Нийслэл хотоос гадна Хангайн бүсэд Өвөрхангай, Баянхонгор аймаг, Орхон аймаг, төвийн бүсэд Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул аймаг хот, суурин газар шилжин ирэгчид олонтой юм.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ



БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн амын эрүүл мэнд, төрөлт, нас баралт, гэрлэлт, шилжих хөдөлгөөн зэрэг хүн ам зүйн үзэгдэл, хөдөлмөр эрхлэлт, орлогын төвшин зэрэг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд боловсролоос ихээхэн хамаардаг. Иймд боловсролыг олон асуудалтай холбон судалдаг.

Боловсрол нь хүн амын ажиллаж, амьдрах чадавх, хүмүүн капиталд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг харуулах чухал үзүүлэлт юм. Тооллогоор хүн амын боловсролын төвшинг тодорхойлох нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, ажиллах хүч, шилжих хөдөлгөөн, байршил, орон сууц зэрэг үндэсний болон бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээний бодлого, төлөвлөлтийг боловсруулахад нэн чухал билээ.

Хүний хөгжлийн үзүүлэлтийн нэг болох хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгийг илэрхийлэх үзүүлэлтийг тус улсын бүх хүн амын тооллогод тусгасан учраас эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг тодорхойлох бүрэн боломжтой. Хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн төвшингийн үзүүлэлт нь төр, засгаас хүнийг хөгжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтын үр дүнг илэрхийлдэг тул тооллогоор нэлээд дэлгэрэнгүй судалдаг.

Боловсролын тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлд “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ”⁴ гэж заасан үндсэн агуулгад сүүлчийн тооллогуудын асуулга, аргачлал, заавар, үр дүн нийцэж байгаа.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгад бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшинд холбогдох асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс, 2-39 насны хүнээс сургуульд сурдаг, цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг асуусан.

Бага, дунд боловсролын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлд “Бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ”⁵, мөн Дээд боловсролын тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлд “Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх сургалтын кредит цагийг оролцуулан тооцон бакалаврын сургалт 120 багц цагаас, магистрын сургалт 150 багц цагаас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна”⁶ гэж заажээ.

⁴ Боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 369

⁵ Бага, дунд боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 392

⁶ Дээд боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 404

БОЛОВСРОЛЫН ТӨВШИН

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойших 20 орчим жилд боловсролын тогтолцоог шинэчилж, хөгжингүй орны боловсролын стандартыг нэвтрүүлж байна. Тиймээс тооллого хоорондын хүн амын боловсролын төвшинг зэрэгцүүлэн жишиж өөрчлөлтийг харах нь чухал билээ. Төвлөрсөн төлөвлөлгөөт нийгмийн харилцаанд мөрдөж байсан боловсролын ангилал 2000 оны тооллогын үеийнхээс нэлээд ялгаатай болсон тул 1989, 2000 оны тооллогын дүнг тодорхой хэмжээгээр бүлэглэж зэрэгцүүлсэн. Энэ удаа хүн амын боловсролын төвшинг НҮБ-ын зөвлөмж, олон улсын нийтлэг жишгийг харгалзан 10, түүнээс дээш насныханд тодорхойлов.

Арав, түүнээс дээш насны хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 4.1 пунктээр нэмэгдэж, 92.5 хувь болсон байна.

ХҮСНЭГТ 6.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН

Боловсролын төвшин	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	11.6	11.7	11.5	7.5	8.0	6.9
Боловсролтой	88.4	88.3	88.5	92.5	92.0	93.1
Дээд	7.6	7.6	7.7	18.3	15.4	21.2
Тусгай мэргэжлийн дунд	7.6	5.7	9.4	5.7	4.6	6.9
Техникийн болон мэргэжлийн	3.6	3.9	3.4	2.8	3.1	2.6
Бүрэн дунд	21.0	19.1	22.8	32.0	32.2	31.9
Суурь	25.1	28.3	22.1	17.9	20.3	15.6
Бага	23.4	23.8	23.1	15.8	16.6	15.0

Улсын болон хувийн хэвшлийн олон их, дээд сургууль байгуулагдаж, түүнд олон арван мянган залуучууд суралцан, төгсөж байгаагийн дүнд 10, түүнээс дээш насны нийт хүн амд дээд боловсролтой хүний эзлэх хувь өнгөрсөн 11 жилд 10.7 пунктээр нэмэгдсэн нь нэг талаар сайн үзүүлэлт боловч нөгөө талдаа үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллах дунд болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурсан байна. Мөн бага болон суурь боловсрол эзэмшигчдийн хувийн жин буурч, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийнх өссөн нь нэг талаас эцэг эхчүүд хүүхэддээ аль болох дээд боловсрол эзэмшүүлэх сонирхолтой болсонтой холбоотой.

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдана. Ялангуяа, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь тооллого хооронд 2 дахин өссөн байхад эмэгтэйчүүдийнх 2.8 дахин нэмэгджээ. Гэтэл тусгай мэргэжлийн дунд, мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурсны дотор эмэгтэйчүүдийнх нь эрэгтэйчүүдийнхээс илүү буурсан байна.

Арав, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь нэлэнхүйдээ буурсны дотор эмэгтэйчүүдийнх илүү буурчээ. Нийгмийн хөгжлийн явцад хүн амын боловсрол эзэмших хэрэгцээ, шаардлага, боломж, хандлага өөр өөр байлаа. Өмнөх тооллогуудын дүнгээс үзэхэд нас ахисан хүмүүсийн боловсролын төвшин залуу үеийнхтэй харьцуулахад бага байдаг байсан. Сүүлчийн үед нас дэвшилтээс шалтгаалан боловсрол өндөртэй залуу үе бага боловсролтой ахмад насны хүмүүсийг түрж, боловсролын төвшний ерөнхий байдал сайжрахад нөлөөсөн.

Хүн амын боловсролын байдлыг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд ялгаатай тал харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Боловсролын төвшин	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	4.9	5.2	4.6	13.1	13.7	12.5
Боловсролтой	95.1	94.8	95.4	86.9	86.3	87.5
Дээд	23.4	20.2	26.4	7.0	5.6	8.6
Тусгай мэргэжлийн дунд	6.5	5.3	7.5	4.2	3.0	5.4
Техникийн болон мэргэжлийн	2.5	2.8	2.2	3.5	3.5	3.5
Бүрэн дунд	37.6	38.8	36.5	19.6	18.6	20.6
Суурь	14.3	16.5	12.2	26.0	27.9	23.9
Бага	10.8	11.1	10.6	26.6	27.6	25.5

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын төвшин дээшлэх тутам боловсролын ялгаа нь нэмэгдэх ажээ. Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 2.7 дахин өндөр бол дээд боловсролтой хотын хүн ам хөдөөгийнхөөс 3.3 дахин их байна. Харин хотод бүрэн дунд боловсролтой хүн ам олон байхад хөдөөд суурь болон бага боловсролтой хүн илүү олон байна. Хөдөөгийн дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс илүү байгаагаас үзэхэд хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсролтой байна. Хотод энэ байдал бас давтагдаж байна.


ХҮСНЭГТ 6.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
БҮГД	100.0	18.3	5.7	2.8	32.0	17.9	15.8	7.5
10-14	100.0	-	-	-	-	7.2	59.8	33.0
15-19	100.0	0.6	1.0	1.8	39.4	41.0	12.8	3.4
20-24	100.0	23.8	2.7	2.8	51.3	9.7	5.7	4.0
25-29	100.0	36.1	2.2	1.5	31.1	13.0	10.2	6.1
30-34	100.0	27.3	3.0	1.5	34.9	19.6	10.1	3.7
35-39	100.0	21.5	7.4	4.4	40.3	20.3	4.0	2.1
40-44	100.0	17.9	11.7	5.9	39.4	18.2	4.5	2.5
45-49	100.0	19.8	12.7	5.6	33.9	18.3	6.5	3.1
50-54	100.0	20.0	13.9	5.0	27.1	19.7	11.2	3.1
55-59	100.0	19.4	15.1	4.1	23.8	17.2	16.8	3.7
60 +	100.0	17.2	11.0	2.2	15.7	11.5	30.6	11.7

Боловсролын төвшинг насаар ангилж үзэхэд зарим сонирхолтой дүр зураг ажиглагдана. Дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүний эзлэх хувь 30-34 насны буурч байснаа 45-54 насанд нэмэгдэж, цаашдаа буурчээ. Энэ нь 1960-аад оны эхнээс манай улсад дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой боловсон хүчнийг олноор нь бэлтгэж байсантай холбоотой. Харин боловсролгүй хүний эзлэх хувь нас ахих тутам нэмэгдэж байгаа нь зүй ёсны асуудал юм. Ахимаг насны хүмүүсийн боловсролын төвшин ерөнхийдөө доогуур, тэдний 1/3 нь бага боловсролтой, 11.7 хувь нь боловсролгүй байна. Харин 20-34 насны дээд боловсролтой хүний эзлэх хувийн жин хамгийн өндөр байгаа нь зүй ёсных боловч энэ насны боловсролгүй хүний эзлэх хувь бусад наснаас өндөр байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөн шилжилтийн үед сургууль завсардалт өндөр байсныг гэрчилнэ. Ерөнхийдөө 20-40 хүртэл насны хүмүүсийн боловсролын төвшин сайн харагдаж байна. Гэвч тухайн насны хүн амын дотор мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь бага байгаа нь үйлдвэрлэл, үйчилгээнд ажиллах мэргэжилтэй ажилчдын хүрэлцээ хангалтгүй байгааг харуулна.

Олон улсын жишиг, хандлагатай зэрэгцүүлэхэд манай улсын дээд, тусгай мэргэжлийн дунд болон мэргэжлийн боловсролтой хүний харьцаа нэлээд өөр байна. Тухайлбал, манай улсын дээд боловсролтой 6 хүнд нэг мэргэжлийн боловсролтой хүн, дээд боловсролтой 3 хүнд 1 тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн ногдож байна.

ЗУРАГ 6.1. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН




Орчин үед эмэгтэйчүүд дээд боловсрол эзэмших нь эрэгтэйчүүдээс илүү байгааг өмнө дурдсан. Энэ байдал үргэлж ийм байгаагүй юм. Хүн амын боловсролын төвшин улс орны тухайн үеийн хөгжлийн чиг хандлагаас шалтгаалан янз бүр байсныг дээрх зургаас харж болно. Одоогоос 30 жил, түүнээс өмнө дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийн хувьд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс илүү байжээ. Харин 50 хүртэл насанд дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн дотор 25-29 насанд хамгийн өндөр байна.

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх НҮБ-ын зөвлөмжийг 2000, 2010 оны тооллогод үндсэнд нь баримталсан юм. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн. Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүнээс бичиг үсэг мэддэг эсэхийг тодруулж асуусан.

ЗУРАГ 6.2. ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2010 ОН



Хүн амын бичиг үсгийн мэдлэгийн төвшинг олон улсын хэмжээнд зэрэгцүүлэхэд дөхөм болгож, 15, түүнээс дээш насаар тодорхойлов.


ХҮСНЭГТ 6.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Бичиг үсгийн мэдлэг	2000					2010				
	Бүгд	Байршил				Бүгд	Байршил			
		Хот	Хөдөө		Хот		Хөдөө			
	дүнд эзлэх хувь	мян. хүн	дүнд эзлэх хувь	мян. хүн	дүнд эзлэх хувь	дүнд эзлэх хувь	мян. хүн	дүнд эзлэх хувь	мян. хүн	дүнд эзлэх хувь
БҮГД	100.0	898.7	100.0	625.7	100.0	100.0	1331.7	100.0	574.3	100.0
Бичиг үсэг мэддэг	97.8	888.4	98.9	602.0	96.2	98.3	1319.8	99.1	553.0	96.3
Бичиг үсэг мэддэггүй	2.2	10.3	1.1	23.7	3.8	1.7	11.9	0.9	21.3	3.7

Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 98.3 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь олон улсынхтай зэрэгцүүлэхэд өндөр байна. Харин хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд ялгаа их байгаа юм. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын хувь хөдөөгийнхөөс 4.1 дахин бага байна. Арван тав, түүнээс дээш насны хотын хүн амын 0.9 хувь буюу 12 орчим мянган хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагаас үзэхэд хотынхон бараг бүхэлдээ бичигтэн болсон гэж болно. Энэ үзүүлэлтэд хөгжлийн бэрхшээлийн улмаас бичиг үсэг сурах боломжгүй хүн орсныг харгалзан үзэх учиртай.

Бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувийг насаар ангилж үзэхэд анхаарах асуудал ажиглагдана. 15-29 насны залуучуудын 1.7 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь бага мэт боловч хүнийхээ тооноос хамаарч тэд нийт бичиг үсэг мэддэггүй 15, түүнээс дээш насны хүн амын 42.0 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлт хөдөөгийн залуучуудын дотор 43.4 хувь байна. Бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь 85-аас дээш насанд харьцангуй өндөр байгаа юм.

ЗУРАГ 6.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод сургуульд суралцаж байгаа болон цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхийг 2-39 насныхнаас асуусан.

НҮБ-ын зөвлөмжийн дагуу сургуульд суралцах насыг 5-29 насаар авч үзэх ёстой боловч манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбогдуулан сургуульд хамрагдалтыг 6-29 насаар тодорхойлов.

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирчээ. Тухайлбал, 2000 онд 8 настай бүх хүүхдийн 84.8 хувь нь сургуульд сурч байсан бол 2010 онд 98.4 хувь болж өсчээ. Есөн настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2000 онд 93.3 хувь байсан нь хамгийн өндөр байсан бол 2010 онд 98.5 хувь болж нэмэгдэв. Сургуульд хамрагдалт арван нэгэн жилийн өмнө 12 наснаас нэлээд буурч, 88.8-аас доош хувьтай байсан бол 2010 онд уг үзүүлэлт 15 наснаас эхлэн буурч байгаагаас үзэхэд бүрэн дунд боловсрол эзэмших насны хүүхдийн сургуульд хамрагдалт эрс нэмэгдсэн гэж дүгнэх үндэслэлтэй юм (Хүснэгт 6.5).

ХҮСНЭГТ 6.5. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Нас	Сургуульд суралцаж байгаа			Сургуульд суралцаагүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
6-29	58.1	55.7	60.6	41.9	44.3	39.4
6	93.6	93.0	94.3	6.4	7.0	5.7
7	97.9	97.7	98.1	2.1	2.3	1.9
8	98.4	98.3	98.6	1.6	1.7	1.4
9	98.5	98.3	98.6	1.5	1.7	1.4
6-9	97.1	96.8	97.4	2.9	3.2	2.6
10	98.2	97.9	98.5	1.8	2.1	1.5
11	97.6	97.1	98.1	2.4	2.9	1.9
12	96.7	95.8	97.7	3.3	4.2	2.3
13	95.8	94.6	97.0	4.2	5.4	3.0
14	94.7	92.8	96.7	5.3	7.2	3.3
10-14	96.6	95.6	97.6	3.4	4.4	2.4
15	93.0	90.5	95.6	7.0	9.5	4.4
16	89.5	85.5	93.6	10.5	14.5	6.4
17	84.0	79.0	89.2	16.0	21.0	10.8
6-17	94.8	93.3	96.3	5.2	6.7	3.7
18	72.5	65.2	80.0	27.5	34.8	20.0
19	61.0	52.2	69.9	39.0	47.8	30.1
20-24	29.8	25.8	33.8	70.2	74.2	66.2
25-29	5.6	4.7	6.5	94.4	95.3	93.5

Хэдийгээр сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс сайжирсан боловч анхаарах асуудлууд байсаар байна. Суурь боловсрол эзэмших насны хүүхдүүдийн дотор 12 наснаас сургуульд хамрагдалт мэдэгдэхүйц буурч байна. Ялангуяа, эрэгтэй хүүхдийн хувьд илүү байгаа юм. Бүх нийтээр суурь боловсрол эзэмших ёстой хэдий ч улсын хэмжээнд 2010 оны байдлаар 6-14 насны 13.0 мянган хүүхэд сургуульд суралцахгүй байгаагийн 8.0 мянга буюу 61.5 хувь нь хөвгүүд, 5.0 мянга буюу 38.5 хувь нь охид байна.

Сургуульд хамрагдалт хот, хөдөөд ялгаатай байна. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт нийт дүнгээрээ хотод 60.1 хувь байхад хөдөөд түүнээс 6.3 пунктээр доогуур байна.

ХҮСНЭГТ 6.6. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Нас	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
6-29	60.1	58.4	61.8	53.8	50.2	57.8
6	96.1	95.8	96.5	89.6	88.5	90.7
7	98.4	98.3	98.5	97.0	96.7	97.4
8	98.7	98.6	98.7	98.0	97.8	98.3
9	98.7	98.6	98.9	98.0	97.8	98.2
6-9	98.0	97.8	98.2	95.7	95.3	96.2
10-14	97.6	97.1	98.0	95.1	93.4	96.9
15-17	93.0	91.1	94.8	80.7	73.5	88.7
15	95.8	94.7	96.9	88.2	83.5	93.1
16	93.5	91.7	95.4	81.2	73.4	89.8
17	89.6	86.9	92.2	68.8	59.5	79.9
6-17	96.4	95.6	97.2	92.0	89.3	94.8
18	81.4	76.8	85.7	35.4	27.7	47.8
19	71.7	64.9	77.9	17.4	13.1	24.5
20-24	37.3	33.5	40.9	6.2	5.1	7.6
25-29	7.2	6.1	8.3	2.0	1.8	2.2


Суурь боловсрол эзэмших насны хүн амын сургуульд хамрагдалтын хувь хот, хөдөөгөөр харьцангуй ойролцоо байгаа боловч ахлах ангид дэвшин суралцах нас буюу 15 наснаас эхлэн зөрүү нь нэмэгдэж байна. Арван найман наснаас эхлэн энэ хувь хотод 80-аас, хөдөөд 30-аас бага болсон байна. Ялангуяа, мэргэжлийн сургуульд суралцах 20-24 насанд сургуульд хамрагдалт хотод хөдөөгөөс 6 дахин өндөр байгаа юм. Дээд болон тусгай мэргэжлийн дунд сургууль хөдөөд байдаггүй, хөдөөгийн олон мянган охид хөвгүүд хот руу шилжиж сургуульд үргэлжлүүлэн суралцдаг тул хөдөөгийн залуучуудын сургуульд хамрагдалт ийнхүү бага гарч байна. Нөгөө талаар, тооллого 11 дүгээр сард явагдаж дээд, тусгай дунд, мэргэжлийн сургуульд суралцагчдыг байгаа газарт нь байнга суугчаар тоолсон нь дээрх үзүүлэлтэд бас нөлөөлсөн.

Сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь бүх насны бүлэгт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь эмэгтэйчүүд суралцагчдын дотор давамгайлж байгааг илтгэнэ. Эмэгтэйчүүдийн энэ давуутай байдал хот, хөдөөд аль алинд нь харагдаж байна.

Нас, боловсролын төвшин дээшлэх тутам эмэгтэйчүүдийн давамгайл байдал өссөөр байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол сургуульд ороходоо төдийгүй орсныхоо дараа ч сургуулиас завсардахгүй, тууштай суралцаж байгаатай холбоотой.

Хүйсийн харьцаа 100-тай тэнцүү байхад ижил тооны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд сургуульд суралцаж байна гэсэн утга билээ. 20-24, 25-29 насны бүлэгт хүйсийн харьцаа 130-140 болж, 30-34 насанд 160-д ойртож байна.

ЗУРАГ 6.4. СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны хүүхдийн 60.1 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Сургуульд орох нас дөхөх тусам сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нэмэгдэх ажээ. Тухайлбал, 2 настай хүүхдийн 44.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан бол 5 настай хүүхдүүдийнх 75.5 хувь нь хамрагдаж байна. Хотод амьдардаг хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 68.2 хувь байхад хөдөөд 45.6 хувь байгаа нь хөдөөгийн малчдад энэ чиглэлийн үйлчилгээ ихээхэн хэрэгцээтэй байгааг харуулна.

ХҮСНЭГТ 6.7. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Нас	Бүгд		Байршил			
			Хот		Хөдөө	
	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь
БҮГД	121.6	60.1	88.6	68.2	33.1	45.6
2	27.4	44.5	20.6	51.6	6.8	31.5
3	30.9	59.2	23.2	68.4	7.7	42.1
4	30.7	67.5	22.2	76.9	8.5	51.2
5	32.7	75.5	22.6	83.0	10.1	62.7

ДҮГНЭЛТ

Боловсролын төвшин

Арав, түүнээс дээш насны хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 4.1 пунктээр нэмэгдэв. Арав, түүнээс дээш насны хүн амд дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өнгөрсөн 11 жилд 10.7 пунктээр нэмэгдсэн нь нэг талаар сайн үзүүлэлт боловч дээд, тусгай дунд, мэргэжлийн боловсролтой хүн амын зохистой харьцаа алдагдсан байна.

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай талууд ажиглагдана. Ялангуяа, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь хоёр тооллогын хооронд 2 дахин өссөн байхад эмэгтэйчүүдийнх 2.8 дахин өссөн дүн гарч байна.

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын төвшин ихээхэн ялгаатай бөгөөд боловсролын төвшин дээшлэх тутамд зөрүү нь нэмэгдэж байна. Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 2.7 дахин өндөр байна. Хөдөөд дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Харин суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаагаас үзэхэд хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсролтой байна. Энэ байдал хотод ч бас ижил хандлагатай байна.

Бичиг үсгийн мэдлэг

Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 98.3 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь олон улсын дунджаас өндөр байна. Харин хот, хөдөөгийн хүн амын хувьд ялгаа их байгаа юм. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь хөдөөгийнхөөс дөрөв дахин бага, тэдний дотор 0.9 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаагаас үзэхэд хотынхон бараг бичигтэн болсон гэж үзэж болно.

Сургууль, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирч, 2000 онд 8 насны хүн амын 84.8 хувь нь сургуульд сурч байсан бол 2010 онд 98.4 хувь болж өсчээ. Есөн настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2000 онд 93.3 хувь байсан бол 2010 онд 98.5 хувь болж нэмэгдсэн байна. 2000 оны хамрагдалт 12 наснаас эхлэн буурч, 88.8-аас доош хувьтай байсан бол 2010 онд энэ үзүүлэлт 15 наснаас эхлэн багасч байна. Энэ нь бүрэн дунд боловсрол эзэмших насны хүүхдийн сургуульд хамрагдалт эрс нэмэгдсэнийг гэрчилнэ.

Бүх насны бүлэгт сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Эмэгтэйчүүдийн энэхүү давуу байдал хот, хөдөөд ч адил байгаа юм.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны хүүхдүүдийн 60.1 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа бол хөдөөгийн 2 хүүхэд тутмын нэг нь энэ төрлийн үйлчилгээ авч чадахгүй байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ


ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ



ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийг өмнөх тооллогын нэгэн адил судалсан боловч өрхөд тоологдсон, өрх үүсгээгүй тоологдсон хүний тодорхойлолт өмнөх тооллогоос ялгаатай байлаа. Гэр бүл, ураг төрлийн хамааралтай хүмүүс өрх үүсгэж тоологдох, хоорондоо огт хамааралгүй хүмүүс нэг орон байранд хамт тоологдох гэсэн 2 хэлбэр байлаа. Өрхөд хамаарахгүй хүмүүст цэрэг, хоригдол, оюутнууд, албан болон албан бусаар ашигт малтмал олборлогчид, орон гэргүй иргэд зонхилж байв.

ЗУРАГ 7.1. ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2010 ОН



Суурин хүн амын 96.5 хувь нь 713.8 мянган өрхөд, үлдсэн 3.5 хувь буюу 93.8 мянган хүн өрхөд хамаарахгүйгээр тоологджээ. Өрхөд тоологдсон хүний хувь өмнөх тооллогын үеийнхээс 2 пунктээр буурсан бол өрх өрхөд хамаарахгүй хүний хувь эсрэгээрээ 2 пунктээр нэмэгдсэн нь оюутан, сурагчид, албан бусаар ашигт малтмал олборлогчид нэмэгдсэнтэй холбоотой.

ХҮСНЭГТ 7.1. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Байршил	2000		2010		2010 / 2000 %
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	
БҮГД	541.1	100.0	713.8	100.0	131.9
Хот	296.4	54.8	479.5	67.2	161.8
Хөдөө	244.7	45.2	234.3	32.8	95.7

Нийт өрхийн тоо 2000 оныхоос 31.9 хувиар өссөний дотор хотын өрх 61.8 хувиар нэмэгдэж, хөдөөгийн өрх 4.3 хувиар буурчээ. Энэ нь хөдөөнөөс төв суурин руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

Хүн ам, орон сууны 2000 оны тооллогоос эхлэн НҮБ-ын аргачлалын дагуу өрхийг хэлбэрээр нь ангилан тодорхойлж байна. Ингэж ангилахдаа өрхийн гишүүд өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг харгалзаж үздэг. Энэ нь улс орны хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн дунд болон урт хугацааны бодлого боловсруулах үндсэн мэдээлэл болдог. Өрхийг хэлбэрээр ангилсан тодорхойлолтыг 1 дүгээр бүлгийн “Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт” гэсэн хэсгээс үзнэ үү.

ЗУРАГ 7.2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



Нийт өрхийн 10.6 хувь нь ганц бие, 62.4 хувь нь ам бүлээрээ байгаа, 24.9 хувь нь нийлмэл, 2.1 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу нөхөр, эхнэр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна. Мөн нийлмэл буюу эцэг эх, ах, дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрх ч олон юм. Энэ нь өрхийн ам бүлийн бүтцийн түгээмэл хэлбэрүүд бөгөөд үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь эцэг эх, ахмад настнаа хүндлэн асардаг манай уламжлалт заншилтай холбоотой.

ХҮСНЭГТ 7.2. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Байршил	Бүгд		Ганц бие өрх		Ам бүлээрээ байгаа өрх		Нийлмэл ам бүлтэй өрх		Холимог ам бүлтэй өрх	
	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь
БҮГД	713.8		75.9	10.6	445.0	62.4	177.9	24.9	14.9	2.1
Хот	479.5		47.2	9.9	275.6	57.5	145.2	30.3	11.4	2.4
Хөдөө	234.3		28.7	12.2	169.4	72.3	32.7	13.9	3.5	1.5

Өрхийн бүтцийг хот, хөдөөгөөр ангилахад ялгаатай байдал нэлээд ажиглагдана. Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод (145.2 мянга) хөдөөнөөс (32.7 мянга) 4.4 дахин олон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс (2000 онд энэ үзүүлэлт 2 дахин их байсан) 2 дахин өсчээ. Энэ нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ, хангамж тааруу, хөдөөнөөс шилжин ирэгчид хамаатан садантайгаа хамт амьдрах нь ихэсч байгаагаас шалтгаалж байна. Үүний зэрэгцээгээр хотод ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 2.9 дахин өссөнийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм.

ХҮСНЭГТ 7.3. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Байршил	Бүгд		1-2		3-4		5-6		7+	
	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь	мян. өрх	хувь
БҮГД	713.8	100.0	190.6	26.7	337.6	47.3	154.0	21.6	31.6	4.4
Хот	479.5	100.0	124.0	25.9	229.7	47.9	102.3	21.3	23.6	4.9
Хөдөө	234.3	100.0	66.6	28.4	107.9	46.1	51.7	22.1	8.0	3.4

Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2000 онд 4.3 байсан бол 2010 онд 3.6 болж буурав. Өрхийн ам бүлийн тоо хот, хөдөөд ялгаатай байгаа боловч 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь хот, хөдөөд бараг адил байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 2000 онд 1-2 ам бүлтэй өрх хөдөөд хотоос 4.5 пунктээр илүү байсан бол 2010 онд хотод хөдөөгөөс 2.5 пунктээр илүү болсон байна. Энэ нь хотод их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм. Долоо, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо ч хотод хөдөөгөөс 3 дахин олон байгаа нь хотод нийлмэл болон холимог өрх хөдөөгөөс олон байсантай тохирч байна.

Өрхийн ам бүлийн дундаж тоо Баян-Өлгий аймагт хамгийн өндөр бөгөөд улсын дунджаас бараг нэг хүнээр илүү юм. Энэ зөрүү 2000 оныхоос нэмэгдсэн нь улсын хэмжээний өрхийн ам бүлийн тоо өмнөх тооллогын үеийнхээс нэлээд буурсантай холбоотой.

ХҮСНЭГТ 7.4. ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Ам бүлийн тоогоор				Өрхийн ам бүлийн дундаж тоо
		1-2	3-4	5-6	7+	
БҮГД	100.0	28.1	47.1	21.2	3.6	3.6
Архангай	100.0	30.8	48.1	19.4	1.7	3.3
Баян-Өлгий	100.0	13.6	40.5	35.0	10.9	4.4
Баянхонгор	100.0	29.5	46.4	21.2	2.9	3.4
Булган	100.0	32.1	48.8	17.5	1.6	3.3
Говь-Алтай	100.0	26.9	49.0	21.7	2.4	3.5
Дорноговь	100.0	31.5	47.3	18.5	2.7	3.3
Дорнод	100.0	29.4	45.3	20.7	4.6	3.5
Дундговь	100.0	29.7	47.3	20.1	2.9	3.4
Завхан	100.0	29.2	48.3	20.3	2.2	3.4
Өвөрхангай	100.0	27.0	48.7	21.5	2.8	3.5
Өмнөговь	100.0	33.1	46.1	18.2	2.6	3.3
Сүхбаатар	100.0	24.8	51.3	20.9	3.0	3.5
Сэлэнгэ	100.0	28.3	48.8	19.5	3.4	3.5
Төв	100.0	33.2	46.6	17.9	2.3	3.3
Увс	100.0	23.1	42.9	28.1	5.9	3.8
Ховд	100.0	21.9	43.3	28.4	6.4	3.9
Хөвсгөл	100.0	28.9	48.6	20.0	2.5	3.4
Хэнтий	100.0	32.8	45.3	18.9	3.0	3.3
Дархан-Уул	100.0	26.9	49.0	20.2	3.9	3.5
Улаанбаатар	100.0	24.9	47.3	22.1	5.7	3.7
Орхон	100.0	26.0	51.8	18.7	3.5	3.5
Говьсүмбэр	100.0	33.8	45.9	17.1	3.2	3.3

Баян-Өлгий аймгийн дараа Ховд, Увс аймгийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дунджаас илүү байгаа нь харагдлаа. Долоо, түүнээс дээш ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий аймагт улсын дунджаас 3 дахин илүү байгаа нь үндэстний онцлог юм. Увс, Ховд аймаг, Улаанбаатар хотод энэ үзүүлэлт улсын дунджаас илүү байна.

Өрхийн тэргүүлэгчийг хүйс, байршлаар ангилахад ялгаатай талууд ажиглагдана.

ХҮСНЭГТ 7.5. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Өрх	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй	560.2	78.5	364.3	76.0	196.0	83.6
Эмэгтэй тэргүүлэгчтэй	153.6	21.5	115.2	24.0	38.3	16.4

Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 5.2 пунктээр, байршлын хувьд хотод 5.7, хөдөөд 2.4 пунктээр тус тус нэмэгджээ. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн амын төрөлт, өсөлтөд шууд нөлөөлдөг хүчин зүйл бол гэр бүлийн байдал юм. Гэрлэх нь үндэсний соёл, уламжлал, зан заншилтай нягт холбоотой. Монгол Улсын төр засаг гэрлэлт, гэр бүлийг дэмжиж, улмаар хүн амын өсөлтөд нөлөөлөх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн баялаг туршлагатай.

Хүн амын гэр бүл болох үндсэн чиг хандлага тооллого хоорондын жилүүдэд эрс өөрчлөгдөөгүй боловч нарийвчлан авч үзвэл ялгаа бий болсон нь ажиглагдана. Хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол огт гэр бүл болоогүй хүмүүсийн эзлэх хувь 1989 онд 25.3 хувь байснаа 2000 онд 33.1 хувь болон нэмэгдэж байсан бол өмнөх үеийнхээс 2010 онд 1.8 пунктээр буурчээ. Энэ нь 2007-2008 онд төр засгаас залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэр бүл болох нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

ХҮСНЭГТ 7.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 1989, 2000, 2010 ОН

Гэр бүлийн байдал	1989		2000		2010	
	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь
БҮГД	1052.0	100.0	1524.4	100.0	1906.0	100.0
Огт гэр бүл болоогүй	265.5	25.3	505.1	33.1	596.1	31.3
Гэр бүлтэй ¹	692.5	65.8	880.4	57.8	1146.2	60.1
Цуцалсан ²	17.1	1.6	41.5	2.7	59.0	3.1
Бэлбэсэн	76.9	7.3	97.4	6.4	104.6	5.5

¹ батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

² тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Дээрх хүснэгтээс харахад өөр нэг тэмдэглэх зүйл бол сүүлчийн 20 жилд гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын эзлэх хувь тогтвортой өсч, бэлбэсэн хүн амынх буурсан явдал юм. Өнгөрсөн 11 жилийн хугацаанд гэр бүлээ цуцалсан хүний тоо 42.2 хувиар нэмэгджээ. Харин бэлбэсэн эрэгтэйчүүдийн тоо буурч, эмэгтэйчүүдийнх 7.6 мянган хүнээр нэмэгджээ.

Ерөнхийдөө гэр бүлээ цуцалсан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс олон байгаа хандлага сүүлчийн 2 тооллогод хадгалагдаж байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол дахин гэр бүл болох магадлал бага байдагтай холбоотой. Хүн амын дунд гэр бүл цуцлалт нэмэгдэж байгааг онцгой анхаарч, түүний шалтгаан нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах шаардлага байна.

ХҮСНЭГТ 7.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь	мян.хүн	дүнд эзлэх хувь
БҮГД	1906.0	100.0	937.3	100.0	968.7	100.0
Огт гэр бүл болоогүй	596.1	31.3	322.5	34.4	273.6	28.2
Гэр бүлтэй ¹	1146.2	60.1	568.9	60.7	577.3	59.6
Цуцалсан ²	59.0	3.1	25.2	2.7	33.8	3.5
Бэлбэсэн	104.6	5.5	20.7	2.2	84.0	8.7

¹ батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

² тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардгийг харуулна. Тиймээс ч эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага байдаг. Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 2.2 пунктээр буурчээ.

Анхны гэрлэлтийн дундаж нас гэсэн үзүүлэлт эрэгтэй, эмэгтэйчүүд дунджаар анх хэдэн насандаа гэр бүл болж байгааг илэрхийлдэг.

ЗУРАГ 7.3. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, 1989, 2000, 2010 ОН



Нийгэм, эдийн засаг хөгжиж, залуу үеийнхний боловсролын төвшин дээшлэх тутам тэдний анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж байдаг зүй тогтолтой. Орчин үеийн хүний нийгмийн амьдралын баталгаа болсон чанартай боловсрол эзэмшихэд ихээхэн цаг хугацаа шаардагдаж, энэ хэрээр боловсролын өртөг нэмэгдсээр байна. Манай улсын хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас сүүлчийн 20 жилд эрэгтэй, эмэгтэйчүүдэд адилхан 3 насаар хойшилсон нь гайхах зүйл биш юм. Анхны гэрлэлтийн дундаж нас 1989, 2000 оны хооронд 2 насаар нэмэгдсэн бол сүүлчийн 10 жилд нэг насаар хойшилсон байна. Харин эрэгтэй, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насны ялгаа ойролцоогоор хоёр нас байгаа нь сүүлчийн 20 жилд өөрчлөгдсөнгүй.

Хүн амын гэр бүлийн байдлыг насны бүлэг болон хүйсээр авч үзэхэд илүү тодорхой үзэгдлүүд харагдана. Тухайлбал, огт гэрлээгүй эрэгтэй, нөхөрт гараагүй эмэгтэйчүүдийн хувь насны бүлгээр онцын ялгаагүй байхад (хүснэгт 7.8) гэр бүлтэй эмэгтэйчүүд 15-34 насанд илүү, түүнээс хойших насанд эрэгтэйчүүд нь олон байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү эрт нөхөрт гардгийг дахин харуулж байна. Эмэгтэйчүүд илүү эрт нөхөрт гардагтай холбоотойгоор тухайн насанд гэр бүл цуцлалт ч бас өндөр байгаа юм.

ХҮСНЭГТ 7.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН


Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй ¹	Цуцалсан ²	Бэлбэсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй ¹	Цуцалсан ²	Бэлбэсэн
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-24	29.7	72.8	7.5	2.7	0.1	28.1	75.3	11.1	4.1	0.2
25-34	25.2	18.8	29.8	21.6	2.0	24.2	15.5	31.4	23.8	2.5
35-44	20.2	5.6	28.1	36.8	7.7	19.9	5.2	27.4	35.8	9.6
45-54	14.5	2.0	20.7	28.4	19.7	15.0	2.6	19.1	27.6	22.5
55-64	5.9	0.5	8.4	7.7	21.0	6.8	0.8	7.2	6.8	23.9
65+	4.6	0.3	5.4	2.8	49.7	6.1	0.6	3.8	2.2	41.2
БҮГД	100.0	34.4	60.7	2.7	2.2	100.0	28.2	59.6	3.5	8.7
15-24	100.0	84.4	15.3	0.2	0.0	100.0	75.7	23.7	0.5	0.1
25-34	100.0	25.7	71.8	2.3	0.2	100.0	18.1	77.6	3.4	0.9
35-44	100.0	9.6	84.7	4.9	0.8	100.0	7.4	82.1	6.3	4.2
45-54	100.0	4.7	87.1	5.3	3.0	100.0	4.9	75.7	6.4	13.0
55-64	100.0	2.8	85.9	3.5	7.8	100.0	3.3	62.8	3.5	30.4
65+	100.0	2.5	71.9	1.6	24.0	100.0	2.9	37.2	1.2	58.6

¹ батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

² тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Нөгөө талаар 15-34 насанд нөхөрт гарсан эмэгтэйчүүд, 35-аас дээш насанд гэрлэсэн эрэгтэйчүүд олон байхад аль ч насанд бэлбэсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц их байна (хүснэгт 7.8). Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт насалдагтай холбоотойгоор тэд эрэгтэйчүүдээс эрт бэлбэсэрч байгааг илтгэнэ. Ялангуяа, 65, түүнээс дээш насанд бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 24 мянган хүнээр илүү байна. Мөн эмэгтэйчүүд хэдийгээр бэлбэсэрсэн ч дахин нөхөрт гарах магадлал эрэгтэйчүүдийнхээс бага байдгийг харуулж байна. Энэ зүй тогтол 2000 оны тооллогын үр дүнгээс ч тодорхой харагддаг юм.

ЗУРАГ 7.4. ГЭР БҮЛЭЭ ЦУЦАЛСАН ХҮН АМЫН ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Гэр бүлээ цуцалсан хүний тоог хүйсээр ангилж үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү, ялангуяа 35-44 насанд хамгийн их зөрүүтэй (3 мянган хүн ба өмнөх тооллогын үеийнхээс 30 орчим хувиар буурсан) байна. Үүнээс эмэгтэйчүүдийн гэр бүлээ цуцлалт эрэгтэйчүүдээс өндөр байна гэж дүгнэхдээ тэд дахин нөхөрт гарах магадлал эрэгтэйчүүдээс бага байдгийг харгалзан үзэх ёстой.

ДҮГНЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор нийт өрхийн тоо 2000 оныхоос 31.9 хувиар өссөний дотор хотын өрх 61.8 хувиар нэмэгдэж, харин хөдөөгийн өрх 4.3 хувиар буурсан байгаа нь өнгөрсөн жилүүдэд хөдөөнөөс төв суурин чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод хөдөөнөөс 4.4 дахин олон байна. Энэ нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ хангамж тааруу, хөдөөнөөс шилжин ирэгчид хамаатан сандантайгаа хамт амьдрах нь олширч байгаатай холбоотой гэж үзэж байна.

Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2000 онд 4.3 байсан бол 2010 онд 3.6 болж буурав. 2010 онд 2000 оныхоос 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 2000 оны тооллогоор 1-2 ам бүлтэй өрх хөдөөд хотоос 4.5 пунктээр илүү байсан бол 2010 онд харин хотод хөдөөнөөс 2.5 пунктээр илүү болсон байна. Энэ нь төв газарт их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирэгчид тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой.

Хүн амын гэр бүлийн байдалд гарсан хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 1989-2000 оны тооллого хооронд нэмэгдэж байсан бол сүүлчийн 11 жилд 1.8 пунктээр буурав. Энэ нь 2007-2008 онуудад төр, засгаас залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэрлэх нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Анхны гэрлэлтийн дундаж нас 2000-2010 оны хооронд нэг насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор хоёр насны зөрүүтэй байгаа нь сүүлчийн 20 жилд өөрчлөгдсөнгүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, бүтэц



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” Монгол Улсын хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Ази Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих хоёр дахь 10 жилийн (Бивакогийн мянганы хөтөлбөр, 2003-2012 он) ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаарх үйл ажиллагааны хөтөлбөр (НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос баталсан) зэрэг олон үйл ажиллагаа хэрэгжих явдлыг хянахад хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дэлгэрэнгүй үнэн бодит тоо баримт шаардлагатай юм. Монгол Улсын хүн амын 1963 оны тооллогоос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх улсын хэмжээний нэгдсэн тоо баримтгүй явж иржээ. Иймээс хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх 2 үзүүлэлт оруулж, бүх хүнээс асуусан.

“Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй” гэж үзсэн⁷.

Улсын хэмжээнд 2010 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 108.1 мянган хүн байгаа нь суурин хүн амын 4.1 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 59.7 мянга нь буюу 55.2 хувь нь эрэгтэй, 48.4 мянга буюу 44.7 хувь нь эмэгтэйчүүд юм.


ХҮСНЭГТ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	хүний тоо	дүнд эзлэх хувь	хүний тоо	дүнд эзлэх хувь	хүний тоо	дүнд эзлэх хувь
БҮГД	108 071	100.0	59 662	100.0	48 409	100.0
0-4	1 957	1.8	1 052	1.8	905	1.9
5-9	3 068	2.8	1 685	2.8	1 383	2.8
10-14	4 436	4.1	2 438	4.1	1 998	4.1
15-19	6 390	5.9	3 539	5.9	2 851	5.9
20-24	7 933	7.3	4 625	7.8	3 308	6.8
25-29	8 833	8.2	5 030	8.4	3 803	7.9
30-34	8 988	8.3	5 051	8.5	3 937	8.1
35-39	10 250	9.5	5 611	9.4	4 639	9.6
40-44	11 596	10.7	6 189	10.4	5 407	11.2
45-49	13 551	12.5	7 014	11.7	6 537	13.5
50-54	11 788	10.9	6 741	11.3	5 047	10.4
55-59	6 756	6.3	4 747	8.0	2 009	4.2
60-64	3 223	3.0	1 799	3.0	1 424	2.9
65-69	2 690	2.5	1 398	2.3	1 292	2.7
70+	6 612	6.2	2 743	4.6	3 869	8.0

⁷ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл II боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 280

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 10.0 хувь нь 10-19 нас буюу өсвөр үеийнхэн, 15.5 хувь нь 20-29 насныхан, 17.8 хувь нь 30-39 насныхан, 23.2 хувь нь 40-49 насныхан, 17.2 хувь нь 50-59 насныхан үлдсэн нь 60-аас дээш насныхан байгаа бөгөөд 35-54 насныхан 47.2 мянга буюу хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 43.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэлээд хувийг 40-54 насныхан эзэлж байгааг дээрх суваргаас харж (Зураг 8.1) болно. Тэдний дийлэнх нь үйлдвэрлэлийн болон ахуйн ослоос хамаарч хөгжлийн олдмол бэрхшээлтэй болсон байх талтай. Харин 70, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бараг 2 дахин олон байгаа нь эмэгтэйчүүд урт насалдагтай холбоотой юм.

ХҮСНЭГТ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,
ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд		Хүйс		Нийт хүн амд эзлэх хувь
	хүний тоо	дүнд эзлэх хувь	эрэгтэй	эмэгтэй	
БҮГД	108 071	100.0	59 662	48 409	4.1
Архангай	3 720	3.4	2 116	1 604	4.4
Баян-Өлгий	3 856	3.6	1 920	1 936	4.5
Баянхонгор	3 696	3.4	2 061	1 635	4.9
Булган	2 318	2.1	1 337	981	4.4
Говь-Алтай	2 528	2.3	1 391	1 137	4.7
Дорноговь	2 560	2.4	1 500	1 060	4.4
Дорнод	4 082	3.8	2 321	1 761	5.9
Дундговь	1 881	1.7	1 043	838	4.9
Завхан	2 939	2.7	1 569	1 370	4.5
Өвөрхангай	4 604	4.3	2 569	2 035	4.6
Өмнөговь	2 183	2.0	1 226	957	3.6
Сүхбаатар	3 057	2.8	1 775	1 282	6.0
Сэлэнгэ	4 711	4.4	2 639	2 072	4.9
Төв	3 825	3.5	2 205	1 620	4.6
Увс	3 358	3.1	1 876	1 482	4.6
Ховд	2 896	2.7	1 550	1 346	3.8
Хөвсгөл	6 553	6.1	3 414	3 139	5.7
Хэнтий	4 136	3.8	2 378	1 758	6.3
Дархан-Уул	3 738	3.5	2 164	1 574	4.1
Улаанбаатар	37 404	34.6	20 438	16 966	3.2
Орхон	3 516	3.3	1 879	1 637	4.0
Говьсүмбэр	510	0.5	291	219	3.9

Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Хөвсгөл аймгийн хүн амын дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь улсын дунджаас 1.6-2.2 пунктээр их, Өмнөговь, Ховд, Говьсүмбэр, Орхон аймгуудад 0.1-0.5 пунктээр бага байна. Улаанбаатар хотод 37.4 мянга буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 34.6 хувь нь оршин сууж байна. Гэвч Улаанбаатар хотод нийт хүн амын 43.6 хувь нь оршин сууж байгаатай харьцуулбал хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь аймгуудаас хамгийн бага байна.

ХҮСНЭГТ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН


Аймаг, нийслэл	Хот		Хөдөө	
	хүний тоо	хувь	хүний тоо	хувь
БҮГД	67 069	62.1	41 002	37.9
Архангай	914	24.6	2 806	75.4
Баян-Өлгий	1 222	31.7	2 634	68.3
Баянхонгор	1 584	42.9	2 112	57.1
Булган	591	25.5	1 727	74.5
Говь-Алтай	864	34.2	1 664	65.8
Дорноговь	1 309	51.1	1 251	48.9
Дорнод	2 309	56.6	1 773	43.4
Дундговь	640	34.0	1 241	66.0
Завхан	696	23.7	2 243	76.3
Өвөрхангай	1 851	40.2	2 753	59.8
Өмнөговь	782	35.8	1 401	64.2
Сүхбаатар	1 033	33.8	2 024	66.2
Сэлэнгэ	2 244	47.6	2 467	52.4
Төв	606	15.8	3 219	84.2
Увс	1 302	38.8	2 056	61.2
Ховд	1 095	37.8	1 801	62.2
Хөвсгөл	2 148	32.8	4 405	67.2
Хэнтий	1 991	48.1	2 145	51.9
Дархан-Уул	2 708	72.4	1 030	27.6
Улаанбаатар	37 404	100.0	-	-
Орхон	3 393	96.5	123	3.5
Говьсүмбэр	383	75.1	127	24.9

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 62.1 хувь буюу 67.1 мянга нь хотод, 37.9 хувь буюу 41.0 мянга нь хөдөөд амьдарч байна. Гэсэн хэдий ч хот, хөдөөд оршин сууж байгаа хүн амын тооноос хамаарч аймаг бүрт ялгаатай байгаа юм. Тухайлбал, Орхон, Дархан-Уул, Дорнод, Говьсүмбэр, Дорноговь аймгийн хот суурин газарт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо нь хөдөө оршин сууж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнээс олон, бусад аймгуудын хувьд хөдөөд илүү олноороо оршин сууж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн тоологдсоны 36.8 мянга буюу 34.0 хувь нь төрөлхийн, үлдсэн 71.3 мянга буюу 66.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Зураг 8.2-оос харахад хөгжлийн бэрхшээлтэй 10 эмэгтэй тутмын 6 нь олдмол байхад эрэгтэйчүүдийн хувьд энэ тоо 7 байна.

ЗУРАГ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 50.6 хувь, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 57.6 хувь эрэгтэйчүүд байгаа нь (хүснэгт 8.4) тэд эмэгтэйчүүдтэй харьцуулахад үйлдвэрлэлийн болон ахуйн осол, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, амьдралын буруу зуршил зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй болдогтой холбоотой.

ХҮСНЭГТ 8.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН


Төрөл	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн	Дүнд эзлэх хувь	Олдмол	Дүнд эзлэх хувь
БҮГД	108 071	100.0	36 765	100.0	71 306	100.0
Хүйс						
Эрэгтэй	59 662	55.2	18 611	50.6	41 051	57.6
Эмэгтэй	48 409	44.8	18 154	49.4	30 255	42.4
Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр						
Харааны	16 631	15.4	5 131	14.0	11 500	16.1
Ярианы	5 999	5.6	4 338	11.8	1 661	2.3
Сонсголын	12 633	11.7	4 875	13.3	7 758	10.9
Хөдөлгөөний	31 265	28.9	8 274	22.5	22 991	32.2
Сэтгэцийн	20 898	19.3	10 864	29.5	10 034	14.1
Бусад*	20 645	19.1	3 283	8.9	17 362	24.4

Тайлбар: * Хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг энд оруулав

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс 29.5 хувь байгаа нь хамгийн өндөр, харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс 32.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн их байна. Ялангуяа, төрөлхийн болоод сэтгэцийн бэрхшээлтэй хүн амын хувь их байгааг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл зэрэг шалтгаанаар олон талаас нь нарийвчилж судлах шаардлагатай. Дараагийн анхаарал татаж байгаа асуудал нь төрөлхийн болоод ярианы бэрхшээлтэй хүн амын хувь олдмол бэрхшээлтэй хүнийхээс 5.1 дахин их байгаа явдал юм.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг хэлбэрээр ангилж үзвэл ярианы болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн талаас илүү хувь нь төрөлхийн, бусад хэлбэрүүдийн хувьд олдмол бэрхшээл давамгайлж байна.

ЗУРАГ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ТӨРӨЛ, ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР, 2010 ОН



Тайлбар: * Хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг энд оруулав

ДҮГНЭЛТ

Улсын хэмжээнд 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь суурин хүн амын 4.1 хувь юм. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 59.7 мянга нь буюу 55.2 хувь эрэгтэй, 48.4 мянга буюу 44.7 мянга нь эмэгтэйчүүд байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд сэтгэцийн бэрхшээлтэй хүн 29.5 хувь байгаа нь хамгийн өндөр байна. Тиймээс үүнийг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл зэрэг шалтгаанаар олон талаас нь нарийвчилж судлах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс орны хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх, тэдний онцлог, хэрэгцээ шаардлагыг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлстэй хамааруулж судлах, улмаар ахуй нөхцөл, амьжиргааг нь дээшлүүлэхэд ашиглагдах мэдээллийн бодитой эх үүсвэр бий болгох шаардлагатай байна.

ЕСЛҮГЭЭР БҮЛЭГ

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ



ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ


Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын “Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх” зорилгын хүрээнд “Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, мэдээлэлжсэн нийгэм байгуулах” зорилтыг дэвшүүлсэн. Орчин үед мэдээллийн технологийн хэрэглээ эрчимтэй өсч, энэ төрлийн мэдээллийн хэрэгцээ нэмэгдсээр байна. Тиймээс төр болон хувийн хэвшлийнхний хэрэгцээг хангах, нөгөө талаас дэлхий нийтээрээ зөвшилцөж, олон улсын өмнө амлалт авсан МХЗ-дын холбогдох зорилтыг хэрэгжүүлж, биелэлтийг үнэлэх үүднээс интернэт, үүрэн утас хэрэглэгчийн тоог тодорхойлох үзүүлэлтийг тооллогын асуулгад тусгаж, мэдээллийг 6, түүнээс дээш насны бүх хүнээс цуглуулсан.

ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Үүрэн технологид суурилсан, нийтийн телефон сүлжээнд (үүрэн холбооны оператор) холбогдсон авсаархан, зөөврийн телефон хэрэглэгчийг үүрэн утас хэрэглэгч гэж үзсэн. Хамгийн гол нь үүрэн утаснаас гадна тусгай дугаарын хамт хэрэглэж байгаа тохиолдлыг хэрэглэгч гэсэн ойлголтод хамааруулсан юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор Монгол Улсын 6, түүнээс дээш насны суурин хүн амын 74 хувь буюу 1714.6 мянган иргэн гар утас хэрэглэж байна. Тэдний 48.2 хувь нь эрэгтэй, 51.8 хувь нь эмэгтэйчүүд ажээ.


ЗУРАГ 9.1. ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Хөдөлмөрийн нас болох 15-59 насны хүн амын 85.3 хувь нь гар утас хэрэглэж байгаагаас 20-24 насныхан хамгийн их хэрэглэгчид байна.

Аймаг, нийслэлээр гар утасны хэрэглээг авч үзвэл Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн хэрэглэгчийн хувь улсын дунджаас өндөр, Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу 37.5 хувьтай байна. Гар утасны хэрэглээ нь үүрэн утасны операторууд орон нутагт сүлжээгээ хир зэрэг өргөн нэвтрүүлсэн болон орон нутгийн байгаль, газарзүйн тогтоц, иргэдийн гар утас хэрэглэх шаардлага, боломж зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай юм.

ЗУРАГ 9.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН



Харин байршлын хувьд ангилж үзэхэд гар утас хэрэглэгчийн 76.7 хувь нь хот, суурин газар, үлдсэн хувь нь хөдөө амьдарч байна. Эндээс үүрэн холбооны техник, технологи төв суурин газар өргөн нэвтэрсэн нь харагдана. Бүсээр нь авч үзвэл төвийн бүс Улаанбаатарын дараа орох хамгийн их хэрэглэгчтэй (74.7 хувь) бол баруун бүс гар утас хамгийн бага хэрэглээтэй (53.4 хувь) байна.

ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Телефон утас болон түрээсийн шугам, өндөр хурдны хэрэглэгчийн тоон шугам буюу DSL, ADSL, байнгын гарцтай, өндөр хурдны кабель модем, шилэн кабель хэрэглэгчдийг интернэт хэрэглэгч гэж үзсэн. Интернэтийн **байнгын** хэрэглээг гэртээ болон гэрээсээ бусад газар 7 хоногийн ихэнх хугацаанд хэрэглэж байгаа тохиолдлоор, **тухайн үеийн** хэрэглээг интернэт үйлчилгээний цэг зэрэг газарт шаардлага гарсан үедээ хэрэглэж байвал “шаардлагатай үед” гэж тодорхойлсон.


Тооллогын дүнгээр 6, түүнээс дээш насны суурин хүн амын 30.6 хувь буюу 709.6 мянган хүн интернэт хэрэглэж байна. Тэдний 32.3 хувь нь гэртээ, 20.3 хувь нь албан газар зэрэг гэрээсээ өөр газар байнга хэрэглэж байхад 47.4 хувь нь шаардлагатай үедээ интернэт хэрэглэдэг ажээ. Энэ байдлаас үзэхэд интернэт хэрэглэдэг хүмүүсийн бараг тал хувь нь шаардлагатай үедээ интернэт кафе буюу найз нөхөд, бусад хүмүүсийн интернэтэд холбогдсон шугам ашиглаж байна.

ЗУРАГ 9.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН
ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, 2010 ОН




Гар утас хэрэглэдэг эрэгтэй, эмэгтэйчүүдийг бодвол интернэт хэрэглэгчийн хүйсийн ялгаа арай илүү юм. Өөрөөр хэлбэл, интернэт хэрэглэгчийн 45.8 хувь нь эрэгтэйчүүд бол эмэгтэйчүүд 8.3 пунктээр олон байна. Интернэт хэрэглэх нь хувь хүнээс тодорхой төвшний хэлний мэдлэг, компьютер, шаардлагатай мэдээллээ богино хугацаанд хайж олох чадвар шаарддаг. Тиймээс эмэгтэйчүүдийн боловсролын төвшин эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад илүү байгаатай холбоотойгоор эмэгтэйчүүд түлхүү хэрэглэдэг байж болох юм. Ялангуяа, энэхүү ялгааг хүний суралцах хамгийн идэвхтэй нас буюу 15-29 насанд тодорхой харж болно (зураг 9.6).

ЗУРАГ 9.4. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН.



Аймаг, нийслэлийн 6, түүнээс дээш насны хүн амд эзлэх интернэт хэрэглэгчийн хувийн жингээр Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймаг улсын дунджаас илүү буюу хамгийн өндөр, Хөвсгөл, Баян-Өлгий зэрэг аймгууд хамгийн бага байна.

ЗУРАГ 9.5. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН



Байршлаар нь ангилж үзэхэд нийт интернэт хэрэглэгчийн 93 хувь нь хотод, үлдсэн 7 орчим хувь нь хөдөөд амьдарч байна. Төвийн бүс нутагт хүн амынх нь 22.6 хувь интернэт хэрэглэж (Улаанбаатарын дараагийн хамгийн их хэрэглээтэй бүс нутаг) байхад баруун бүсэд энэ хувь хамгийн бага буюу 11.0 хувь байгаа юм. Энэ нь төмөр зам дагасан шилэн кабель, дэд бүтцийн хөгжлөөс хамаарч байгааг харуулна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын 6, түүнээс дээш насны суурин хүн амын 74 хувь буюу 1714.6 мянган иргэн гар утас хэрэглэж байна. Гар утас хэрэглэгч 4 хүн тутмын 3 нь хот суурин амьдардаг ажээ. Гар утас хэрэглэгчийн дотор 15-29 насныхан хамгийн олон байна.

Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амын 30.6 хувь буюу 709.6 мянган хүн интернэт хэрэглэж байгаагийн 52.6 хувь нь байнга, үлдсэн 47.4 хувь нь шаардлагатай үедээ хэрэглэдэг ажээ. Интернэт хэрэглэгчийн 54.2 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд тэдний боловсролын төвшин эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад илүү байгаагаас шалтгаалж болох юм.

Аймаг, нийслэлээр нь авч үзвэл гар утас, интернэт хэрэглэгчийн тоогоор Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгууд улсын хэмжээнд тэргүүлж байгаа бол Архангай, Хөвсгөл, Баян-Өлгий зэрэг аймгууд хамгийн бага хэрэглэгчтэй байна.

АРАВЛУГААР БҮЛЭГ


ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ



Хүн амын эдийн засгийн идэвхийн талаарх ойлголт, тодорхойлолтыг НҮБ-ын “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”⁸-ын 2.252 хэсгийг үндэслэн сүүлчийн хоёр тооллогод хэрэглэв. Ингэснээр хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг тодорхойлж, хоёр тооллогын үр дүнг зэрэгцүүлэх боломжтой болсон. Үндэсний Статистикийн Хорооны дарга, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2009 оны 01-681/94 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-аар тооцсон албан ёсны статистикийн болон бусад түүвэр судалгааны зарим үзүүлэлттэй тооллогын үр дүн тохирохгүй байж болно. Учир нь дээрх аргачлалд хүн амын эдийн засгийн идэвхийн зарим голлох үзүүлэлтийг хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүн амд харьцуулан тооцохоор заасан.

“Тооллогын товын үед ажил эрхэлж байгаа болон товын өмнөх 7 хоногт (2010 оны 11 дүгээр сарын 1-нээс хойш) ядаж нэг өдөр цалин орлоготой ажил эрхэлсэн хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн идэвхийг долоо хоногийн байдлаар тухайн үеийн идэвх гэсэн ойлголтоор тодорхойлсон. Өвчтэй, жирэмсний болон төрсний дараах чөлөөтэй, ээлжийн амралттай зэрэг шалтгаанаар тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй боловч үндсэн байгууллага, аж ахуйн нэгжтэйгээ хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзсэн (1 дүгээр бүлгийн “Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт” гэсэн хэсгийг үзнэ үү).

ЗУРАГ 10.1. АРВАНТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ АСУУЛТЫН ХАРИУЛТЫН БҮДҮҮВЧ, 2010 ОН




⁸ Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж. 2 дахь хэвлэл, НҮБ, Нью-Йорк, 2009 он, хуудас 184

ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийг тооллогод тухайн үеийн ажил эрхлэлтээр авсан учир ажиллах хүч (зарим тохиолдолд эдийн засгийн идэвхтэй хүн амтай тохирдог), эдийн засгийн идэвхгүй хүн ам гэж 2 ангилж тодорхойлов (зураг 10.1). Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамрууллаа. Энэ нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг, ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулах үндэслэл болдог. Тухайн үед ажиллаж байгаа гэдэг ойлголтод байнгын болон улирлын чанартай ажил эрхэлдэг, тоолох үед ажил эрхлэхгүй байгаа ч ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжээсээ хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй бүх хүн хамрагдсан гэдгийг дээр дурдсан билээ.

Харин эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүнийг оруулсан болно.

ЗУРАГ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХУВИАР, 2010 ОН



Арван тав, түүнээс дээш насны хүн амын 56.4 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2000 оноос 5.6 пунктээр буурчээ. Ерөнхийдөө хүн амын эдийн засгийн идэвх өнгөрсөн тооллогын үеийнхээс буурч, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өссөнийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

Ажиллах хүчний оролцооны төвшинг байршил, хүйсээр ангилгахад нэлээд ялгаатай байна. Энэ үзүүлэлт хөдөөд хотоос 13.8 пунктээр илүү байгаа нь манай улсын онцлог юм. Тооллогоор хөдөөгийн малчин өрхийн 15-аас дээш настай хүмүүсийг үндсэнд нь ажил эрхэлдэг гэж үздэгээс хамаарч, хөдөөгийн ажил хүчний оролцооны төвшин өндөр гарахад нөлөөлсөн. Гэхдээ хөдөөгийн хүн амын ажиллах хүчний оролцооны төвшин 2000 оны тооллогын үеийнхээс 7.5 пунктээр буурчээ.

Хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 72.4 хувь байгаа нь хотынхоос 9.4 пунктээр илүү юм.

ХҮСНЭГТ 10.1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТӨВШИН,
ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүчний оролцооны төвшин	56.4	63.0	50.1	52.3	58.5	46.5	66.1	72.4	59.3
Эдийн засгийн идэвхгүй хүн амын эзлэх хувь	43.6	37.0	49.9	47.7	41.5	53.5	33.9	27.6	40.7


Ажиллах хүчийг насны бүлгээр ангилахад мэдэгдэхүйц ялгаа ажиглагдана. Эрэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр юм. Үүний дотор 20-34 насанд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 13.7-17.8 пунктээр их байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагч эмэгтэйчүүд илүү байдагтай холбоотой. Хүн амын ажиллах хүчний оролцоо 25-44 насанд хамгийн өндөр байгаагийн дотор, эрэгтэйчүүдийн хувьд 80-иас дээш, эмэгтэйчүүдийнх 69-75 хувьтай байна. Ялангуяа, 40-49 насанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын зөрүү хамгийн бага байгаа нь энэ насанд эдийн засгийн идэвх хамгийн өндөр байгааг гэрчилнэ. Харин 55-аас дээш насанд эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх огцом буурч байгаа нь тэд 55 наснаас эхлэн өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой.

ХҮСНЭГТ 10.2. АРВАНТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН
ЗАСГИЙН ИДЭВХ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Эдийн засгийн идэвхтэй хүн ам						Эдийн засгийн идэвхгүй хүн ам					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*
БҮГД	1075.8	56.4	590.1	63.0	485.6	50.1	830.2	43.6	347.1	37.0	483.1	49.9
15-19	37.1	14.4	25.9	19.8	11.2	8.8	220.5	85.6	104.7	80.2	115.8	91.2
20-24	161.3	55.2	94.4	64.0	66.9	46.2	130.9	44.8	53.1	36.0	77.8	53.8
25-34	357.3	75.9	195.7	82.8	161.6	69.1	113.2	24.1	40.8	17.2	72.4	30.9
35-44	295.2	77.3	151.7	80.2	143.4	74.5	86.5	22.7	37.4	19.8	49.1	25.5
45-54	186.2	66.3	96.1	70.9	90.1	62.0	94.7	33.7	39.4	29.1	55.3	38.0
55-59	26.1	36.3	17.9	53.7	8.2	21.3	45.8	63.7	15.5	46.3	30.4	78.7
60+	12.6	8.4	8.5	13.1	4.1	4.8	138.5	91.6	56.3	86.9	82.2	95.2

*тухайн насны бүлгийн хүн амд эзлэх хувь

ЗУРАГ 10.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТӨВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Эдийн засгийн идэвхгүй хүн ам өмнөх тооллогын үеийнхээс өссөний шалтгаанд тайлбар болж чадах нэг зүйл бол 15-24 насны хүн амын ажиллах хүчний оролцоо огцом буурсан явдал юм. Тухайлбал, 15-19 насны эрэгтэйчүүдийн оролцооны төвшин 58.7 хувь, эмэгтэйчүүдийнх 74.3 хувь, 20-24 насны эрэгтэйчүүдийнх 14.1 хувь, эмэгтэйчүүдийнх 24 хувиар тус тус буурчээ. Энэ нь тухайн насны залуучуудын сургуульд хамрагдалт нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм.


АЖИЛЛАХ ХҮЧ

Тооллогын товын өмнөх 7 хоногт ядаж нэг цагаас илүү хугацаагаар цалин орлоготой ажил эрхэлсэн, ажил хайж байгаа хүнийг ажиллах хүчинд хамааруулсныг дээр тэмдэглэсэн. Бид ажил эрхлэлтийг богино хугацаагаар тодорхойлж байгаа болохоор НҮБ-ын зөвлөмжийг үндэслэн **ажиллах хүч** гэдэг ойлголтыг хэрэглэж байна.

Тоолох ажиллагаа 2010 оны 11 дүгээр сарын дундуур явагдсан. Монгол орны байгаль, цаг уурын онцлогоос хамаарч энэ үед хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлд өөрчлөлт гардаг. Тухайлбал, газар тариалан, уул уурхайн салбарт ажилладаг хүмүүсийн үндсэн ажлынх нь ид үе дууссан байдаг хэдий ч ажилчид нь аж ахуйн нэгж, байгууллагаасаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй бол хөдөлмөр эрхэлсэн гэж үзэв. Тиймээс тухайн тоолуулагч тооллогын товын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байвал түүний ажил эрхлэлтийг үнэн зөв тодорхойлохын тулд ер нь ажилтай эсэх, ажилдаа эргэж орох боломжтой эсэх, байгууллагаасаа хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан эсэхийг тодруулж асуусан.

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан гэсэн асуултыг ашигласан. Энэ нь эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог гаргахад түлхүүр үзүүлэлт болж өгсөн. “Ажил хайж байгаа” гэдэгт “тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхтэй хайж байгаа” хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлов.

ЗУРАГ 10.4. ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХУВИАР, 2010 ОН



Арван тав, түүнээс дээш насны хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувь 8.6 болж, өнгөрсөн 11 жилийн хугацаанд 2.2 пунктээр буурчээ. Хэдийгээр ажилгүй иргэдийн хувь буурсан ч ажилгүйдлийн төвшин хэрхэн өөрчлөгдсөнийг дараагийн дэд бүлэгт оруулав.

АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ

Тооллогоор “Ажил эрхэлдэг” хүн амд хэнийг хамруулсан талаар бүлгийн эхэнд тодорхой дурдсан билээ. Ажил эрхэлдэг бүх хүнээс тэдний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөр эрхлэлтийн байдал гэсэн гурван асуултыг асуусан.

ХҮСНЭГТ 10.3. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН

Хүйс	2000 он		2010 он		2010 / 2000 %
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	
БҮГД	779.1	51.1	911.7	47.8	117.0
Эрэгтэй	420.4	56.1	495.1	52.8	117.8
Эмэгтэй	358.7	46.3	416.6	43.0	116.1

* 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Ажил эрхэлдэг хүн амын тоо 2000 оноос хойш 17 хувиар өсчээ. Хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд илүү өсөлттэй байна. Харин байршлаар нь ангилахад нэлээд ялгаатай байгааг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 10.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*
БҮГД	911.7	47.8	574.5	43.7	337.1	57.5
Эрэгтэй	495.1	52.8	302.9	48.2	192.2	62.7
Эмэгтэй	416.6	43.0	271.6	39.5	144.9	51.8

* 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Улсын хэмжээнд арван тав, түүнээс дээш насны хүн амын 47.8 хувь ажил эрхэлж байхад уг үзүүлэлт хөдөөд 57.5 хувь байгаа нь хотынхоос 13.8 пунктээр илүү байна. Хөдөөгийн хүн ам улсын суурин хүн амын 32.1 хувийг эзэлж, хувийн жин нь жилээс жилд буурч байгаа боловч тэд үндсэндээ мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг нь хөдөөд хөдөлмөр эрхэлдэг хүний хувийн жин хөдөөд хотоос өндөр байх нөхцөлийг бүрдүүлнэ. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт хотынхоос 12.3 пунктээр их бол эрэгтэйчүүдийнх 14.6 пунктээр илүү байна. Хэдийгээр эл зөрүү 2000 оны тооллогын үеийнхээс буурсан ч хөдөлмөр эрхлэх зорилгоор хот суурин руу нүүж, амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн олон мянган хүн ажлын байраар тэр бүр хангагдаж чадахгүй байдал байсаар байна.

ХҮСНЭГТ 10.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	2000			2010			2010 / 2000 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	779.3	420.6	358.7	911.7	495.1	416.6	117.0
15-19	80.9	48.4	32.5	25.6	18.7	6.9	31.7
20-24	126.1	69.1	57.0	122.9	72.7	50.2	97.5
25-34	252.3	131.0	121.3	300.6	163.8	136.7	119.1
35-44	199.7	99.9	99.8	255.9	129.1	126.8	128.1
45-54	82.8	46.5	36.3	169.1	85.4	83.7	204.3
55-59	22.3	16.0	6.3	25.0	16.9	8.1	112.0
60+	15.2	9.7	5.5	12.6	8.5	4.1	82.6

Дээрх хүснэгтээс сонирхолтой дүр төрх ажиглагдаж байна. 15-24 насны ажил эрхэлдэг хүний тоо 2000 оныхоос буурч, харин 35-54 насны хүний тоо өссөн нь аж ахуйн нэгж, байгууллагууд ажлын чадвар дадлага туршлагатай, ажлын бүтээмж өндөртэй ажилтныг ажиллуулах сонирхол нэмэгдэж байгаагийн зэрэгцээгээр өнгөрсөн жилүүдэд ажиллаж байсан 34-44 насныхан нас дэвшсэнтэй холбоотой. Нөгөө талаар залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс нэмэгдсэн нь энэхүү бууралтад нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 10.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ,
АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Мян.хүн			Хувь-А			Хувь-Б		
БҮГД	911.7	495.1	416.6	100.0	100.0	100.0	100.0	54.3	45.7
Менежер	72.2	41.1	31.1	7.9	8.3	7.5	100.0	56.9	43.1
Мэргэжилтэн	153.9	53.2	100.7	16.9	10.8	24.2	100.0	34.6	65.4
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	40.5	15.4	25.0	4.4	3.1	6.0	100.0	38.1	61.9
Контор, үйлчилгээний ажилтан	23.7	6.7	17.1	2.6	1.3	4.1	100.0	28.1	71.9
Худалдаа үйлчилгээний ажилтан	134.2	53.3	80.9	14.7	10.8	19.4	100.0	39.7	60.3
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	236.3	135.6	100.7	25.9	27.4	24.2	100.0	57.4	42.6
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	85.0	63.2	21.8	9.3	12.8	5.2	100.0	74.3	25.7
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	79.7	74.0	5.7	8.7	14.9	1.4	100.0	92.8	7.2
Энгийн ажил мэргэжил	68.7	36.7	32.0	7.5	7.4	7.7	100.0	53.4	46.6
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	17.4	16.0	1.4	1.9	3.2	0.3	100.0	91.8	8.2

Хүн амын эрхэлдэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа ангилал тус бүрт өөр өөр байгаа нь ажиглагдана. Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй байгаа нь менежер, хөдөө аж ахуй, ой, загас агнуур, энгийн ажил мэргэжил ажээ. Харин суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, зэвсэгт хүчний алба болон биеийн хүч шаардсан ажил мэргэжлийн 90 дээш хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Гэтэл мэргэжилтэн, контор, үйлчилгээний ажилтай 10 хүн тутмын 7 нь эмэгтэйчүүд байна.

Ажил эхэлдэг хүн амын 96.5 хувь нь боловсролтой, үүнээс эрэгтэйчүүдийн 95.6 хувь, эмэгтэйчүүдийн 97.6 хувь нь тус тус ямар нэг төвшний боловсрол эзэмшжээ. Ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн 23.5 хувь нь дээд боловсролтой байхад ижил төвшний боловсролтой эмэгтэйчүүдийн хувь 12.5 пунктээр илүү байна. Хэдийгээр дээд боловсролтой эмэгтэйчүүд ажил эрхэлдэг хүн амд давамгайлж байгаа боловч менежер буюу бүх шатны төрийн, төрийн бус болон аж ахуйн нэгж, байгууллагын удирдах, бодлого тодорхойлох төвшинд тэдний төлөөлөл арай бага байгааг дээрх хүснэгтээс харж болно.

Тооллогоор хөдөлмөр эрхэлдэг буюу товын өмнөх 7 хоногт ажил эрхэлсэн гэж хариулт өгсөн хүмүүсээс ажилладаг байгууллага эсвэл эрхэлдэг ажлынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тодруулж асуусан. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллыг хуулийн этгээд, өөрөөр хэлбэл, өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага болон хүн амд үйлчилдэг ашгийн бус төр, олон нийт, шашны зэрэг байгууллагууд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлээр нь ялгаж, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, ажиллах хүчний судалгаа зэрэг олон зорилгоор ашигладаг.

ХҮСНЭГТ 10.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХУВИАР 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Дүн	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	мян.хүн			Хувь А			Хувь Б		
БҮГД	911.7	495.1	416.6	100.0	100.0	100.0	100.0	54.3	45.7
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	241.0	139.4	101.6	26.4	28.2	24.4	100.0	57.8	42.2
Уул уурхай, олборлолт	48.9	39.2	9.7	5.4	7.9	2.3	100.0	80.2	19.8
Боловсруулах үйлдвэрлэл	63.4	33.6	29.8	7.0	6.8	7.2	100.0	53.0	47.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	14.3	10.8	3.5	1.6	2.2	0.8	100.0	75.5	24.5
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	6.5	3.8	2.7	0.7	0.8	0.6	100.0	58.8	41.2
Барилга	58.5	46.7	11.8	6.4	9.4	2.8	100.0	79.8	20.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	117.0	51.1	66.0	12.8	10.3	15.8	100.0	43.6	56.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	52.7	42.1	10.6	5.8	8.5	2.5	100.0	79.8	20.2
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	28.4	6.3	22.1	3.1	1.3	5.3	100.0	22.2	77.8
Мэдээлэл, холбоо	13.6	7.2	6.4	1.5	1.5	1.5	100.0	52.8	47.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15.8	6.1	9.8	1.7	1.2	2.3	100.0	38.4	61.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7.7	3.4	4.3	0.8	0.7	1.0	100.0	44.1	55.9
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10.5	5.1	5.4	1.2	1.0	1.3	100.0	49.0	51.0
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12.3	8.8	3.5	1.3	1.8	0.8	100.0	71.5	28.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	74.6	49.3	25.3	8.2	10.0	6.1	100.0	66.1	33.9
Боловсрол	79.6	21.3	58.2	8.7	4.3	14.0	100.0	26.8	73.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	35.7	7.0	28.7	3.9	1.4	6.9	100.0	19.5	80.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	8.5	4.6	3.8	0.9	0.9	0.9	100.0	54.7	45.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	19.3	8.1	11.2	2.1	1.6	2.7	100.0	42.0	58.0
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.7	0.2	0.5	0.1	0.0	0.1	100.0	26.6	73.4
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2.7	1.1	1.7	0.3	0.2	0.4	100.0	39.2	60.8

Хүн амын 26.4 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилтын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр юм. Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, цахилгаан хий, уур агааржуулалтын хангамж, барилга, тээвэр агуулахын аж ахуй, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажиллагчдын 70, түүнээс илүү хувь нь эрэгтэйчүүд байхад байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын 70, түүнээс дээш хувь нь эмэгтэйчүүд байна.

Хот, хөдөөгийн хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийг авч үзэхэд илүү тодорхой мэдээлэл өгнө. Хотын ажил эрхэлдэг хүн амын дотор бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, төрийн удирдлага, батлан хамгаалах, боловсролын салбарт ажиллагчдын хувийн жин өндөр байна. Гэхдээ салбар салбарын ажиллагчдын хувь хөдөөгийнх шиг нэг салбарт хэт төвлөрсөн бус харьцангуй жигд тархжээ.

Хөдөө аж ахуй, ан агнуур, загас барилт, ойн аж ахуйн салбарт ажиллагчид хөдөөгийн ажиллагчдын 2/3-ыг бүрдүүлж, дараа нь төрийн удирдлага, батлан хамгаалах, боловсролын салбар орж байгаагаас харахад хөдөөд боловсруулах зэрэг аж үйлдвэрийн салбар муу хөгжсөнийг гэрчилнэ. Харин уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын хувь хот, хөдөөд ойролцоо гарсан нь тооллого явагдах үед уул уурхайн олборлохтой холбоотой үндсэн үйл ажиллагаа зогсож, ажиллагчид нь хот суурин газар тоологдсоноос хамаарчээ.

ХҮСНЭГТ 10.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Хот		Хөдөө	
	Ажил эрхэлдэг хүн амын тоо	Дүнд эзлэх хувь	Ажил эрхэлдэг хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	581 329	100.0	330 335	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	23 492	4.0	217 525	65.8
Уул уурхай, олборлолт	32 916	5.7	15 981	4.8
Боловсруулах үйлдвэрлэл	57 704	9.9	5 687	1.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	12 220	2.1	2 037	0.6
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5 875	1.0	576	0.2
Барилга	51 217	8.8	7 300	2.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	106 898	18.4	10 142	3.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	45 930	7.9	6 751	2.0
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	25 831	4.4	2 615	0.8
Мэдээлэл, холбоо	12 976	2.2	670	0.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	13 317	2.3	2 524	0.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7 644	1.3	45	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	8 664	1.5	1 834	0.6
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	10 587	1.8	1 689	0.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	54 132	9.3	20 449	6.2
Боловсрол	56 263	9.7	23 289	7.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	27 301	4.7	8 409	2.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	7 377	1.3	1 086	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17 876	3.1	1 409	0.4
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийнүйл ажиллагаа	634	0.1	49	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 475	0.4	268	0.1

Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хэрэглэгддэг дараагийн чухал үзүүлэлт бол хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) юм. Тоолуулж байгаа хүний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагадаа гүйцэтгэж байгаа үүрэг, байгуулсан гэрээ хэлцэл, тухайн хүний байгууллага, хувь хүнтэй харилцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж өгдөг учраас энэ үзүүлэлт ихээхэн чухал ач холбогдолтой.

ХҮСНЭГТ 10.9. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ,
ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН

	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажиллагч	41.3	39.3	43.6	56.2	53.6	59.4
Ажил олгогч	1.3	1.7	0.8	2.5	3.1	1.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	31.2	43.9	16.4	27.7	37.7	15.9
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	0.5	0.5	0.4	0.2	0.2	0.2
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлстэй оролцогч	25.3	14.0	38.6	12.9	4.9	22.5
Бусад	0.4	0.6	0.2	0.4	0.5	0.3

Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлчийн 11 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2000 онд өрхийн бизнест цалин хөлстэй ажилладаг 197.5 мянган хүн байсан бол 2010 онд 117.8 мянга болтлоо цөөрсөн байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин 3.5 пунктээр буурч, харин цалин хөлстэй ажиллагч, ажил олгогчийн хувийн жин өссөн нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжсөнийг харуулна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин буурах нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгаалалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх бололцоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай юм.

АЖИЛГҮЙЧҮҮД

Улсын хэмжээнд ажилгүйчүүдийн тоо 2010 онд 164.1 мянган хүн байгаа нь 2000 оноос 0.8 мянган хүнээр буюу дөнгөж 1 хувиар буурчээ. Гэвч энэ хугацаанд Монгол Улсын ажиллах хүч 132.5 мянган хүнээр хүрээгээ тэлсэн байна. Харин ажилгүйдлийн төвшин 2010 онд 2000 оныхоос 2.2 пунктээр буурсны дотор хотод 7.8 пунктээр буурсан боловч хөдөөд 2.8 пунктээр нэмэгдсэн байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс их байгаатай холбоотойгоор ажилгүйдлийн төвшин ч мөн адил эрэгтэйчүүдийнх өндөр гарчээ. Энэ нь эрэгтэйчүүдийн боловсролын төвшин эмэгтэйчүүдийнхээс бага байгаатай холбоотой.


ХҮСНЭГТ 10.10. АЖИЛГҮЙДЛИЙН ТӨВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.хүн	Ажилгүйдлийн төвшин	мян.хүн	Ажилгүйдлийн төвшин	мян.хүн	Ажилгүйдлийн төвшин
БҮГД	164.1	15.3	114.6	16.5	49.5	13.0
Эрэгтэй	95.0	16.1	65.9	17.7	29.1	13.4
Эмэгтэй	69.1	14.2	48.6	15.0	20.4	12.6

Ерөнхийдөө ажилгүйдлийн төвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас сүүлчийн жилүүдэд мал аж ахуйн үйлдвэрлэлд тохиолдсон байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан олон тооны айл өрхүүд малгүй болж, хот суурин бараадан ирсэн, нөгөө талаас тэд хотод ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.

Нийт ажилгүй хүмүүсийн дотор 20-34 насны 95.1 мянган (ажилгүй иргэдийн 57.9 хувь) залуучууд байгаа нь бусад наснаас хамгийн өндөр юм. Харин 35-44 насны 39.2 мянган хүн ажилгүй байгаа нь нийт ажилгүйчүүдийн 23.9 хувь болж байна. Үүнээс үзэхэд ажилгүйчүүдийн дийлэнх буюу 81.8 хувь нь 20-44 насныхан ажээ.

ЗУРАГ 10.5. АЖИЛГҮЙДЛИЙН ТӨВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Ерөнхийдөө ажилгүйдлийн төвшин 15-24 насанд өндөр байгаа нь мэргэжилгүй залуучуудад ажлын байр ховор олддогтой, нөгөө талаар, тэд энэ насанд ажиллахаас суралцахыг илүүд үзэж байгаатай холбоотой. Энэ нь эмэгтэйчүүдийн хувьд бүр илүү ажиглагдана. Харин 25, түүнээс дээш насныханд эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн амаас ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг асуусан. Тухайлбал, сургуульд сурдаг хүн амд 15-аас дээш настай бүх шатны сургуульд суралцагчдыг, хөдөлмөрлөх чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны боловч хөдөлмөрлөх чадвараа байнга буюу удаан хугацаагаар бүтэн болон хэсэгчлэн алдсан бөгөөд сэргээгдэх боломжгүй хүнийг, гэрийн ажилтайд хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн бусад хүний ажлын онцлог зэргээс хамааран ажиллаж чадахгүй байгаа хүнийг тус тус хамааруулав. Тохирох ажил олдохгүй байгаа гэдэг ойлголтод “Ажил хийхийг хүсч байгаа, ажил хийхэд бэлэн, урьд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын товын өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй эсвэл тохирох ажил хаанаас хайхаа мэдэхгүй байгаа хүмүүсийг” оруулав.

ХҮСНЭГТ 10.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил эрхлээгүй шалтгаан	2000			2010			2010 2000 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	580.3	235.6	344.7	830.3	347.2	483.1	143.1
Сургуульд сурдаг	171.0	71.4	99.6	300.5	136.7	163.8	175.7
Тэтгэвэрт	163.7	53.9	109.8	191.9	65.7	126.2	117.2
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	36.9	20.5	16.4	55.9	31.3	24.6	151.5
Гэрийн ажилтай	76.3	10.9	65.4	108.4	12.1	96.3	142.1
Ажиллах сонирхолгүй	-	-	-	3.3	2.3	1.0	-
Тохирох ажил олдохгүй байгаа	90.4	53.1	37.3	121.6	71.9	49.7	134.5
Бусад	42.0	25.8	16.2	48.7	27.1	21.6	115.9

Эдийн засгийн идэвхгүй 10 хүн тутмын 4 нь эрэгтэйчүүд, 6 нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн ам нийтдээ 830.2 мянга байгаа нь 2000 оныхоос 43.1 хувиар, үүний дотор сургуульд суралцагчид 75.7 хувь, хөдөлмөрлөх чадваргүй, гэрийн ажилтай болон тохирох ажил олдохгүй байгаа хүний тоо 51.5, 42.1, 34.5 хувиар тус тус өсчээ. Сургуульд суралцагчдын хувь өссөн нь зүй ёсны асуудал бол хөдөлмөр эрхлэх чадваргүй, тохирох ажил олдохгүй байгаа гэсэн шалтгаан нэмэгдсэнийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Ялангуяа, хөдөлмөрийн насны хүн амд хөдөлмөр эрхлэх чадваргүй хүний тоо хамгийн их өссөн нь үйлдвэрлэлийн болон ахуйн осол гэмтэл, энгийн болон мэргэжлээс шалтгаалах өвчлөл нэмэгдсэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хувь хүн сахиж ажиллахгүй байгаа зэрэг олон шалтгаантай байж болох юм. Тохирох ажил олдохгүй, гэрийн ажилтай гэсэн шалтгаануудын хувьд хүн амын эзэмшсэн мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй хэр нийцэж байгаагаас хамаардаг.

Гэрийн ажилтайн улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа эмэгтэйчүүдийн тоо 2000 оноос 47.2 хувиар өссөн байхад эрэгтэйчүүдийнх 11.2 хувиар нэмэгдсэн нь эмэгтэйчүүд хөлсгүй буюу эдийн засгийн бус үйлдвэрлэл, үйлчилгээний дийлэнх хэсгийг эрхэлж байгааг гэрчилнэ.

ХҮСНЭГТ 10.12. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2010 ОН

Насны бүлэг	Эдийн засгийн идэвхгүй хүн ам							Бусад
	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонирхолгүй	Тохирох ажил олдохгүй байгаа	
БҮГД	830.2	300.5	191.9	55.9	108.4	3.3	121.5	48.7
15-19	220.5	204.9	-	2.9	3.7	0.3	5.5	3.4
20-24	130.9	82.7	-	4.2	18.8	0.4	16.9	8.0
25-34	113.2	11.4	-	10.6	41.8	0.9	33.6	15.0
35-44	86.5	1.4	0.1	14.2	24.3	0.9	34.1	11.5
45-54	94.7	0.1	21.1	18.4	17.8	0.7	27.7	8.8
55-59	45.8	-	34.4	4.3	1.7	0.1	3.6	1.6
60+	138.5	-	136.4	1.4	0.3	0.0	0.2	0.4

Ажил хийх сонирхолгүй 3.3 мянган хүн байгаагийн 1.8 мянга буюу 54.0 хувь нь ажил эрхлэх ид нас болох 25-44 насны хүмүүс байгаа нь цаашид анхааран судлах асуудлуудын нэг юм.

Тохирох ажил олдохгүй байгаа хүний 96.2 хувь боловсролтой, үүний дотор 13.1 хувь нь дээд, 6.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн байна. Энэ нь боловсролын хэрэгцээ, нийлүүлэлт тохирохгүй байгааг харуулна. Гэрийн ажилтай хүмүүсийн 96.6 хувь боловсролтой байгаагийн дотор 21.2 хувь нь дээд боловсролтой, 5.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажээ. Харин ажиллах сонирхолгүй бүх хүний 91.5 хувь боловсролтой, үүний дотор 13.5 хувь нь дээд, 5.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүс байна.

Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 43.6 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам юм. Энэ тоон дээр ажилгүйчүүдийг нэмбэл дээрх насны нийт хүн амын 52.2 хувь буюу 2 хүн тутмын нэг нь ажил эрхлэхгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. Үүнээс гадна тохирох ажил олдохгүй байгаа, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүйн улмаас хөдөлмөрийн зах зээлд оролцохгүй байгаа хүмүүсийн 13.6-21.9 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байгаагийн шалтгаан нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 56.4 хувь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2000 оноос 5.5 пунктээр буурсан бол ажиллах хүчинд хамаарагдахгүй хүн ам (43.6 хувь) 5.5 пунктээр өсчээ. Ерөнхийд нь үзвэл хүн амын эдийн засгийн идэвх өнгөрсөн тооллогын үеийнхээс буурчээ.

Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны төвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 72.4 хувь байгаа нь хотынхоос 9.4 пунктээр илүү юм. Энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой.

Нийт хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 3.3 пунктээр буурч, харин эдийн засгийн идэвхгүй хүн амын хувийн жин 5.6 пунктээр нэмэгдэж, ажил хайж байгаа иргэд 8.6 хувийг эзэлж байна. Ялангуяа, 15-24 насны залуучуудын зарим хэсэг эзэмшсэн боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа тул ажиллах хүчинд оролцож чадахгүй байна. Мөн 55-аас дээш наснаас эхлэн нас ахих тутам хүмүүсийн хөдөлмөрийн чадвар буурч, 60, түүнээс дээш насны хүн амын дөнгөж 8.5 хувь ажиллах хүчинд хамрагдаж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 2.6 пунктээр буурчээ.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 47.8 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 57.7 хувь байгаа нь хөдөөгийн хүн амын дийлэнх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэгтэй холбоотой. Ялангуяа, хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт хотынхоос 12.3 пунктээр өндөр байгаа нь хөдөөгийн эмэгтэйчүүдийн дийлэнх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаагаар тайлбарлагдана.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 2000 онд өрхийн бизнест цалин хөлсгүй ажилладаг хүмүүсийн тоо харьцангуй олон буюу 197.5 мянган хүн байсан бол 2010 онд 117.8 мянга болтлоо цөөрчээ. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин 3.5 пунктээр буурч, цалин хөлстэй ажиллагч, ажил олгогчийн хувийн жин өссөн нь үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээ тэлж, ажлын байр нэмэгдсэнийг гэрчилнэ.

Улсын хэмжээнд ажилгүйдлийн төвшин 2010 онд 15.3 хувь болж, 2000 оноос 2.2 пунктээр буурчээ. Ерөнхийдөө ажилгүйдлийн төвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Хотод ажилгүйдлийн төвшин өндөр байгаа нь нэг талаас сүүлчийн жилүүдэд тохиолдож байгаа байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан олон тооны өрхүүд малгүй болж, хот суурин газар шилжин ирж байгаа, нөгөө талдаа тэд хотод ирээд ажлын байр олох боломж нөхцөл муу байдагтай холбоотой.

Ажилгүй иргэдийн дотор 20-34 насны 95.1 мянган залуучууд байгаа нь хамгийн их буюу нийт ажилгүйчүүдийн 57.9 хувийг эзэлж байна. Мөн 35-44 насны 39.2 мянган хүн ажилгүй байгаа юм. Үүнээс үзэхэд ажилгүйчүүдийн дийлэнх буюу 63.1 хувь нь ид хөдөлмөрийн буюу 20-44 насныхан байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын дотор 41.8 хувь нь эрэгтэйчүүд, 58.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын дотроос хөдөлмөрлөх чадваргүй, гэрийн ажилтай болон тохирох ажил олдохгүй байгаа хүний тоо 51.5, 42.1, 34.5 хувиар тус тус өссөнийг цаашид судлах шаардлагатай.

АРВАННЭГЛДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН
ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ



ГАДААДАД 6, ТҮҮНЭЭС ДЭЭШ САРЫН ХУГАЦААГААР ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүн амын гадаад улс орнуудад шилжин хөдөлгөөн нэмэгдсэн. “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй”⁹ гэсэн Үндсэн хуулийн заалт нь иргэдийг гадаад зорчих, сурах, ажиллах, эх орондоо дуртай цагтаа эргэж ирэх эрх зүйн үндэс болдог. Сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг шалтгааны улмаас манай орны иргэдийн гадаадын олон улс оронд зорчих хөдөлгөөн улам нэмэгдэж байна. “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” Монгол Улсын хуульд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдээ тоолохоор хуульчилсан юм. Иймээс хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийнхээ талаар бодитой тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг боловсруулж, хэрэгжүүлэв. Энэ нь төр засгаас гадаадад ажиллаж, сурч байгаа иргэдийнхээ талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах үндсэн мэдээлэл болох учиртай.

Тооллогоор гадаадад 6, түүнээс сарын хугацаагаар амьдарч, ажиллаж, суралцаж байгаа Монгол Улсын иргэдийг гадаадад (цаашид гадаадад оршин суугаа гэнэ) оршин суугаа гэж үзсэн.

Гадаад улс оронд Монгол Улсын хэдэн иргэн ажиллаж, амьдарч, суралцаж байгаа талаарх бүртгэл, мэдээллийн тогтолцоо бүрдээгүйн улмаас энэ чиглэлийн албан ёсны тоо мэдээлэл өнөө хэр нь байхгүй байв.

Гадаад харилцааны яам гадаад орнуудад суугаа ЭСЯ, ДТГ-даар дамжуулан тухайн оронд монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, холбоо, төрийн бус байгууллагуудын шугамаар гадаадад ажиллаж, амьдардаг иргэдийн тоог нэгтгэн гаргуулж байна. Тус яамнаас нэгтгэн ирүүлсэн мэдээлэл бусад эх үүсвэрүүдтэй харьцуулахад гадаадад амьдарч байгаа монгол иргэдийн талаарх илүү бодитой тоо байж болох үндэслэлтэй юм (Хүснэгт 11.1). Ерөнхийдөө тоолох үйл ажиллагааны хамралт, мэдээлэл цуглуулахад шаардагдах төсөв зэрэг төлөвлөлтийг энэхүү мэдээлэлд үндэслэн тооцож байсан.

⁹ Монгол Улсын үндсэн хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл. I боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 5.

ХҮСНЭГТ 11.1. ГАДААДАД АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, УЛСААР, 2010 ОН*

Улсын нэр	Тоо (мян.хүн)
НИЙТ	134.8
Америкийн Нэгдсэн Улс	27.3
Бүгд Найрамдах Казакстан Улс	40.2
Бүгд Найрамдах Солонгос Улс	30.8
Бүгд Найрамдах Турк Улс	1.8
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	5.0
Бүгд Найрамдах Чех Улс	6.1
Бүгд Найрамдах Франц Улс	1.5
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	2.0
Оросын Холбооны Улс	1.8
Холбооны Бүгд Найрамдах Герман улс	4.4
Швейцарийн Холбооны Улс	1.5
Япон Улс	5.0
Бусад Улс	7.4

* Эх үүсвэр: ГХЯ-ны мэдээгээр

Мэдээлэл цуглуулах ажлыг нэг талаас монголд байгаа ар гэрийнхнээс нь асуух, нөгөө талаас гадаадад оршин суугаа иргэд өөрсдөө интернэтээр тоолуулахаар зохион байгуулсан бөгөөд АНУ-аас бусад улсын хувьд тооллогын хамралт сайн явагдсан.

Гадаадад оршин суугаа иргэдийн тоог энэ чиглэлийн холбогдох байгууллагуудын мэдээллээс нягталж, тооллогын дүнтэй харьцуулж, нийт тоог гаргах шаардлага тавигдах нь зүй ёсны асуудал юм.

УБЕГ, ГИХАЭГ-ын мэдээнээс үзэхэд 2000-2010 онуудад нийт 40 орчим мянган иргэд, үүний дотроос 39 мянга орчим иргэд БНКаЗУ-ын харьяат болжээ. Тиймээс гадаад улсын харьяат болсон дээрх иргэдийн тоог оролцуулахгүйгээр тооллогын хамралт, ГХЯ-ны мэдээнээс үзэхэд гадаадад нийт 130-140 мянган иргэн удаан хугацаагаар оршин сууж байна.


ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа Монгол Улсын 107140 иргэн тоологдлоо.

ХҮСНЭГТ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүйс		Хүйсийн харьцаа
		Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	107 140	49 955	57 185	87.4
0-4	4 598	2 309	2 289	100.9
5-9	3 171	1 595	1 576	101.0
10-14	3 535	1 771	1 764	100.2
15-19	9 176	4 420	4 756	93.0
20-24	20 400	10 164	10 236	99.3
25-29	20 739	10 161	10 578	96.1
30-34	16 855	7 500	9 355	80.1
35-39	13 343	5 797	7 546	76.8
40-44	7 930	3 380	4 550	74.3
45-49	4 168	1 628	2 540	64.1
50-54	1 883	742	1 141	65.1
55-59	709	269	440	61.1
60-64	304	117	187	62.6
65-69	162	54	108	50.0
70+	167	48	119	48.1


ЗУРАГ 11.1. НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2010 ОН



Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцээс үзвэл 0-14 насны хүн ам 10.6 хувь, 15-44 насныхан 82.5 хувь, 45-64 насныхан 6.6 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 0.3 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, 10 хүн тутмын 9 хөдөлмөрийн насны хүн ам байгаа нь албан ёсны хөдөлмөрийн гэрээтэй болон хувиараа олон тооны иргэд гадаадад гарч ажиллаж, амьдарч байгаатай холбоотой.

Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 87.4 байгаа (46.6 хувь эрэгтэй, 53.4 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад эмэгтэйчүүд олон байгааг харуулж байна. Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч, 30 наснаас эхлэн огцом багасчээ. 0-14 насныхны хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байхад хөдөлмөрийн болон ахмад настнуудын хувьд эмэгтэйчүүд олонх байна. Гэхдээ гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн хүйсийн харьцаа улс орон бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал, хамгийн олон иргэн оршин суугаа БНСУ-д хүйсийн харьцаа 136.4, ОХУ-д 106.2 байхад Япон, АНУ, БНЧУ, БНХАУ-д тус тус 77.8, 75.3, 68.0, 56.7 байна.

ЗУРАГ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн нас, хүйсийн суварга илүү тодорхой мэдээллийг өгч чадна. Суваргаас харахад Монгол Улс дахь суурин хүн амын насны бүтэцтэй ойролцоо байна. Өөрөөр хэлбэл, 0-4 насны хүн ам 5-14 насныхаас илүү цүлхийсэн хэлбэртэй байгааг харуулж байна.


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор гадаадад оршин суугаа иргэдийн Монголд байнга амьдарч байсан аймаг, нийслэлийг тодруулж асуусан. Үүний үр дүнд гадаадад оршин суугаа иргэдийн 80 хувь нь Улаанбаатараас, 7 хувь нь Дархан-Уул, Орхон, 2.6 хувь нь Баян-Өлгий аймгаас гадаадад явжээ (хүснэгт 11.3).

ХҮСНЭГТ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Тоо	Дүнд эзлэх хувь	Аймаг, нийслэл	Тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	107 140	100.0			
Архангай	505	0.5	Сүхбаатар	243	0.2
Баян-Өлгий	2 824	2.6	Сэлэнгэ	1 780	1.7
Баянхонгор	395	0.4	Төв	1 330	1.2
Булган	588	0.6	Увс	422	0.4
Говь-Алтай	368	0.3	Ховд	617	0.6
Дорноговь	682	0.6	Хөвсгөл	593	0.6
Дорнод	679	0.6	Хэнтий	476	0.5
Дундговь	277	0.3	Дархан-Уул	3 978	3.7
Завхан	557	0.5	Улаанбаатар	85 758	80.0
Өвөрхангай	870	0.8	Орхон	3 581	3.3
Өмнөговь	459	0.4	Говьсүмбэр	158	0.2

Монгол Улсын иргэдийг гадаадад оршин суугаа улсаар авч үзвэл хамгийн их хүнтэй БНСУ, АНУ, БНЧУ дараа нь БНХАУ, Япон, ОХУ зэрэг улсууд юм. Эдгээр улсуудад гадаадад оршин суугаа нийт иргэдийн 66.8 нь ажиллаж, сурч, амьдарч байна.

ЗУРАГ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛСААР, 2010 ОН



Улаанбаатараас гадаадад явсан иргэдийн 20.7 хувь нь АНУ руу, 45.0 хувь нь зүүн Ази, Номхон далайн бүс нутагт, 31.6 хувь нь Европд зорчсон бол зүүн бүсээс хамгийн их нь өмнөд Ази, Европд, баруун бүсээс зүүн Ази, Номхон далайн бүс нутагт явсан хүмүүс зонхилж байна.

ХҮСНЭГТ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД,
БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ОРШИН СУУГАА УЛС,
БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

Бүс	Бүгд	Америк	Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг	Европ	Өмнөд Ази	Африк
БҮГД	100.0	18.4	47.5	31.3	1.5	1.3
Улаанбаатар	100.0	20.8	45.0	31.6	1.3	1.3
Зүүн	100.0	7.9	52.5	35.6	2.3	1.7
Төвийн	100.0	10.0	49.5	37.1	1.9	1.5
Хангайн	100.0	11.1	53.0	31.9	2.9	1.1
Баруун	100.0	4.6	79.8	13.2	1.5	0.9

Нийт иргэдийн 37 хувь нь сурах, 41.3 хувь нь хөдөлмөр эрхлэх (үүнээс 19.1 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 19.6 хувь нь хувиараа ажиллах, 2.6 хувь нь албан томилолтоор ажиллах), 0.7 хувь нь эмчлүүлэх, үлдсэн 21 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ. Явсан зорилгыг оршин суугаа улсаар нь харвал АНУ, БНСУ, БНХАУ руу хамгийн олон хүн суралцахаар (нийт сурахаар явагсадын 47.8 хувь), БНСУ, БНЧУ руу хамгийн олон хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагсдын 76.4 хувь), БНСУ, АНУ руу хамгийн их хүн хувиараа ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагсдын 47.3 хувь) явж байгаагаас харахад АНУ, БНСУ, БНЧУ монголчуудын хамгийн олноороо амьдарч, ажиллаж, сурдаг улс болжээ.

ХҮСНЭГТ 11.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА УЛС,
ЯВСАН ЗОРИЛГО, ХУВИАР, 2010 ОН

Оршин суугаа улс	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Суралцах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Хувиараа ажиллах	Албан томилолтоор ажиллах	Эмчлүүлэх	Бусад
БҮГД	107 140	100.0	37.0	19.1	19.6	2.6	0.7	21.0
Өмнөд Солонгос	29 534	100.0	21.6	40.3	22.3	1.7	0.8	13.3
Америк	17 036	100.0	43.6	4.1	19.7	2.2	0.6	29.8
Чех	7 274	100.0	9.0	51.6	18.6	1.3	0.2	19.3
Хятад	7 273	100.0	70.8	3.9	8.1	2.8	0.5	13.9
Япон	5 401	100.0	48.3	11.0	13.5	2.4	0.4	24.4
Орос	5 008	100.0	67.4	3.0	10.4	3.4	0.5	15.3
Герман	3 852	100.0	47.9	4.2	12.9	2.4	0.7	31.9
Англи	3 701	100.0	55.2	4.0	17.1	1.9	0.2	21.6
Франц	2 859	100.0	17.5	8.9	30.3	1.9	4.7	36.7
Турк	2 645	100.0	53.6	8.0	30.0	1.1	0.2	7.1
Казахстан	2 523	100.0	56.5	5.5	20.2	0.8	1.1	15.9
Унгар	1 615	100.0	15.3	38.8	20.2	3.3	0.5	21.9
Швейцари	1 509	100.0	22.2	11.2	32.6	5.4	0.7	27.9
Австри	1 346	100.0	35.8	6.1	22.5	2.8	0.8	32.0
Канад	1 259	100.0	27.5	3.8	19.0	4.4	0.7	44.6
Ирланд	1 124	100.0	55.9	3.5	15.4	1.7	0.3	23.2
Энэтхэг	1 116	100.0	91.8	0.9	1.3	0.9	0.2	4.9
Польш	999	100.0	30.6	7.1	23.9	9.6	0.5	28.3
Австрали	962	100.0	53.7	4.3	13.5	2.7	0.3	25.5
Итали	282	100.0	56.0	3.9	13.5	2.8	1.8	22.0
Бусад	9 822	100.0	28.5	11.2	26.8	5.7	0.9	26.9

Монголчууд гадаадад чөлөөтэй зорчих болсноос хойш 20 гаруй жил өнгөрчээ. Иргэдийн гадаадад оршин суугаа хугацааг авч үзэхэд 21.5 хувь нь 1 жил хүртэлх, дийлэнх буюу 53.2 хувь нь 2-5 жил, үлдсэн хувь нь 6-аас дээш жил гадаадад амьдарч байна. Хамгийн олон жил гадаадад оршин суугаа иргэд Герман, хуучин социалист орон байсан - Унгар, Польш улсад амьдарч байна. Харин БНКау, БНХАУ амьдарч байгаа иргэд хамгийн цөөн жил оршин суугаа ажээ. БНСУ, БНЧУ, Австрали, Энэтхэг зэрэг улсад амьдрагчид дунджаар 2-5 жил, Ирланд, ХБНГУ, АНУ хувьд 6-10 жил оршин суугаа иргэд багагүй хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 11.6. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА УЛС,
ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ХУВИАР, 2010 ОН

Оршин суугаа улс	Тоо	Хувь	Оршин суугаа хугацаа			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
БҮГД	107 140	100.0	21.5	53.2	19.9	5.4
Өмнөд Солонгос	29 534	100.0	19.7	65.0	12.9	2.4
Америк	17 036	100.0	14.5	42.3	35.8	7.4
Чех	7 274	100.0	9.7	64.5	18.0	7.8
Хятад	7 273	100.0	40.1	51.7	7.4	0.8
Япон	5 401	100.0	22.4	52.6	21.5	3.5
Орос	5 008	100.0	34.3	47.6	12.8	5.3
Герман	3 852	100.0	12.1	29.3	39.3	19.3
Англи	3 701	100.0	12.9	51.9	30.1	5.1
Франц	2 859	100.0	21.2	47.0	25.7	6.1
Турк	2 645	100.0	33.8	54.7	10.3	1.2
Казахстан	2 523	100.0	42.4	50.3	6.5	0.8
Унгар	1 615	100.0	8.2	35.4	20.9	35.5
Швейцари	1 509	100.0	22.7	50.4	22.1	4.8
Австри	1 346	100.0	16.9	51.0	25.6	6.5
Канад	1 259	100.0	33.3	44.3	17.8	4.6
Ирланд	1 124	100.0	9.4	48.9	40.8	0.9
Энэтхэг	1 116	100.0	33.9	57.6	7.5	1.0
Польш	999	100.0	15.8	33.7	21.4	29.1
Австрали	962	100.0	24.4	58.7	14.7	2.2
Итали	282	100.0	24.5	52.5	15.6	7.4
Бусад	9 822	100.0	26.5	51.2	17.8	4.5

ДҮГНЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 107140 иргэн тоологдов.

Нийт иргэдийн 37 хувь нь сурах, 41.3 хувь нь хөдөлмөр эрхлэх (үүнээс 19.1 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 19.6 хувь нь хувиараа ажиллах, 2.6 хувь нь албан томилолтоор ажиллах), 0.7 хувь нь эмчлүүлэх, үлдсэн 21 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ. Явсан зорилгыг оршин суугаа улсаар нь харвал АНУ, БНСУ, Хятад руу хамгийн олон хүн суралцахаар (нийт сурахаар явагсадын 47.8 хувь), БНСУ, БНЧУ руу хамгийн олон хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагсдын 76.4 хувь), БНСУ, АНУ руу хамгийн их хүн хувиараа ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагсдын 47.3 хувь) явж байгаагаас харахад АНУ, БНСУ, БНЧУ монголчуудын хамгийн олноороо амьдарч, ажиллаж, сурдаг улс болжээ.

Иргэдийн гадаадад оршин суугаа хугацааг авч үзэхэд 21.5 хувь нь 1 жил хүртэлх, дийлэнх буюу 53.2 хувь нь 2-5 жил, үлдсэн хувь нь 6-аас олон жил гадаадад амьдарч байна. Хамгийн олон жил гадаадад оршин суугаа иргэд ХБНГУ, хуучин социалист орон байсан - Унгар, Польш улсад амьдарч байна. Харин Казахстан, Хятадад амьдарч байгаа иргэд хамгийн цөөн жил оршин суугаа ажээ. БНСУ, БНЧУ, Австрали, Энэтхэг зэрэг улсад амьдрагчид дунджаар 2-5 жил, Ирланд, ХБНГУ, АНУ-ын хувьд 6-10 жил оршин суугаа иргэд багагүй хувийг эзэлж байна.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ



СУУЦНЫ ТӨРӨЛ

Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм. Төр, засгийн бодлогын нэг хэсэг нь хүн амаа орон сууцаар хангаж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд чиглэдэг.

Монгол Улс хүн амын 1969 оны тооллогоос эхлэн орон сууцны тооллогыг хамтатган зохион байгуулж, орон сууцны сан (фонд), түүний нөхцөлийн талаарх мэдээллийг цуглуулж, бодлого, хөтөлбөртөө оруулж ирсэн. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын орон сууц, түүний нөхцөлийн талаарх асуулгын агуулга, бүтэц нь өмнөх тооллогуудынхтай адил. Энэ удаа байшин болон монголын ард түмний уламжлалт сууц – гэрийн талаарх мэдээллийг тус тусад нь авч үзэв.

Тооллогод хэрэглэсэн сууц гэдэг ойлголт өргөн утгаараа тоолох үед хүний амьдарч байгаа зориулалтын болон зориулалтын бус бүх төрлийн сууцыг хамардаг. Нөгөө талаар хүн амын амьдарч байгаа сууцны нөхцөл ямар байгааг тодорхойлж, орон сууцжуулах бодлого, хөтөлбөрийн үр өгөөжийг үнэлэх зорилго агуулж байсан тул сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамжийн үзүүлэлтийг гаргахад чиглэгдсэн. Гэхдээ орон сууцны фондын тооллогыг явуулаагүй тул тооллогын үр дүнд хүн амьдардаггүй сууцны тоо, сууцны насжилт, ханын болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг гаргах боломжгүй. Тухайлбал, манай улс хэчнээн орон сууцны болон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, эсвэл гэртэй вэ гэсэн үзүүлэлтийг тодорхойлох бололцоогүй юм.

Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийдөө хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, зориулалтын бус гэж ангилсан. Өөрөөр хэлбэл, зориулалтын бус, бусад гэсэн ангиллын сууцууд хүний амьдрах тав тухтай орчинг хангах шаардлагад нийцэхгүй гэсэн агуулгыг илэрхийлнэ (сууцны төрлийн тодорхойлолтыг энэ номын 1 дүгээр бүлгийн “Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт” гэсэн хэсгээс үзнэ үү). Дараагийн онцлон тэмдэглэх асуудал бол нэгээс илүү сууцтай өрхүүдийн хувьд хүйтний улиралд амьдардаг үндсэн сууцаар нь асуулгыг асуусан болно.

ЗУРАГ 12.1. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010 ОН



Орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 45.2 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц гэрт, 53.6 хувь нь байшинд, 1.1 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 5.7 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 4.6 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.1. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Гэр	322.8	45.2	156.7	32.7	166.1	70.9
Байшин	382.8	53.6	316.1	65.9	66.7	28.5
Зориулалтын бус сууц	8.1	1.1	6.6	1.4	1.5	0.6
Бусад	0.1	0.0	0.1	0.0	0.0	0.0

Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Хотод нийт өрхийн 65.9 хувь нь байшинд, 32.7 хувь нь гэрт амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь буурч, гэрт амьдардаг өрхийнх нэмэгджээ. Энэ нь гол төлөв томоохон хот, аймгийн төвүүдэд хөдөөнөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд эхлээд гэр хороололд суурьшдагтай холбоотой. Хотын байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 48.8 хувиар өссөн боловч гэрт амьдрагчдын тоо илүү ихээр нэмэгджээ. Хөдөөгийн өрхийн 70.9 хувь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 7.4 пунктээр буурч, харин байшинд амьдардаг өрхийн хувь 6.8 пунктээр өссөн байна. Ерөнхийдөө хот, хөдөөгийн гэр, байшинд амьдардаг өрхийн хувийн жингийн зөрүү тооллого хооронд буурч, өрхүүдийн сууцны ялгаа багассан. Хот, хөдөөд байшинд амьдардаг өрхийн тоо өсч байгаа нь тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр иргэд өөрсдөө байшин барьж суух нь олширч, орон сууцаар хангах бодлого тодорхой хэмжээгээр нөлөөлснийг гэрчилнэ.

Байшинг төрлөөр нарийвчилж ангилсан нь 2000 оны тооллогынхоос бага зэрэг ялгаатай ч харьцуулалт хийх бололцоотой юм. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 21.3 хувийг эзэлж, 2000 оныхоос 0.7 пунктээр буурсан байна. Харин сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2000 оныхоос 4.7 пунктээр өссөн нь иргэд өөрсдөө байшин барьж суух бололцоо нэмэгдсэнийг харуулж байна. Нийт өрхийн 0.5 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа бол 2000 онд уг үзүүлэлтийг тусад нь тодорхойлж байгаагүй юм.

ХҮСНЭГТ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Сууцны төрөл	2000		2010	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	541.1	100.0	713.8	100.0
Гэр	275.6	50.9	322.8	45.2
Зориулалтын бус сууц	3.4	0.6	8.1	1.1
Бусад	0.8	0.1	0.1	0.0
Байшин	261.3	48.3	382.8	53.6
Орон сууцны байшин	119.0	22.0	152.3	21.3
Бие даасан тохилог сууц ¹	-	-	3.8	0.5
Сууцны тусдаа байшин	133.9	24.7	209.9	29.4
Нийтийн байр ²	8.4	1.6	16.7	2.3

¹ 2000 онд бие даасан тохилог сууцыг тусад нь тодорхойлоогүй

² оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байрыг хамт авч үзэв.

Гэрт амьдардаг өрх хөдөөд дийлэнх байгаа боловч сумын төв, хөдөөгөөр ангилахад үр дүн нь илүү тодорхой болно. Тухайлбал, сумын төвд оршин суудаг өрхийн 46.9 хувь, хөдөөгийн 14.9 хувь нь байшинд амьдарч, 2000 оныхоос 3.6-4.8 пунктээр нэмэгдсэн. Энэ нь нэг талаас хүн амын амьжиргааны төвшин 2000 онтой харьцуулахад дээшилсэн, нөгөө талаас шилжих хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой.

ХҮСНЭГТ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, БАЙРШИЛ, ХУВИАР, 2010 ОН

Сууцны төрөл	Бүгд	Байршил				
		Хөдөө	Сумын төв	Тосгон	Аймгийн төв	Улаанбаатар
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	45.2	84.7	52.0	36.7	39.4	28.9
Байшин	53.6	14.9	46.9	62.3	59.1	69.7
Зориулалтын бус сууц	1.1	0.3	1.1	1.0	1.5	1.4
Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Тосгонд амьдардаг өрхийн 62.3 хувь нь байшинд амьдарч байна. Энэхүү үзүүлэлтийг өмнөх тооллогын үр дүнтэй харьцуулах боломжгүй юм. Учир нь “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” Монгол Улсын хуулийн дагуу тосгонд хамаарах суурингийн тоо 2000 онд 29 байснаа 2010 онд 17 болж өөрчлөгдсөн.

ОРОН СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР

Сууцны өмчийн хэлбэрийг 2010 оны тооллогод тодорхойлохдоо төрийн болон хувийн гэж 2 ерөнхий ангилалд хуваасан бөгөөд хувийн өмчийг дотор нь иргэний, аж ахуй нэгж байгууллагын гэж ангилсан. Уг үзүүлэлтийг 2000 онд төрийн, хувийн, холимог (2000 онд нийт өрхийн 1 хувь нь амьдарч байсан) гэж ангилж байжээ. Тиймээс сууцны өмчийн хэлбэрийг 2000 оныхтой ерөнхий ангиллын хувьд харьцуулах бүрэн бололцоотой юм.

ХҮСНЭГТ 12.4. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Сууц төрөл	Бүгд		Төрийн өмчийн		Хувийн өмчийн			
					Аж ахуйн нэгж, байгууллагын		Иргэний	
	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	11.6	1.6	15.5	2.2	686.7	96.2
Гэр	322.8	100.0	1.3	0.4	1.3	0.4	320.3	99.2
Байшин	382.8	100.0	9.4	2.5	11.0	2.9	362.4	94.7
Зориулалтын бус сууц	8.1	100.0	0.9	11.4	3.2	39.9	3.9	48.8
Бусад	0.1	100.0	0.0	31.9	0.0	31.9	0.0	36.1

Нийт өрхийн 98.4 хувь хувийн (96.2 хувь нь иргэний, 2.2 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцанд амьдарч байгаа нь 2000 оныхоос 7.7 пунктээр нэмэгджээ. Гэрт суудаг өрхийн 99.6 хувь хувийн (99.2 хувь нь иргэний, 0.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцанд байгаа нь 2000 оныхоос 0.1 пунктээр өсчээ. Байшинд суудаг өрхийн 2.5 хувь нь төрийн өмчийн сууцанд, 97.5 хувь нь хувийн (94.7 хувь нь иргэний, 2.9 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) өмчийн сууцанд амьдарч байна. Харин 2000 оны тооллогын дүнгээс үзэхэд байшинд амьдардаг нийт өрхийн 16.6 хувь нь төрийн, 81.6 хувь нь хувийн өмчийн сууцанд амьдарч байжээ. Төрийн өмчийн сууц ийнхүү багассан нь улсаас төрийн мэдлийн орон сууцыг хувьчилж, иргэдээ өмчтэй болгох бодлого хэрэгжүүлсний үр дүн юм.

ХҮСНЭГТ 12.5. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Өмчлөлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Төрийн өмчийн	11.6	1.6	7.4	1.5	4.2	1.8
Хувийн өмчийн	702.2	98.4	472.1	98.5	230.0	98.2
ААНБ-ын	15.5	2.2	12.6	2.6	2.9	1.3
Иргэний	686.7	96.2	459.6	95.8	227.1	96.9

Өрхийн сууцны өмчийн хэлбэрийг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа өрх хөдөөд (1.8 хувь), хотоос (1.5) илүү байсан бол 2000 онд эсрэгээрээ хотод (12.5 хувь), хөдөөгөөс (3.1 хувь) илүү байжээ. Хувийн өмчийн сууцанд амьдардаг өрх хөдөөд 98.2 хувь, хотод 98.5 хувь байгаа нь 2000 оныхоос тус тус 1.6, 12.6 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.6. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Өөрийн эзэмшлийн	619.0	86.7	401.1	83.6	217.9	93.1
Бусдын сууцанд түрээстэй суудаг	45.0	6.3	40.9	8.5	4.0	1.7
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	43.5	6.1	33.0	6.9	10.6	4.5
Бусад	6.3	0.9	4.5	0.9	1.7	0.7

Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх зэрэг асуултад тодорхой хэмжээгээр хариулт өгөх үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Сууцны эзэмшлийг хэлбэрээр нь үзэхэд хэд хэдэн асуудал тодорхой болно. Улсын хэмжээнд нийт өрхийн 13.3 хувь буюу 94.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Эдгээрийн 78.4 мянга нь хотын өрхүүд юм. Хөдөөд энэ үзүүлэлт харьцангуй бага байгаа нь орон сууцны хэрэгцээг гол төлөв шинэ гэр, байшин барьж хангах боломжтой байдагтай холбоотой. Нэг орон байранд хамт амьдарч байгаа өрхүүдийг үндсэн болон хамт амьдарч байгаагаар нь ялгаж тоолсон тул эзэмшлийн хэлбэрийг үүнтэй холбон судлах бололцоо байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг 2000 оныхоос нэлээд дэлгэрүүлж авсан. Энэ нь сүүлчийн жилүүдэд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсонтой холбоотой. Тиймээс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хангамж, хүрэлцээг тодорхойлж, цаашид холбогдох бодлого, хөтөлбөр боловсруулах суурь мэдээлэл бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

ХҮСНЭГТ 12.7. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян. өрх*	эзлэх хувь	мян. өрх	эзлэх хувь	мян. өрх	эзлэх хувь
БҮГД	705.6	100.0	472.9	100.0	232.8	100.0
Төвлөрсөн систем	541.1	76.7	450.3	95.2	90.9	39.0
Дизель станц	18.8	2.7	8.8	1.9	10.0	4.3
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	110.0	15.6	6.3	1.3	103.8	44.6
Бага оврын цахилгаан үүсгүүр	12.5	1.8	2.2	0.5	10.3	4.4
Цахилгааны эх үүсвэргүй	23.2	3.3	5.4	1.1	17.9	7.7
ГЭР	322.8	100.0	156.7	100.0	166.1	100.0
Төвлөрсөн систем	182.5	56.5	139.5	89.0	42.9	25.9
Дизель станц	12.2	3.8	5.4	3.4	6.8	4.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	96.5	29.9	5.7	3.6	90.8	54.7
Бага оврын цахилгаан үүсгүүр	10.4	3.2	1.6	1.0	8.9	5.3
Цахилгааны эх үүсвэргүй	21.2	6.6	4.6	2.9	16.6	10.0
БАЙШИН	382.8	100.0	315.8	100.0	66.7	100.0
Төвлөрсөн систем	358.7	93.7	310.7	98.3	47.9	71.9
Дизель станц	6.6	1.7	3.4	1.1	3.2	4.8
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	13.5	3.5	0.6	0.2	12.9	19.4
Бага оврын цахилгаан үүсгүүр	2.1	0.5	0.6	0.2	1.4	2.1
Цахилгааны эх үүсвэргүй	2.0	0.5	0.8	0.2	1.3	1.9

*Зориулалтын бус сууц, бусад сууцанд амьдарч байгаа өрхийн тоо ороогүй

Улсын хэмжээнд 23.2 мянган өрх цахилгаангүй байна. Энэ нь өмнөх тооллогын үеийнхээс 7.6 дахин буурсан үзүүлэлт юм. Цахилгаангүй өрхийн 91.3 хувь нь гэрт амьдардаг бөгөөд тэдгээрийн 78.3 хувь нь хөдөө оршин суудаг ажээ. Сэргээгдэх эрчим хүч ашигладаг өрхийн 90 гаруй хувь хөдөө орон нутагт байгаа нь цаашид ийм төхөөрөмжийн хэрэгцээ нэмэгдэхийг дээрх хүснэгтээс харж болно.

ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Монголын ард түмний үндэсний уламжлалт сууц болох гэрт нийт өрхийн 45-аас илүү хувь нь амьдарч байгааг дээр тэмдэглэсэн.

ХҮСНЭГТ 12.8. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Ханын тоо							
			5-аас цөөн		5		6		6-аас дээш	
	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь	мян. өрх	бүгдэд эзлэх хувь
БҮГД	322.8	100.0	82.0	25.4	181.7	56.3	50.8	15.7	8.3	2.6
1-2	88.0	100.0	31.3	35.6	44.8	51.0	10.4	11.9	1.4	1.5
3-4	150.4	100.0	35.2	23.4	87.8	58.4	23.7	15.7	3.8	2.5
5-6	71.6	100.0	13.3	18.5	41.7	58.2	14.1	19.6	2.6	3.7
7+	12.8	100.0	2.2	17.5	7.4	57.9	2.6	20.5	0.5	4.0

Гэрт амьдардаг өрхийн 56.3 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байгаагаас үзэхэд таван ханатай гэр манай ард түмний түгээмэл сууц гэж ойлгогдоно. Гэрийн ханын тоогоор талбайн хэмжээг тооцож болох хэдий ч аймаг орон нутаг, үндэстэн угсаатны уламжлалт зан заншилтай холбоотойгоор ханын толгойн тоо, зууравчны хэмжээнээс хамаарч, гэрийн хэмжээ бүс нутгуудад өөр өөр байдгийг судлаачид анхаарах нь зүйтэй. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэхийн хэрээр гэрийн ханын тоо нэмэгдэх нь зүй ёсны асуудал бөгөөд энэ зүй тогтлыг дээрх хүснэгтээс ажиглаж болно.

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн талаар бие засах газар, хатуу хог хаягдал болон бохир ус зайлуулах хэлбэр гэсэн үзүүлэлтийг тухайн өрхөөс асуусан бөгөөд үр дүнг нь нэгтгэвэл дараах байдалтай байна.

ХҮСНЭГТ 12.9. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН


Ахуйн нөхцөл	Бүгд	Хот	Хөдөө
БИЕ ЗАСАХ ГАЗАРТАЙ ЭСЭХ	100.0	100.0	100.0
Бусадтай хамтран ашигладаг	43.5	58.4	29.5
Бусадтай хамтран ашигладаггүй	30.7	36.9	24.8
Тогтсон газар байхгүй	25.8	4.7	45.7
ХАТУУ ХОГ ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР	100.0	100.0	100.0
Үйлчилгээний байгууллагаар	43.0	80.1	7.9
Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	21.9	10.0	33.2
Тогтсон газар байхгүй	35.1	9.9	58.9
БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР	100.0	100.0	100.0
Цооногт асгадаг	56.5	81.7	32.6
Задгай асгадаг	43.5	18.3	67.4

Бие засах тодорхой цэггүй өрх нийт өрхийн 25.8 хувийг эзэлж байгаа бол энэ үзүүлэлт хотод 4.7 хувь буюу 7.4 мянган өрх байгаа нь анхаарал татаж байна. Хотод бие засах газраа олон өрх дундаа ашиглах, тогтсон газар байхгүй байх нь хөрсний бохирдол, хүн амд халдварт өвчин тархах магадлалыг нэмэгдүүлж байна. Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх хотын нийт өрхийн 9.9 хувь, бохир усаа задгай асгадаг өрх 18.3 хувь байгаа нь хот суурин газар оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж байгааг анхаарч, цаашид гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Гэрт амьдардаг өрхийн 55.7 хувь нь баталгаатай эх үүсвэрээс ундны усаа авч байна. Харин 44.3 хувь нь баталгаагүй ундны ус хэрэглэж байгаагаас 36.1 хувь гол мөрөн, нуур, булаг шанд, 8.2 хувь нь зөөврийн ус хэрэглэж байна. Энэ нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө амьдардагтай холбоотой. Өрхийн ундны усны эх үүсвэрийн талаарх 2010 оны тооллогын асуулт өмнөх тооллогынхоос ялгаатай тул зэрэгцүүлэх боломжгүй юм.

ЗУРАГ 12.2. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ, ХУВИАР, 2010 ОН



БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

СУУЦНЫ БАГТААМЖ

Байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээ, өрөөний тоог тооллогын асуулгад оруулсан нь сууцны зай талбай оршин суугчдын эрүүл ахуйн шаардлагыг хэр зэрэг хангаж байгаа болон аймаг, бүс нутгийг жиших, гадаад орнуудын ижил төрлийн үзүүлэлттэй зэрэгцүүлж, бодлого төлөвлөлтөд ашиглах зорилготой.

ХҮСНЭГТ 12.10. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХУВИАР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Сууцны талбай (квадрат метр)					
			20 хүртэл		21-40		40-өөс дээш	
	мян.өрх	бүгдэд эзлэх хувь	мян.өрх	бүгдэд эзлэх хувь	мян.өрх	бүгдэд эзлэх хувь	мян.өрх	бүгдэд эзлэх хувь
БҮГД	378.2	100.0	50.4	13.3	151.3	40.0	176.5	46.7
1-2	95.0	100.0	19.1	20.1	39.8	41.8	36.2	38.1
3-4	180.6	100.0	22.6	12.5	72.6	40.2	85.3	47.3
5-6	82.8	100.0	7.2	8.7	31.4	37.9	44.2	53.4
7+	19.8	100.0	1.5	7.5	7.4	37.6	10.9	54.9

Байшинд амьдардаг өрхийн 40 хувь нь 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 14.9 пунктээр буурав. Гэтэл 40-өөс дээш квадрат метр талбайтай байшинд суудаг өрхийн хувь 46.7 хувь болж, өмнөх тооллогынхоос 2.9 дахин өссөнийг ерөнхийдөө орон сууцны багтаамж сайжирсан гэж үзэж болно. Үүнийг нотлох нэг үзүүлэлт бол 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 54.9 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай байранд амьдарч байгаа явдал юм. Өрөөний болон өрхийн ам бүлийн тоог харьцуулж үзэхэд сууцны багтаамж нэмэгдсэн нь илүү тодорхой болно.

ХҮСНЭГТ 12.11. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ХУВИАР, 2010 ОН

Ам бүлийн тоо	Бүгд	Өрөөний тоо						
		1	2	3	4	5-7	8-10	11+
БҮГД	100.0	33.6	39.5	18.9	5.5	2.1	0.3	0.2
1-2	100.0	43.5	37.0	14.5	3.5	1.2	0.2	0.2
3-4	100.0	32.8	40.8	18.9	5.2	1.9	0.2	0.2
5-6	100.0	26.5	40.0	22.4	7.5	3.0	0.4	0.2
7+	100.0	23.5	38.4	24.9	8.5	3.9	0.5	0.2

Тооллогоор байшинд амьдардаг өрхийн 73.1 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь 2000 оноос 7.6 пунктээр буурчээ. Тус улсын өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 73.6 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгааг өмнөх тооллогын үетэй харьцуулахад 9.1 пунктээр, 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 62.0 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 11.7 пунктээр тус тус буурав. Долоо, түүнээс дээш ам бүлтэй байшинд амьдардаг өрхийн 4.6 хувь 5-аас олон өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь 2000 оныхоос 5.1 дахин өссөн байна.

ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

Энэ удаагийн тооллогоор орон сууцны нөхцөлийн талаар нэлээд мэдээлэл цуглуулсныг дээр дурдсан. Дараах хүснэгтэд байшинд суудаг өрхийн дэд бүтцийн хангамж болох халаалтын төрөл, усан хангамж, бие засах газар, онгоц, шүршүүрийн өрөөний талаарх үр дүнг танилцуулна.

Байшинд амьдардаг өрхийн 43.8 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 0.6 пунктээр буурсан аж. Хотын төвлөрсөн халаалттай байшинд амьдардаг өрхийн хувь 3.2 пунктээр буурсан бол хөдөөд энэ хувь бараг 3 дахин нэмэгджээ. Харин иргэд сууцаа ердийн галлагаагаар халааж байгаа хувь хот, хөдөөд, ялангуяа хотод илүү нэмэгдсэн байна. Энэ бүхнээс үзэхэд өнгөрсөн 11 жилийн хугацаанд сууцыг халаалтаар хангах, дулааны шугам сүлжээ, дэд бүтцийг бий болгох асуудал учир дутагдалтай явж ирснийг харуулна. Хотод ердийн байдлаар сууцаа халаах явдал нэмэгдсэн нь сүүлчийн жилүүдийн томоохон хот, аймгийн төвүүдийн агаарын бохирдлоос ч тодорхой мэдрэгдэнэ.

ХҮСНЭГТ 12.12. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Халаалтын төрөл	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн	44.3	54.7	2.5	43.8	51.6	7.2
Төвлөрсөн бус	12.3	12.1	13.0	5.9	6.3	4.1
Нам даралтын зуух	-	-	-	5.3	5.6	3.6
Цахилгаан халаагуур	-	-	-	0.6	0.7	0.5
Ердийн галлагаа	43.4	33.2	84.5	50.2	42.1	88.7

Халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн хувь 38.7 байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 1.1 пунктээр буурсан байна. Энэ үзүүлэлт хотод 46.0 хувь, хөдөөд 3.7 хувь байна. Байшинд амьдардаг өрхийн 56.8 хувь буюу 214.7 мянган өрх зөөврийн ус хэрэглэж байгаагийн дотор хотын 152.7 мянган өрх байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувь өмнөх тооллогоос 3.0 пунктээр нэмэгдсэний дотор хотод 5.5 пункт, хөдөөд 1.3 пунктээр тус тус ихэсчээ.

ХҮСНЭГТ 12.13. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ХОТ ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Усан хангамж	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	42.8	50.6	5.9
Халуун, хүйтэн устай	38.5	45.8	3.6
Зөвхөн хүйтэн устай	4.4	4.8	2.4
Төвлөрсөн бус усан хангамж	57.2	49.4	94.1
Бие даасан систем	0.4	0.4	0.3
Халуун, хүйтэн устай	0.2	0.2	0.2
Зөвхөн хүйтэн устай	0.2	0.2	0.2
Зөөврийн	56.8	48.9	93.8

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтийн нэг нь онгоц, шүршүүр юм. Энэхүү үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ямар байгааг тодруулах, энэ төрлийн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь эх үүсвэр болно.


ХҮСНЭГТ 12.14. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БИЕ ЗАСАХ ГАЗАР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Сууцны дотор	46.9	57.9	2.9	42.4	50.1	5.9
Бусадтай хамтран ашигладаг	1.9	2.4	0.1	6.1	7.2	0.8
Бусадтай хамтран ашигладаггүй	45.0	55.5	2.8	36.3	42.9	5.2
Сууцны гадна	53.1	42.1	97.1	55.5	49.4	84.3
Бусадтай хамтран ашигладаг	-	-	-	24.9	23.3	32.5
Бусадтай хамтран ашигладаггүй	-	-	-	30.7	26.2	51.8
Тогтсон газар байхгүй	-	-	-	2.1	0.5	9.7
ОНГОЦ, ШҮРШҮҮРИЙН ӨРӨӨ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өрөөтэй	43.4	53.5	3.0	40.6	47.8	6.6
Байнгын суурилуулсан	-	-	-	40.0	47.1	6.0
Угсардаг /зөөврийн/	-	-	-	0.7	0.7	0.5
Нийтээрээ ашигладаг	-	-	-	2.2	2.5	0.5
Өрөөгүй	56.7	46.5	97.0	57.2	49.6	92.9

Сууцны дотроо бие засах газартай өрхийн хувь улсын хэмжээнд 42.4 хувь болсон нь 2000 оноос 4.5 пунктээр буурсан бол сууцны гаднаа бие засах газартай өрхийн хувь нэмэгджээ. Хот суурин газарт бие засах тогтсон газаргүй 1458 өрх байна.


Байшинд амьдардаг өрхийн онгоц, шүршүүрийг энэ удаагийн тооллогод өрх дангаараа эзэмшдэг болон нийтээрээ ашигладаг, онгоц шүршүүргүй гэсэн ангиллаар тусгасан. Өмнөх тооллогод уг үзүүлэлтийг онгоц, шүршүүрийн өрөөтэй, өрөөгүй гэж ангилан, өрөөтэй гэснийг тусдаа болон нийтийн хэмээн салгаж тодорхойлсон. Үүнийг энэ бүлэгт 2 тооллогын үр дүнг харьцуулах үүднээс тусдаа, нийтийн гэсэн дэд ангиллыг салгаж оруулсангүй (хүснэгт 12.14). Байшинд амьдардаг нийт өрхийн 42.8 хувь (тусдаа эзэмшдэг 40.6 хувь, нийтээрээ ашигладаг 2.2 хувь) нь онгоц, шүршүүртэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 0.6 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлт хотод 3.1 пунктээр буурсан бол хөдөөд 4.1 пунктээр нэмэгдсэн байна. Байнгын суурилуулсан онгоц, шүршүүртэй сууцанд амьдардаг өрх нийт байшинд амьдардаг өрхийн 40.0 хувийг эзэлж байгаагийн дотор хөдөөд энэ үзүүлэлт дөнгөж 6 хувь байгаа нь хангалтгүй юм. Харин онгоц шүршүүргүй өрхийн хувь улсын хэмжээнд 57.2 байхад хөдөөгийн өрхийн бараг 93 хувь нь ийм сууцанд амьдарч байна.

ЗУРАГ 12.3. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН, ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН



Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам шүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот суурин газруудад хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө. Байшинд амьдардаг өрхийн 77.1 хувь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс ихээхэн дэвшил гарсан байна. 2000 онд байшинд суудаг өрхийн 10 хувь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2010 онд 5 хувь болтлоо буурчээ.

ЗУРАГ 12.4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН



Байшинд амьдардаг өрхийн 42.3 хувь нь төвлөрсөн системээр, 0.4 хувь нь бие даасан системээр шингэн хог хаягдлаа зайлуулж, 48.3 хувь нь цооногт, үлдсэн 9 хувь нь задгай асгаж байна. Цооногт асгаж байгаа хувь өндөр байгаа нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд амьдардаг өрхийн дийлэнхийг бүрдүүлж байгаатай холбоотой.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын нийт өрхийг сууцны төрлөөр ангилахад 45.2 хувь нь гэрт, 53.6 хувь нь байшинд, 1.1 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Өмнөх тооллогын үеийнхээс байшин амьдардаг өрхийн эзлэх хувь 5.3 пунктээр нэмэгдэж, гэрт амьдардаг өрхийн хувь 5.7 пунктээр буурчээ. Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай юм. Хотод нийт өрхийн 2/3 байшинд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс буурсан. Энэ нь гол төлөв том хотуудад хөдөөнөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд гэр хороололд суурьшдагтай холбоотой.

Улсын хэмжээнд нийт өрхийн 13.3 хувь буюу 94.8 мянган өрх өөрийн эзэмшлийн сууцгүй байна. Хотын нийт өрхийн 16.3 хувь буюу 78.4 мянга нь өөрийн гэсэн сууцгүй ажээ.

Тооллогын дүнгээс үзэхэд 23.2 мянган өрх цахилгаангүй байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 7.6 дахин буурсан чухал дэвшил юм. Цахилгаангүй өрхийн 91.3 хувь нь гэрт амьдарч байгаагийн дотор 78.3 хувь нь хөдөөд оршин суудаг ажээ. Цахилгааны эх үүсвэрээр хангагдаагүй өрхийн хувь хэд дахин буурсан сайн талтай ч цаашид энэ тал дээр анхаарах нь зүй ёсны асуудал юм.

Ерөнхийдөө орон сууцны багтаамж сайжирчээ. Үүнийг байшинд амьдардаг өрхийн 40 хувь 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч, өмнөх тооллогын үеийнхээс 14.9 пунктээр буурсан, харин 40-өөс дээш квадрат метр талбайтай байшинд амьдардаг өрхийн хувь 46.7 хувь болж, өмнөх тооллогынхоос 2.9 дахин өссөнөөс харж болно.

Хотод амьдардаг нийт өрхөд эзлэх төвлөрсөн халаалттай байшинд амьдардаг өрхийн хувь 3.2 пунктээр буурсан бол хөдөөд энэ хувь бараг 3 дахин нэмэгджээ. Ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь хот, хөдөөд нэмэгдсэний дотор хотод илүү нэмэгдсэн байна. Энэ нь хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

Сууцны дотроо бие засах газартай байшинд амьдардаг өрхийн хувь улсын хэмжээнд 42.4 хувь болсон нь 2000 оноос 4.5 пунктээр буурсан бол сууцны гаднаа бие засах газартай өрхийн хувь нэмэгдэв. Байшинд амьдардаг нийт өрхийн 42.8 хувь (тусдаа эзэмшдэг 40.6 хувь, нийтээрээ ашигладаг 2.2 хувь) нь онгоц, шүршүүртэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 0.6 пунктээр буурчээ. Байшинд амьдардаг өрхийн 77.1 хувь үйчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үетэй харьцуулахад ихээхэн дэвшил гарсан. 2000 онд байшинд суудаг өрхийн 10 хувь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2010 онд 5 хувь болтлоо буурчээ.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл хүн амыг цахилгаанаар хангаж, төвлөрсөн болон төвлөрсөн бус байдлаар эрчим хүчний эх үүсвэрийг шийдэх бодлого, хөтөлбөр, хэрэгжүүлсэн арга хэмжээ бодитой үр дүнд хүрсэн бол хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор сууцны халаалт, дулаан, ариун цэврийн байгууламж зэрэг үзүүлэлтүүдийн хувьд эерэг өөрчлөлт ажиглагдсангүй.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ



Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2000-2010 онд 1.5 хувь болсон нь өмнөх 10 жилийнхээс 0.1 пунктээр илүү юм. Үүнд хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт өмнөх 10 жилийнхээс илүү байсан, мөн 1989-1990 онд Монгол Улсад ажиллаж, амьдарч байсан хуучин Зөвлөлт Холбоот Улсын 50 шахам мянган иргэн нутаг буцаж, 1990-ээд оны дундуур 50 гаруй мянган казах иргэд Казахстан улсад хөдөлмөрийн гэрээтэй ажиллахаар явж, шилжин суурьшсан шиг гадаад улс орнуудад олон арван мянган хүн бөөнөөрөө шилжээгүй нь нөлөөлсөн байна. Аймгуудын хүн амын жилийн дундаж өсөлт дотоод шилжих хөдөлгөөний нөлөөгөөр 5 аймаг (Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр), нийслэлээс бусад бүх аймагт буурчээ. Сүүлчийн 20 жилд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд тийм ч өндөр биш байлаа. Цаашдаа хүн ам энэ тогтмол хэмжээгээр өсвөл ойролцоогоор 47-50 жилд одоогийнхоос 2 дахин олон болох юм.

Хүн амын насны бүтцэд өөрчлөлт гарч, нийт хүн амд 0-4 насныхны эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс өссөн. Энэ нь өнгөрсөн 10 жилд нийтдээ 583.8 мянган хүүхэд төрсний дотор 2007-2009 онуудад төрөлт өмнөх жилүүдийнхээс нэлээд нэмэгдсэн нь хүн амын өсөлтөд эерэг нөлөөлсөнтэй холбоотой юм. Харин 5-9 насны бүлэг дэх хувийн жин өмнөх 10 жилийнхээс буурсан байна. Ерөнхийдөө 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин 2000 оныхоос 8.5 пунктээр буурсан бол хөдөлмөрийн буюу 15-64 насны хүн амын хувийн жин 8.3 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээлгэгчдийн харьцаа буюу хүн ам зүйн ачаалал 2010 онд 2000 оныхоос 19.6 пунктээр буурав.

Төрөлтийг нэмэгдүүлэх, улмаар хүн амын өсөлтийн хурдыг түргэтгэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх, хүн амын насны залуу бүтцээ цаашид урт хугацаанд хадгалах талаар анхаарах шаардлага байгаа нь 2010 оны тооллогын дүнгээс харагдаж байна.

Хүн амын шилжих хөдөлгөөний 2000-2010 оны дүр төрх өмнөх 10 жилийнхтэй ерөнхийдөө төстэй, нийслэл хотоос бусад бүх бүс нутагт шилжих хөдөлгөөний урсгал гадагшаа чиглэжээ. Баруун бүсээс бусад бүс руу цэвэр шилжилт (шилжин ирсэн, явсан хүний зөрүү) хамгийн их байна. Улаанбаатар хотод төрөөд тоолох үед нийслэлд сууж байгаа хүний эзлэх хувь 92.3 байгаа нь Улаанбаатар хотод төрсөн хүн өөр бүсэд шилжин суурьших сонирхол тун бага байгааг харуулж байна. Улаанбаатар хотын хүн ам 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 135.7 мянган хүнээр нэмэгдсэн нь тоолох үед нийслэлд оршин сууж байсан 9 хүний нэг нь сүүлчийн 5 жилд шилжин суурьшисныг харуулж байна. Гэтэл баруун бүсийн хүн амын 5 жилийн цэвэр шилжилтийг тооллогоор байгаа хүн амын тоотой харьцуулахад 12.8 хувьтай тэнцэж байна.

Тооллогын өмнөх нэг жилд улсын хэмжээнд 101.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцож байгаа нь Өвөрхангай аймгийн суурин хүн амтай тэнцүү юм. Энэ үзүүлэлт улсын хэмжээний суурин хүн амын 3.8 хувийг эзлэж байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт билээ.

Манай улсад төв сууринг чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс хамаарч хотын хүн ам өсч, хотжилт хурдацтай нэмэгджээ. Нийслэлээс гадна аймгийн төвүүд үүний дотор Дархан, Эрдэнэт хот хүмүүст боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээ үзүүлэх, ажлын байр олох боломж илүү байдаг нь хөдөөнөөс төв суурин газрыг чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэх үндсэн шалтгаан юм. Мөн сүүлчийн жилүүдэд тохиолдож байгаа байгалийн гамшигт үзэгдлүүд малчдад хүндээр тусч, тэд төв суурин газарт шилжиж байгаа нь хотжих үйл явц өмнөхөөсөө илүү хурдацтай өсөх бас нэг нөхцөл болов. Цаашдаа шилжих хөдөлгөөний урсгал, ялангуяа нийслэлийг чиглэсэн шилжих хөдөлгөөн, төвлөрлийг сааруулах талаарх дунд, урт хугацааны бодлого боловсруулан, хэрэгжүүлэх нь чухал болохыг тооллогын дүн харуулж байна.

Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын төвшин өмнөх тооллогын үеийнхээс 4.1 пунктээр дээшилж, 92.5 хувь болсны дотор нийт хүн амд дээд боловсролтой хүний

эзлэх хувь өнгөрсөн 11 жилд 10.7 пунктээр нэмэгдсэн нь нэг талаар сайн үзүүлэлт боловч нөгөө талдаа үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах тусгай мэргэжлийн дунд болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурсан байна. Олон улсын нийтлэг жишиг хандлагатай зэрэгцүүлэхэд манай улсын дээд, тусгай мэргэжлийн дунд болон мэргэжлийн боловсролтой хүний хоорондох зохистой харьцаа алдагдсан байна. Тухайлвал манай улсын дээд боловсролтой 6 хүнд нэг мэргэжлийн боловсролтой хүн, дээд боловсролтой 3 хүнд 1 тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн ногдож байна. Тиймээс мэргэжилтэй боловсон хүчний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт зохицохгүй, нийгмийн ухааны чиглэлийн мэргэжлээр төгссөн дээд боловсролтой мэргэжилтэй боловсон хүчний илүүдэл болж, тэд мэргэжлийн чиглэлээрээ ажиллах ажлын байр үндсэндээ байхгүй байгаа зэрэг асуудлыг зохицуулах шаардлага байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 98.3 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь олон улсын дунджаас өндөр байна. Харин хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд ялгаа их байгаа юм. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь хөдөөгийнхөөс дөрөв дахин бага, тэдний 0,9 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаагаас үзэхэд хотынхон бараг бүхэлдээ бичигтэн болсон гэж үзэж болно.

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирсан байна. Тухайлбал, 2000 онд 8 настай бүх хүүхдийн 84.8 хувь нь сургуульд сурч байсан бол 2010 онд 98.4 хувь болж өсчээ. Есөн настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2000 онд 93.3 хувь байсан бол 2010 онд 98.5 хувь болж нэмэгдсэн байна.

Бүх насны бүлэгт сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь хот, хөдөөд аль алинд нь ажиглагдаж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор нийт өрхийн тоо 2000 оныхоос 31.9 хувиар өссөний дотор хотын өрх 61.8 хувиар өсч, харин хөдөөгийн өрх 4.3 хувиар буурсан байна. Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод хөдөөнөөс 4.4 дахин олон байна. Энэ нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ хангамж тааруу, хөдөөнөөс шилжин ирэгчид хамаатан сандантайгаа хамт амьдрах нь ихэсч байгаатай холбоотой гэж үзэж байна. Үүний зэрэгцээгээр хотод ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 2.9 дахин өссөнийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм.

Хүн амын гэр бүлийн байдалд гарсан хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 1989-2000 оны тооллого хоорондын хугацаанд нэмэгдэж байсан бол 2010 онд 2000 оноос 1.8 пунктээр буурав. Үүнийг 2007-2008 онуудад төр засгаас залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэрлэх нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Улсын хэмжээнд 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 4.1 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 59.7 мянга буюу 55.2 хувь нь эрэгтэй, 48.4 мянга буюу 44.7 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийн байдлаас үзвэл 80.1 хувь нь ажил эрхлэхгүй байгаагийн дотор эрэгтэйчүүдийн 77.3 хувь, эмэгтэйчүүдийн 83.5 хувь нь ажилгүй юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачилгыг дэмжих замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх, тэдний ахуй нөхцөлийг дээшлүүлэхэд тооллогын дүнд үндэслэсэн гүнзгийрүүлсэн судалгаа хийж, цаашид бодлогоор зохицуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амын 56.4 хувь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2000 оноос 5.5 пунктээр буурсан байна. Мөн насны нийт хүн амын 43.6 хувь ажиллах хүчинд хамаарахгүй байгаа нь өнгөрсөн тооллогынхоос 5.5 пунктээр өссөн байна. Ерөнхийд нь үзвэл хүн амын эдийн засгийн идэвх өнгөрсөн тооллогын үеийнхээс

буурчээ. Эдийн засгийн идэвхгүй хүн ам нийтдээ 830.3 мянга байгаа нь 2000 оныхоос 43.1 хувиар өссөн байна. Энэ тоон дээр ажилгүйчүүд болох 164.1 мянган хүнийг нэмж үзвэл 15, түүнээс дээш насны нийт хүн амын 52.2 хувь буюу 2 хүний нэг нь ажил эрхлэхгүй байна. Тохирох ажил олдохгүй байгаа, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүй хүмүүсийн 13.6-21.9 хувь нь дээд боловсролтой юм. Улсын хэмжээнд ажилгүй байгаа хүмүүсийн дотор 20-34 насныхан 95.1 мянга, 35-44 насныхан 39.2 мянга байгаа нь нийт ажилгүйчүүдийн дийлэнх буюу 81.8 хувь нь 20-44 насныхан байгааг харуулна. Үүний шалтгаан нөхцөлийг нарийвчлан судлах нь энэ асуудлыг хариуцдаг шат шатны төр захиргааны байгууллага, судлаачдын анхаарах асуудал болоод байна.

Хүн ам зүйн ачаалал буурч байгаагийн зэрэгцээгээр хүн амын боловсролын төвшин дээшилж, тус улс эрчимтэй хөгжлийн гараанд ирээд байгаа өнөө үед хүн ам зүйн ийм тааламжтай нөхцөлийг бүрэн дүүрэн ашиглах нь чухал юм. Харин тооллогын дүнгээс үзэхэд хүн амын ажиллах хүчний оролцооны төвшин өмнөх тооллогын үеийнхээс буурч, ажилгүй, тохирох ажил олдохгүй, ажиллах сонирхолгүй хүний нийт тоо нэмэгдсэн зэрэг хүн амын ажил эрхлэлттэй холбогдох сөрөг үзэгдлийн шалтгаан нөхцөлийг нарийвчлан судлах, ажлын байрыг эрчимтэй нэмэгдүүлэх, ялангуяа үйлдвэрлэлд ажиллах мэргэжилтэй ажилтныг олноор бэлтгэх зэрэг арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Манай улсын нийт өрхийн 45.2 хувь нь Монголын ард түмний уламжлалт сууц гэрт, 53.6 хувь нь байшинд, 1.1 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Хотод нийт өрхийн 65.9 хувь байшинд, 32.7 хувь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь буурч, гэрт амьдардаг өрхийнх нэмэгдсэнийг харуулж байна. Энэ нь гол төлөв том хотуудад хөдөөнөөс шилжин ирэгчид ихэнх тохиолдолд гэр хороололд суурьшсантай холбоотой.

Хотын байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 48.8 хувь өссөн боловч гэрт амьдрагчдийн тоо илүү олноор нэмэгджээ. Төв суурин газарт гэрт амьдарч байгаа өрхийн тоо нэмэгдэж байгаагаас агаарын болон орчны бохирдлыг нэмэгдүүлэх, оршин суугчдын эрүүл ахуйн нөхцөл хүндрэх зэрэг сөрөг үзэгдлүүд нэмэгдэж болзошгүй юм.

Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэрээр ангилахад сонирхолтой дүр зураг харагдаж байна. Улсын хэмжээнд нийт өрхийн 13.3 хувь буюу 94.8 мянган өрх өөрийн өмчийн сууцгүй байна. Эдгээрийн 78.4 мянга нь хотын өрхүүд байгаагаас үзэхэд хотынхны орон сууцны хүрэлцээ, хангамж хангалтгүйг харуулж байна. Хөдөөд энэ үзүүлэлт харьцангуй бага байгаа нь орон сууцны хэрэгцээгээ гол төлөв шинэ гэр, байшин барьж хангах боломжтой байдагтай холбоотой.

Таван ханатай гэрт 3-4 ам бүлтэй өрхийн 58.4 хувь нь амьдарч байгаагийн зэрэгцээгээр 7-гоос дээш ам бүлтэй өрхийн 57.9 хувь нь мөн 5 ханатай гэрт амьдарч байгаагаас үзэхэд таван ханатай гэр манай ард түмний хамгийн түгээмэл сууц гэж ойлгогдож байна.

Тоолох үед улсын хэмжээнд 23.2 мянган өрх цахилгаангүй байна. Энд өмнөх тооллогын үеийнхэс 7.6 дахин цөөн болж ихээхэн ахиц гарчээ. Гэвч цахилгаангүй өрхийн тоо нэлээд олон байна. Цахилгаангүй өрхийн 91.3 хувь нь гэрт амьдардаг өрхүүд юм. Гэрт амьдардаг цахилгаангүй өрхийн 78.3 хувь нь хөдөөд оршин суудаг өрхүүд ажээ. Сэргээгдэх эрчим хүч ашигладаг нийт өрхийн 96.7 хувь хөдөө орон нутагт байгаа нь зүй ёсны асуудал бөгөөд цаашид ч ийм төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага их байгааг холбогдох байгууллагууд анхаарах нь зүйтэй.

Байшинд амьдардаг нийт өрхийн 40 хувь 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 14.9 пунктээр буурсан байна. Гэтэл 40-өөс дээш квадрат метр талбайтай байршинд суудаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 46.7 хувь болж, өмнөх тооллогынхоос 2.9 дахин өссөн нь ерөнхийдөө орон сууцны

багтаамж сайжирсан гэж үзэж болох юм. Үүнийг харуулах бас нэг үзүүлэлт нь 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 54.9 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай байранд амьдарч байгаа явдал юм.

Сууцны дотроо бие засах газартай байшинд амьдардаг өрхийн хувь 2000 оноос 4.5 пунктээр буурч, харин сууцны гадна бие засах газартай өрхийн хэмжээ нэмэгджээ. Байшинд амьдардаг нийт өрхийн 42.8 хувь (тусдаа эзэмшдэг 40.6 хувь, нийтээрээ ашигладаг 2.2 хувь) нь онгоц, шүршүүрийн өрөөтэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 0.6 пунктээр буурчээ. Байшинд амьдардаг өрхийн 77.1 хувь үйчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үетэй харьцуулахад ихээхэн дэвшил гарсан аж. 2000 онд байшинд суудаг өрхийн 10 хувь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэг байхгүй байсан бол 2010 онд 5 хувь болтлоо буурчээ.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл хүн амыг цахилгаанаар хангаж, төвлөрсөн болон төвлөрсөн бус байдлаар эрчим хүчний эх үүсвэрийг шийдэх бодлого, хөтөлбөр, хэрэгжүүлсэн нь бодитой үр дүнд хүрсэн боловч хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор нийтийн ариун цэвэр, орчны бохирдолтой холбоотой үзүүлэлтүүдийн хувьд эерэг өөрчлөлт ажиглагдсангүй.

Гэрт амьдардаг нийт өрхийн 25.8 хувийг нь бие засах тодорхой цэггүй байгаагийн дотор энэ үзүүлэлт хотод 4.7 хувь буюу 7.4 мянган өрх байгаа нь анхаарал татаж байна. Хотод бие засах газраа олон өрх дундаа ашигладаг, эсвэл бие засах тогтсон цэг байхгүй байх нь хөрсний бохирдол, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөөр байна. Хотын гэрт амьдардаг нийт өрхийн 9.9 хувь хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй, 18.3 хувь бохир усаа задгай асгаж байгаа нь хот суурингийн оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд тааламжгүй нөлөөлж байгааг хот суурин газрын төр захиргааны байгууллагууд анхаарч, цаашид гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй.

ХАВСРАЛТ



ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМЫН ТОО*, АЙМАГ, НИЙСЛЭЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

БҮГД

Аймаг, нийслэл	Бүгд	Насны бүлэг						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
БҮГД	2 647 545	288 497	216 214	236 865	257 645	292 183	247 983	222 522
Архангай	84 078	9 299	7 693	9 418	7 967	7 428	6 932	6 929
Баян-Өлгий	85 232	11 037	10 383	10 092	8 947	6 832	7 264	6 507
Баянхонгор	75 690	8 606	7 038	8 505	7 134	7 104	6 745	6 391
Булган	53 065	5 836	4 433	5 426	4 212	3 881	4 335	4 513
Говь-Алтай	53 223	5 885	5 252	5 689	4 742	4 701	4 810	4 550
Дорноговь	57 930	6 688	5 116	5 315	4 698	5 780	5 974	5 343
Дорнод	68 873	7 928	5 751	6 207	6 227	6 838	6 433	5 874
Дундговь	38 543	4 285	3 674	4 157	3 242	3 061	3 366	3 230
Завхан	64 924	7 667	6 030	7 182	5 625	4 563	5 482	5 632
Өвөрхангай	100 444	11 482	9 412	11 106	9 123	8 455	8 672	8 274
Өмнөговь	60 855	5 726	4 671	5 236	4 387	6 610	6 988	5 931
Сүхбаатар	51 091	5 400	4 501	5 122	4 463	4 600	4 800	4 720
Сэлэнгэ	95 804	10 588	8 183	9 230	8 039	8 565	8 512	8 001
Төв	83 838	9 388	7 012	7 771	7 071	7 294	7 296	6 990
Увс	72 906	9 201	7 834	8 895	7 454	5 179	5 829	5 537
Ховд	76 252	9 222	7 933	9 132	8 061	6 618	6 079	5 908
Хөвсгөл	114 331	13 220	10 493	11 817	10 335	9 869	9 741	9 542
Хэнтий	65 335	7 454	6 239	6 680	5 619	5 176	5 721	5 643
Дархан-Уул	90 642	9 375	6 735	7 908	10 026	10 110	7 680	7 340
Улаанбаатар	1 154 290	119 637	80 040	82 753	121 019	159 643	116 322	97 609
Орхон	87 118	8 992	6 671	7 939	8 132	8 630	7 757	6 961
Говьсүмбэр	13 081	1 581	1 120	1 285	1 122	1 246	1 245	1 097

* Гадаадад б, түүнээс дээш сарын хугацаагаар суугаа Монгол Улсын харьяат иргэд ороогүй

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Насны бүлэг							
	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
БҮГД	202 383	179 267	158 756	122 082	71 989	49 453	38 232	63 474
Архангай	6 475	5 873	4 873	3 792	2 417	1 586	1 371	2 025
Баян-Өлгий	5 844	4 926	4 098	3 183	1 822	1 299	1 027	1 971
Баянхонгор	5 787	5 097	4 130	3 157	1 788	1 291	1 120	1 797
Булган	4 407	4 122	3 561	3 048	1 818	1 080	898	1 495
Говь-Алтай	4 290	3 766	3 032	2 365	1 314	850	767	1 210
Дорноговь	4 563	3 969	3 513	2 644	1 527	893	640	1 267
Дорнод	5 083	4 498	4 335	3 611	2 130	1 280	936	1 742
Дундговь	2 872	2 574	2 325	1 879	1 097	736	588	1 457
Завхан	5 320	4 817	3 873	2 993	1 630	1 198	1 137	1 775
Өвөрхангай	7 867	7 012	5 826	4 188	2 694	1 898	1 644	2 791
Өмнөговь	5 412	4 853	3 982	2 501	1 331	856	709	1 662
Сүхбаатар	3 982	3 554	3 056	2 541	1 528	873	633	1 318
Сэлэнгэ	7 610	7 164	6 453	5 002	3 017	1 953	1 391	2 096
Төв	6 488	5 917	5 399	4 512	2 815	1 905	1 478	2 502
Увс	5 289	5 202	4 138	3 025	1 651	1 143	1 007	1 522
Ховд	5 506	4 850	4 170	3 085	1 785	1 187	1 002	1 714
Хөвсгөл	9 140	8 192	7 133	5 402	2 993	1 926	1 674	2 854
Хэнтий	4 891	4 503	4 194	3 345	1 976	1 213	921	1 760
Дархан-Уул	6 940	6 372	5 803	4 371	2 591	1 880	1 357	2 154
Улаанбаатар	86 563	74 127	67 613	52 379	31 323	22 676	16 605	25 981
Орхон	7 011	6 957	6 487	4 484	2 410	1 489	1 154	2 044
Говьсүмбэр	1 043	922	762	575	332	241	173	337

ЭРЭГТЭЙ

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Бүгд	Насны бүлэг						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
БҮГД	1 313 968	146 516	110 117	120 064	130 560	147 472	124 490	111 976
Архангай	41 943	4 625	3 904	4 820	4 042	3 718	3 508	3 455
Баян-Өлгий	42 655	5 573	5 239	5 079	4 569	3 483	3 689	3 260
Баянхонгор	38 023	4 425	3 492	4 332	3 841	3 754	3 355	3 224
Булган	27 325	2 961	2 320	2 764	2 348	2 109	2 215	2 342
Говь-Алтай	26 602	2 977	2 688	2 899	2 373	2 417	2 472	2 339
Дорноговь	29 230	3 386	2 530	2 611	2 349	2 991	3 244	2 768
Дорнод	34 796	4 042	2 981	3 127	3 236	3 653	3 333	3 043
Дундговь	19 578	2 221	1 870	2 129	1 753	1 640	1 694	1 654
Завхан	32 544	3 845	3 093	3 712	2 978	2 418	2 756	2 785
Өвөрхангай	50 333	5 892	4 776	5 691	4 796	4 417	4 364	4 133
Өмнөговь	34 884	2 895	2 390	2 668	2 456	4 146	4 218	3 722
Сүхбаатар	26 059	2 729	2 334	2 604	2 423	2 440	2 504	2 509
Сэлэнгэ	48 756	5 422	4 178	4 635	4 344	4 700	4 435	4 171
Төв	43 751	4 867	3 588	3 990	3 944	4 128	3 889	3 711
Увс	36 829	4 675	3 964	4 545	3 880	2 862	3 003	2 812
Ховд	38 006	4 716	4 037	4 629	4 034	3 346	3 139	2 987
Хөвсгөл	56 899	6 650	5 274	5 888	5 436	5 131	4 949	4 779
Хэнтий	33 399	3 817	3 211	3 474	3 093	2 792	2 999	2 883
Дархан-Уул	44 556	4 771	3 439	3 951	5 134	5 115	3 825	3 670
Улаанбаатар	558 247	60 587	40 885	41 840	58 632	77 209	56 452	47 714
Орхон	42 813	4 633	3 364	4 001	4 239	4 323	3 804	3 464
Говьсүмбэр	6 740	807	560	675	660	680	643	551

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Насны бүлэг							
	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
БҮГД	100 819	88 273	77 475	58 009	33 384	22 106	17 262	25 445
Архангай	3 241	2 901	2 488	1 827	1 157	728	659	870
Баян-Өлгий	2 858	2 462	1 993	1 562	843	618	515	912
Баянхонгор	2 856	2 571	2 068	1 486	811	565	502	741
Булган	2 268	2 107	1 801	1 529	920	539	449	653
Говь-Алтай	2 177	1 910	1 512	1 143	603	334	338	420
Дорноговь	2 346	2 010	1 770	1 318	760	430	286	431
Дорнод	2 554	2 226	2 162	1 763	1 039	607	417	613
Дундговь	1 401	1 334	1 199	911	511	349	296	616
Завхан	2 675	2 398	1 921	1 442	723	512	523	763
Өвөрхангай	3 887	3 427	2 888	1 955	1 290	875	755	1 187
Өмнөговь	3 415	3 044	2 400	1 446	674	442	329	639
Сүхбаатар	2 088	1 815	1 560	1 252	721	399	274	407
Сэлэнгэ	3 822	3 491	3 224	2 385	1 497	924	641	887
Төв	3 374	3 050	2 717	2 260	1 424	962	704	1 143
Увс	2 637	2 562	2 090	1 509	800	464	445	581
Ховд	2 693	2 407	2 064	1 502	843	515	442	652
Хөвсгөл	4 533	4 117	3 514	2 596	1 369	821	766	1 076
Хэнтий	2 417	2 252	2 122	1 701	957	587	431	663
Дархан-Уул	3 362	3 074	2 655	2 008	1 189	836	627	900
Улаанбаатар	42 319	35 413	31 885	23 907	13 927	9 829	7 292	10 356
Орхон	3 361	3 248	3 053	2 213	1 172	655	496	787
Говьсүмбэр	535	454	389	294	154	115	75	148

ЭМЭГТЭЙ

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Бүгд	Насны бүлэг						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
БҮГД	1 333 577	141 981	106 097	116 801	127 085	144 711	123 493	110 546
Архангай	42 135	4 674	3 789	4 598	3 925	3 710	3 424	3 474
Баян-Өлгий	42 577	5 464	5 144	5 013	4 378	3 349	3 575	3 247
Баянхонгор	37 667	4 181	3 546	4 173	3 293	3 350	3 390	3 167
Булган	25 740	2 875	2 113	2 662	1 864	1 772	2 120	2 171
Говь-Алтай	26 621	2 908	2 564	2 790	2 369	2 284	2 338	2 211
Дорноговь	28 700	3 302	2 586	2 704	2 349	2 789	2 730	2 575
Дорнод	34 077	3 886	2 770	3 080	2 991	3 185	3 100	2 831
Дундговь	18 965	2 064	1 804	2 028	1 489	1 421	1 672	1 576
Завхан	32 380	3 822	2 937	3 470	2 647	2 145	2 726	2 847
Өвөрхангай	50 111	5 590	4 636	5 415	4 327	4 038	4 308	4 141
Өмнөговь	25 971	2 831	2 281	2 568	1 931	2 464	2 770	2 209
Сүхбаатар	25 032	2 671	2 167	2 518	2 040	2 160	2 296	2 211
Сэлэнгэ	47 048	5 166	4 005	4 595	3 695	3 865	4 077	3 830
Төв	40 087	4 521	3 424	3 781	3 127	3 166	3 407	3 279
Увс	36 077	4 526	3 870	4 350	3 574	2 317	2 826	2 725
Ховд	38 246	4 506	3 896	4 503	4 027	3 272	2 940	2 921
Хөвсгөл	57 432	6 570	5 219	5 929	4 899	4 738	4 792	4 763
Хэнтий	31 936	3 637	3 028	3 206	2 526	2 384	2 722	2 760
Дархан-Уул	46 086	4 604	3 296	3 957	4 892	4 995	3 855	3 670
Улаанбаатар	596 043	59 050	39 155	40 913	62 387	82 434	59 870	49 895
Орхон	44 305	4 359	3 307	3 938	3 893	4 307	3 953	3 497
Говьсүмбэр	6 341	774	560	610	462	566	602	546

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Насны бүлэг							
	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
БҮГД	101 564	90 994	81 281	64 073	38 605	27 347	20 970	38 029
Архангай	3 234	2 972	2 385	1 965	1 260	858	712	1 155
Баян-Өлгий	2 986	2 464	2 105	1 621	979	681	512	1 059
Баянхонгор	2 931	2 526	2 062	1 671	977	726	618	1 056
Булган	2 139	2 015	1 760	1 519	898	541	449	842
Говь-Алтай	2 113	1 856	1 520	1 222	711	516	429	790
Дорноговь	2 217	1 959	1 743	1 326	767	463	354	836
Дорнод	2 529	2 272	2 173	1 848	1 091	673	519	1 129
Дундговь	1 471	1 240	1 126	968	586	387	292	841
Завхан	2 645	2 419	1 952	1 551	907	686	614	1 012
Өвөрхангай	3 980	3 585	2 938	2 233	1 404	1 023	889	1 604
Өмнөговь	1 997	1 809	1 582	1 055	657	414	380	1 023
Сүхбаатар	1 894	1 739	1 496	1 289	807	474	359	911
Сэлэнгэ	3 788	3 673	3 229	2 617	1 520	1 029	750	1 209
Төв	3 114	2 867	2 682	2 252	1 391	943	774	1 359
Увс	2 652	2 640	2 048	1 516	851	679	562	941
Ховд	2 813	2 443	2 106	1 583	942	672	560	1 062
Хөвсгөл	4 607	4 075	3 619	2 806	1 624	1 105	908	1 778
Хэнтий	2 474	2 251	2 072	1 644	1 019	626	490	1 097
Дархан-Уул	3 578	3 298	3 148	2 363	1 402	1 044	730	1 254
Улаанбаатар	44 244	38 714	35 728	28 472	17 396	12 847	9 313	15 625
Орхон	3 650	3 709	3 434	2 271	1 238	834	658	1 257
Говьсүмбэр	508	468	373	281	178	126	98	189

ХҮСНЭГТ 1А. МОНГОЛ УЛСЫН ХОТЫН СУУРИН ХҮН АМЫН ТОО*, АЙМАГ, НИЙСЛЭЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

БҮГД

Аймаг, нийслэл	Бүгд	Насны бүлэг						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
БҮГД	1 798 147	188 882	133 740	143 846	188 334	221 784	171 685	149 461
Архангай	20 619	1 988	1 621	1 949	2 641	2 489	1 556	1 480
Баян-Өлгий	30 663	3 580	3 363	3 455	3 385	2 586	2 626	2 322
Баянхонгор	29 829	3 272	2 560	3 026	3 306	2 848	2 631	2 462
Булган	14 116	1 426	1 073	1 282	1 354	1 080	1 131	1 058
Говь-Алтай	17 962	1 768	1 531	1 738	2 151	1 877	1 538	1 406
Дорноговь	33 932	3 912	2 851	2 918	3 048	3 622	3 534	3 151
Дорнод	38 615	4 461	3 180	3 409	3 823	3 828	3 460	3 184
Дундговь	13 664	1 483	1 183	1 335	1 462	1 092	1 143	1 057
Завхан	17 485	1 894	1 459	1 697	2 059	1 424	1 357	1 390
Өвөрхангай	38 027	4 053	3 252	3 982	3 991	3 179	3 129	2 967
Өмнөговь	18 781	2 093	1 552	1 792	1 766	1 804	1 847	1 557
Сүхбаатар	16 150	1 670	1 257	1 327	1 580	1 568	1 463	1 421
Сэлэнгэ	47 008	5 010	3 846	4 273	4 027	4 309	4 137	3 876
Төв	13 339	1 353	1 010	1 113	1 368	1 312	1 148	1 047
Увс	27 178	3 179	2 576	2 995	3 377	1 992	2 087	2 003
Ховд	29 046	3 090	2 615	3 128	4 000	3 215	2 158	2 066
Хөвсгөл	38 443	4 161	3 274	3 768	3 633	3 318	3 137	3 188
Хэнтий	30 086	3 426	2 789	3 004	2 858	2 395	2 544	2 633
Дархан-Уул	74 985	7 563	5 457	6 316	8 717	8 884	6 316	6 005
Улаанбаатар	1 154 290	119 637	80 040	82 753	121 019	159 643	116 322	97 609
Орхон	84 187	8 697	6 425	7 642	7 861	8 409	7 534	6 765
Говьсүмбэр	9 742	1 166	826	944	908	910	887	814

* Гадаад 6, түүнээс дээш сарын хугацаагаар суугаа Монгол Улсын харьяат иргэд ороогүй

Хүснэгт 1А-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Насны бүлэг							
	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
БҮГД	136 034	120 105	108 736	83 084	49 342	34 724	26 004	42 386
Архангай	1 409	1 408	1 229	920	628	424	364	513
Баян-Өлгий	2 287	1 970	1 719	1 296	683	456	345	590
Баянхонгор	2 270	1 949	1 677	1 257	717	558	472	824
Булган	1 082	1 115	1 039	840	572	313	311	440
Говь-Алтай	1 336	1 299	1 154	826	475	276	222	365
Дорноговь	2 642	2 333	2 085	1 507	854	495	338	642
Дорнод	2 815	2 466	2 379	2 002	1 189	770	580	1 069
Дундговь	932	927	884	721	399	285	197	564
Завхан	1 378	1 330	1 106	828	422	331	321	489
Өвөрхангай	3 049	2 763	2 237	1 567	1 058	821	743	1 236
Өмнөговь	1 355	1 334	1 107	799	478	335	262	700
Сүхбаатар	1 200	1 161	1 007	886	596	353	219	442
Сэлэнгэ	3 814	3 552	3 204	2 544	1 559	1 006	715	1 136
Төв	974	956	861	729	446	295	232	495
Увс	1 906	2 001	1 725	1 248	663	444	402	580
Ховд	2 094	1 858	1 639	1 114	639	462	359	609
Хөвсгөл	3 341	2 877	2 530	1 860	1 105	709	587	955
Хэнтий	2 312	2 076	1 912	1 503	879	582	421	752
Дархан-Уул	5 718	5 236	4 761	3 539	2 100	1 535	1 079	1 759
Улаанбаатар	86 563	74 127	67 613	52 379	31 323	22 676	16 605	25 981
Орхон	6 778	6 691	6 297	4 300	2 309	1 410	1 102	1 967
Говьсүмбэр	779	676	571	419	248	188	128	278

ЭРЭГТЭЙ

Хүснэгт 1А-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Бүгд	Насны бүлэг						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
БҮГД	872 989	95 671	68 119	72 244	92 124	107 751	83 922	73 525
Архангай	9 572	932	835	991	1 098	968	753	709
Баян-Өлгий	15 041	1 777	1 713	1 726	1 692	1 217	1 323	1 146
Баянхонгор	14 518	1 702	1 272	1 447	1 618	1 436	1 276	1 242
Булган	7 034	715	548	613	730	552	554	535
Говь-Алтай	8 502	911	780	871	953	797	725	691
Дорноговь	16 756	2 011	1 422	1 426	1 428	1 761	1 876	1 587
Дорнод	18 667	2 264	1 649	1 662	1 869	1 847	1 698	1 587
Дундговь	6 787	758	610	640	776	560	570	531
Завхан	8 386	916	721	854	1 039	686	633	642
Өвөрхангай	18 559	2 077	1 673	2 034	1 989	1 530	1 506	1 417
Өмнөговь	9 374	1 045	817	877	958	960	913	810
Сүхбаатар	8 041	825	663	646	806	790	760	766
Сэлэнгэ	23 365	2 570	1 967	2 117	2 072	2 274	2 129	1 978
Төв	6 586	697	498	584	723	704	567	525
Увс	13 378	1 637	1 263	1 542	1 625	1 027	1 045	1 006
Ховд	13 841	1 578	1 297	1 565	1 826	1 409	1 085	1 042
Хөвсгөл	18 580	2 016	1 645	1 844	1 770	1 640	1 523	1 596
Хэнтий	14 957	1 781	1 421	1 503	1 482	1 249	1 294	1 291
Дархан-Уул	36 549	3 818	2 794	3 144	4 434	4 441	3 099	2 960
Улаанбаатар	558 247	60 587	40 885	41 840	58 632	77 209	56 452	47 714
Орхон	41 250	4 458	3 230	3 827	4 073	4 196	3 688	3 349
Говьсүмбэр	4 999	596	416	491	531	498	453	401

* Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар суугаа Монгол Улсын харьяат иргэд ороогүй

Хүснэгт 1А-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Насны бүлэг							
	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
БҮГД	66 149	57 388	51 528	38 547	22 373	15 234	11 578	16 836
Архангай	666	703	605	418	296	199	181	218
Баян-Өлгий	1 065	993	784	631	346	205	178	245
Баянхонгор	1 073	961	801	583	318	239	210	340
Булган	544	546	516	411	272	159	155	184
Говь-Алтай	636	599	576	416	209	122	99	117
Дорноговь	1 318	1 122	1 034	736	424	242	163	206
Дорнод	1 333	1 135	1 129	949	552	351	256	386
Дундговь	450	430	445	351	186	139	106	235
Завхан	667	629	530	403	179	135	144	208
Өвөрхангай	1 491	1 328	1 069	719	484	374	337	531
Өмнөговь	655	632	535	395	220	162	115	280
Сүхбаатар	616	558	492	426	285	168	98	142
Сэлэнгэ	1 843	1 696	1 526	1 174	766	470	312	471
Төв	460	442	398	337	210	135	94	212
Увс	936	961	845	608	315	168	176	224
Ховд	979	874	800	538	288	186	152	222
Хөвсгөл	1 602	1 404	1 222	866	496	310	277	369
Хэнтий	1 096	1 007	938	743	407	256	203	286
Дархан-Уул	2 752	2 508	2 161	1 599	952	666	500	721
Улаанбаатар	42 319	35 413	31 885	23 907	13 927	9 829	7 292	10 356
Орхон	3 243	3 124	2 953	2 127	1 120	630	475	757
Говьсүмбэр	405	323	284	210	121	89	55	126

ЭМЭГТЭЙ

Хүснэгт 1А-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Бүгд	Насны бүлэг						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
БҮГД	925 158	93 211	65 621	71 602	96 210	114 033	87 763	75 936
Архангай	11 047	1 056	786	958	1 543	1 521	803	771
Баян-Өлгий	15 622	1 803	1 650	1 729	1 693	1 369	1 303	1 176
Баянхонгор	15 311	1 570	1 288	1 579	1 688	1 412	1 355	1 220
Булган	7 082	711	525	669	624	528	577	523
Говь-Алтай	9 460	857	751	867	1 198	1 080	813	715
Дорноговь	17 176	1 901	1 429	1 492	1 620	1 861	1 658	1 564
Дорнод	19 948	2 197	1 531	1 747	1 954	1 981	1 762	1 597
Дундговь	6 877	725	573	695	686	532	573	526
Завхан	9 099	978	738	843	1 020	738	724	748
